



Австралийн
Засгийн газар



Нээлтэй
Нийгэм Форум



“Глоб Интернэшнл”
ТББ

Хүний эрх НҮБ Сэтгүүлч

Сэтгүүлчдэд зориулсан гарын авлага

Улаанбаатар хот
2010 он

Энэ гарын авлагыг “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага Австралийн Засгийн газрын Хүний эрхийн жижиг тэтгэлгийн хөтөлбөр, ННФ-ын дэмжлэгтэйгээр “UPR-ийг мэдээлэл, сурталчилгаагаар хангах нь” төслийн хүрээнд бэлтгэв.

Хэвлэлд бэлтгэсэн:

Б.Хишигсайхан, НҮБХХ-ийн ХЗҮХХЭТ-ийн зөвлөх,
хүний эрхийн хуулийн магистр

Д.Эрдэнэчимэг, “Хүний эрх хөгжил” төвийн хөтөлбөрийн
зохицуулагч, өмгөөлөгч, хууль зүйн магистр

Хянан тохиолдуулсан:

С.Цэрэндорж, Хууль зүйн ухааны доктор /Ph.D/

© “Глоб Интернэшнл” ТББ

Гарын авлагыг хэсэгчлэн болон бүтнээр нь дахин хэвлэхийг хүсвэл “Глоб Интернэшнл” ТББ-аас зөвшөөрөл авна уу.

“Импресс”ХХК-ны Хэвлэх үйлдвэрт хэвлэв.

Гарчиг

Бүлэг I. Хүний эрхэд суурилсан хандлага ба хэвлэл мэдээллийн хэрэгсэл	6
1. Хүний эрхийн тухай ойлголт, ангилал, сэтгүүлчид хүний эрхийн асуудлаар хэвлэн нийтлэхэд анхаарах зарим асуудал	6
1.1 Хүний эрхийн тухай ойлголт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн гүйцэтгэх үүрэг	6
1.2 Хүний эрхийн ангилал	8
1.2.1. Иргэний, улс төрийн эрх	9
1.2.2. Эдийн засаг, нийгэм, соёлын эрх	10
1.2.3. Гурав дахь үеийн эрхүүд	11
1.3 Сэтгүүл зүйд анхаарвал зохих хүний эрхийн зарим асуудал	11
2. Хүний эрхэд суурилсан хандлага	14
2.1 Хүний эрхэд суурилсан хандлага гэж юу вэ?	14
2.2 Эрхэд суурилсан хандлагад баримтлах зарчмууд	15
3. Сэтгүүл зүй дэх хүний эрхэд суурилсан хандлага	17
3.1. Хүний эрхийн хэм хэмжээ хоорондын уялдаа холбоо	18
3.2. Үл ялгаварлан гадуурхах	18
3.3. Хариуцлагатай байдал	19
3.4. Оролцоо	20
3.5. Эрх зүйн чадавх	20
Бүлэг II. UPR ба НҮБ-ийн хүний эрхийн бусад механизм, хэвлэл мэдээллийн үүрэг	21
1. НҮБ-ийн хүний эрхийн механизм, бүтэц, ерөнхий ойлголт	21
1.1 Хүний эрхийн Зөвлөл	23
1.1.1 Хүний эрхийн зөвлөлийн тусгай хэрэгслүүд	27
1.2 Гэрээний хороод	30
1.3 Хүний эрхийн дээд комиссарын газар	33
1.4 НҮБ-ын хүний эрхийн механизмтай иргэний нийгмийн байгууллагууд хэрхэн хамтран ажиллаж болох вэ?	36

2. UPR буюу Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт, хэлэлцүүлэг	37
2.1 UPR-ийн тухай ойлголт, ач холбогдол	37
2.2 UPR-ийг хэн явуулах вэ?	38
2.3 Монгол улс хэлэлцүүлэгт хэзээ орох вэ?	38
2.4 UPR юунд үндэслэх вэ?	39
2.5 UPR дахь төрийн бус байгууллагууд, хэвлэл мэдээллийнхний үүрэг	40
2.5.1 Илтгэл бэлтгэн илгээх шатанд	41
2.5.2 UPR-ийн ажлын хэсгийн хуралдааны үеэр.....	44
2.5.3 Ажлын хэсгийн хуралдаанаас Хүний эрхийн зөвлөлийн Бүгд хуралдаан хүртэл (2010.11.23 - 2011.03 сар)	45
2.5.4 UPR-ын дараа	45
2.5.5 НҮБ-ийн Хүний эрхийн зөвлөл дээрх UPR-ийн хэлэлцүүлгийг хэрхэн сурвалжлах вэ?	46
Хавсралт	49
Товчилсон үг	49
Хүний эрхийн олон улсын гол гэрээ, конвенцууд	50
Хүний эрхийн түгээмэл тунхаглал	51
Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт	60
Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт	87
Цөөнхийн эрхийн асуудал	102
Нэр томъёоны тайлбар	109

Өмнөтгөл

Эрхэм сэтгүүлч Таны амрыг айлтгая.

Монгол улс Хүний эрхийг дээдлэн хэрэгжүүлэх талаар Нэгдсэн Үндэстний байгууллагын өмнө гэрээ, баримтаар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж буйг дүгнэн үзэх чухал мөч ирээд байна. 2010 оны 11-р сарын 23-нд Монгол Улс НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд хүний эрхийн төлөв байдлын тухай Үндэсний илтгэлээ тавьж хэлэлцүүлнэ. Үүний дараа НҮБ-ын өгсөн зөвлөмжийн дагуу дараагийн тайлангийн хугацаа хүртэлх 4 жилийн туршид хүний эрхийг хангах олон талт ажлууд хийх юм. Энэхүү тасралтгүй үргэлжлэх үйл ажиллагааны талаар сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд иргэдэд байнга мэдээлж, эрхээ эдэлж, элбэг жаргалтай амьдрахад нь туслах ёстой буйзаа.

Таны, миний, андын, аав ээж, ах дүүсийн, ард иргэдийн эрх хэрхэн хангагдсан бэ? Монгол улсын иргэн хүний эрхээ бүрэн дүүрэн эдэлж чадаж байна уу, төр засгаас иргэнийхээ эрхийг хангах ямар үйл ажиллагаа явуулах ёстой вэ гэдэг асуудал сэтгүүлч та бүхний ажил, бүтээлийн томоохон хэсэг байх бизээ.

Хүний эрхийг хангасан, иргэнээ дээдэлсэн улс гүрэн болоход сэтгүүлч та бидний үүрэг нэн чухал билээ. Энэ үүргээ амжилттай биелүүлэхэд тань тус болуужин хэмээн энэхүү гарын авлагыг бэлтгэхдээ НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн тайлант механизмууд, хүний эрхийн холбогдох баримт бичгүүд, хүний эрхийн талаар бичихэд анхаарах зүйлүүдийг нэгтгэн оруулсан болно.

Эл багахан ном хүний эрхийн талаар цаашид бичих олон сайхан зохиол, нийтлэл, нэвтрүүлэгтээ ашиглах чухал нэгэн эх сурвалж болно гэж итгэж байна.

Таны бийр үзэг тань хурц, билэг оюун тань гэгээн байх болтугай.

Бүлэг I. Хүний эрхэд суурилсан хандлага ба хэвлэл мэдээллийн хэрэгсэл

Бүлгийн товч танилцуулга

Дөрөв дэх засаглал хэмээн хүлээн зөвшөөрөгддөг хэвлэл мэдээллийн салбар бол олон нийтэд хүрэх, айл бүрт нэвтрэх хамгийн хүчирхэг хэрэгсэл яах аргагүй мөн билээ. Тиймээс олон нийтийг гэгээрүүлэх, тэдэнд эрх зүйн болон хүний эрхийн боловсрол түгээхээр зорин ажиллаж буй хүмүүст хэвлэл мэдээллийн хэрэгсэл хамгийн ойр түнш юм. Тус гарын авлагыг НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн цоо шинэ хяналтын механизм болох UPR буюу “Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг”-т явуулах Монгол Улсын Үндэсний илтгэл болон бусад оролцогчид, НҮБ-ын гэрээний байгууллагууд, төрөлжсөн агентлагуудын нэмэлт мэдээлэлд хийх хяналт, шалгалтын үйл явцыг олон нийтэд нээлттэйгээр мэдээлэх гол үүргийг гүйцэтгэх сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслийн ажилтнуудад зориулав. Дараагийн бүлэгт UPR болон НҮБ-ын хүний эрхийн хяналтын механизмуудын талаар дэлгэрэнгүй тайлбарласан тул энэ бүлэгт сэтгүүлчид хүний эрхийн асуудлыг олон нийтэд мэдээлэхдээ баримтлах зарчим, анхаарвал зохих асуудлыг илүүтэй тусгалаа.

1. Хүний эрхийн тухай ойлголт, ангилал, сэтгүүлчид хүний эрхийн асуудлаар хэвлэн нийтлэхэд анхаарах зарим асуудал

1.1 Хүний эрхийн тухай ойлголт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн гүйцэтгэх үүрэг

Эртний Грек, Ромын философчид анх “...хүн бүр суурь эрх, эрх чөлөөтэй...” хэмээн томъёолсон ч энэ үзэл баримтлалыг дэлхийн бүх л улс оронд түгээн тараахад багагүй хугацаа шаардагджээ. Тухайлбал, “хүний эрх” хэмээх ойлголт нь Европын зарим хэсэгт 17, 18-р зуунд орж ирсэн бол дөнгөж 20-р зууны 2-р хагасаас л дэлхий нийтэд түгээмэл хэрэглэгдэх болсонд дэлхийн 1, 2-р дайны сургамж, үр дагавар маш хүчтэй түлхэц болжээ. Хүн төрөлхтөний

түүхэнд анх удаа хүний эрхийг олон улсын хэмжээнд цогцоор нь тунхагласан түүхэн чухал баримт бичиг болох Хүний эрхийн түгээмэл тунхаглал /ХЭТТ/-д “Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна.”¹ хэмээн суурийг тавьсан. Хүн аливаа эрхээ хүйс, арьсны өнгө, яс үндэс, хэл, нас, шашин шүтлэг, үзэл бодол, нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн байдал, хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг баримжаа болон бусад байдлаар алагчлагдахгүйгээр эдлэх ёстой болохыг ХЭТТ болон үүний дараагаар батлагдсан хүний эрхийн олон гэрээ, баримт бичгээр баталгаажуулсан юм.

Хүний эрх салшгүй байх нь Хүний эрхийн нэг чухал зарчим бөгөөд хэнээс ч эрхийг нь салгах, булаах эсвэл зөрчих ёсгүй. Нөгөө талаас хүний эрх нь хуваагдашгүй бөгөөд тэдгээрийг эрэмбэлэх ёсгүй юм. Хүйтэн дайны үед социалист, капиталист лагерийнхан хүний аль нэг бүлэг эрхийг илүү чухал хэмээн ялгавартай ханддаг байсан бол өнөө үед олон улсын хамтын нийгэмлэгийн хэмжээнд буруушаан үзэх болсон билээ.

Хүний эрхүүд нь хуваагдашгүй байхын зэрэгцээ хоорондоо харилцан хамааралтай. Тухайлбал, хүүхдээр тэвчишгүй хэлбэрийн хүнд хүчир хөдөлмөр хийлгэснээр зөвхөн хөдөлмөр эрхлэх эрхийг нь зөрчөөд зогсохгүй тэдний хөгжих, сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалуулах зэрэг бусад олон эрх давхар зөрчигддөг. Тиймээс хүний нэг л эрх зөрчигдөж байна хэмээн хайхрамжгүй хандах бус зөрчигдсөн бусад эрхийг сэргээн эдлүүлэх чиглэлээр шуурхай ажиллах ёстой. Цаашлаад хүн бүр чөлөөтэй, идэвхтэй, утга агуулга дүүрэн оролцоотой байх замаар нийгэм, соёл, эдийн засаг, улс төрийн хөгжлийн үр шимээс хүртэх эрхтэй билээ. Энэ нь зүгээр хэлбэр төдий оролцоо биш “утга агуулга бүхий оролцоо” гэдгийг онцгой анхаарах шаардлагатай юм.

Үйлчилгээ, мэдээлэл, хөдөлмөрийн салбар дахь даяаршлаас үүдэн хэвлэл мэдээлэл нь харилцаа холбооны салбарт тун чухал үүрэг гүйцэтгэх болж буй эрин үед дэлхийд болж буй үйл явдлыг түргэн шуурхай мэдээлэх, мэдээллийг харилцан солилцох үйл явцад сэтгүүлчид онцгой үүрэг гүйцэтгэж байна. Сэтгүүлчид ямар

¹ *Хүний эрхийн түгээмэл тунхаглал, НУБ-ын Ерөнхий Ассамблей, 1948 он, 1-р зүйл*

асуудлыг, аль өнцгөөс нь, хэр их нухацтай авч үзэхийг өөрсдөө тодорхойлох эрхтэй байдгаараа аливаа асуудлын талаарх олон нийтийн үзэл бодолд маш хүчтэй нөлөөлдөг.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчид нь олон нийтэд мэдээлэл хүргэх, бид бүхнийг алслагдсан газар нутаг болон дэлхийтэй холбох, хүн төрөлхтөний мэдлэг, оюуныг тэлэхэд онцгой хувь нэмэр оруулдаг гэдэгтэй хэн ч маргахгүй. Нөгөө талаас сэтгүүлчид нь олон нийтийн мэдээллийн хэрэгслийн эх сурвалжид хамгийн ойр байдгийн хувьд аливаа зүйлийн талаар зөвхөн мэдээлэх биш, мөн тухайн асуудалд ул суурьтай дүгнэлт хийх боломжтой.

Сэтгүүлчид хүмүүст эрхийнх нь талаар боловсрол олгох, хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих, хүний эрхийн тулгамдсан асуудлыг олон нийтэд дэлгэн тавих зэргээр хүний эрхийн салбарт үнэтэй хувь нэмэр оруулдаг. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийгэмд гүйцэтгэж буй эдгээр олон чухал хувь нэмрийн дүнд идэвхтэй, мэдээлэлтэй, эрхээ шаардах чадвартай иргэд олноор бий болох боломжтой юм.

1.2 Хүний эрхийн ангилал

Хүний эрхийг иргэний, улс төрийн, эдийн засаг, нийгэм, соёлын болон гурав дахь үеийн эрхүүд хэмээн ангилдаг. Энэ нь төдийлөн чухал ач холбогдолтой биш хэдий ч хүний эрхийн тухай илүү ихийг мэдэхэд дөхөм болно. Тухайлбал, иргэний, улс төрийн эрхүүд нь сөрөг эрх ч хэмээн нэрлэгддэгээс гадна хүн эдгээр эрхээ эдлэхэд төр хөндлөнгөөс оролцохыг хориглож, зөрчсөн тохиолдолд нэн даруй сэргээн эдлүүлэхийг шаарддаг зэргээрээ онцлог юм. Тэгвэл эдийн засаг, нийгэм, соёлын эрх буюу эерэг эрх хэмээн нэрлэгддэг бүлэг эрх нь эрхийг дэвшилттэйгээр хэрэгжүүлэх, боломжит нөөцийн хэрээр эдлүүлэх гэх мэт илүү сул зохицуулалттай. Гурав дахь үеийн эрх нь аливаа хувь хүн, бүлэгт хамаарахаасаа илүүтэй хамтын, нийтлэг гэх утгыг агуулж байдаг. Жишээ нь, бид агаарын бохирдлын тухай ярихдаа зөвхөн монголчууд эсвэл иргэн Д-ийн эрх зөрчигдөж байгаа гэхээсээ тухайн орон нутагт амьдарч буй бүх хүмүүст хамааруулан авч үздэг.

1.2.1. Иргэний, улс төрийн эрх

Иргэний, улс төрийн эрхүүд нь ХЭТТ-ийн 2-18-р зүйлд тусгагдсан бөгөөд эдгээр эрхийг хүний хамгийн суурь эрхүүд хэмээн үздэг.

Үүнд:

- амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх
- боолчлолоос ангид байх
- эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцахаас ангид байх
- Хаана ч байсан эрх зүйн чадвартай байх эрхээ хүлээн зөвшөөрүүлэх
- хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчлалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах
- Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр сэргээн тогтоолгох эрхтэй.
- хэнийг ч дур мэдэн баривчлах, саатуулах буюу хөөн зайлуулах ёсгүй.
- хараат бус, тал хардаггүй шүүхээр бүрэн адил тэгш үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх
- гэм буруутайг нь хуулийн дагуу тогтоох хүртэл гэм буруугүйд тооцогдох, тухайн үед гэмт хэрэгт эс тооцож байсан аливаа үйлдэл, эс үйлдэхүйн төлөө хэнийг ч шийтгэх ёсгүй.
- хэнийг ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, нэр төр, алдар хүндэд нь халдах ёсгүй.
- улсынхаа дотор чөлөөтэй зорчих, амьдран суух газраа чөлөөтэй сонгох
- хэн боловч мөрдөлт, мөшгөлтөөс зугтаж, өөр улсад орогнох боломжийг эрэлхийлэх болон орогнох эрхтэй.
- хүн бүр иргэний харьяалалтай байх.
- сайн дурын үндсэн дээр гэрлэх, өрх тусгаарлах эрхтэй.
- өмчтэй байх
- чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, эс шүтэх
- үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх
- чөлөөтэй хуран цуглах, эвлэлдэн нэгдэх
- улсаа удирдахад шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчөөрөө уламжлан оролцох

Хэвлэн нийтлэх, үзэл бодлоо илэрхийлэхдээ хувь хүний нэр төр, эрхэм зэрэгт хүндэтгэлгүй хандах, гүтгэн доромжлох, аливаа нийгмийн цөөнх болсон бүлгийг буруушаасан, үзэн ядсан, хүний эрхийн суурь зарчмыг гажуудуулсан зэрэг алдааг гаргахгүй байх үүргийг сэтгүүлчид хүлээдэг. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх болон мэдээллийн эрх чөлөө байхгүй бол сэтгүүл зүй болон хэвлэл мэдээлэл оршин тогтнох аргагүй билээ.

1.2.2. Эдийн засаг, нийгэм, соёлын эрх

ХЭТТ-ийн 22-27-р зүйлд эдийн засаг, нийгэм, соёлын эрхүүдийг тусгасан. Үүнд: Адил хэмжээний хөдөлмөрт адил хөлс авах, ажил хөдөлмөр эрхэлж байгаа хэн боловч хувийн болон ам бүлийнхээ ахуй амьжиргааг хүний зэрэгтэй авч явахад хүрэлцэхүйц хөлс авах, сурч боловсрох, нийгэм соёлынхоо амьдралд чөлөөтэй оролцох, эрүүл мэндээ хамгаалуулах зэрэг олон эрхүүд багтдаг.

Эдгээр бүлэг эрх нь “дэвшилттэйгээр хэрэгжүүлэх”, аливаа төрөөс эрхийг нь бүрэн эдлүүлэхийн төлөө “боломжит бүх нөөцөө дээд зэргээр” ашиглахыг шаарддагаараа онцлог. Хэрвээ оролцогч улс нь хязгаарлагдмал нөөцтэй бол боломжит нөөцийнхөө хүрээнд чадах бүхнээ хийх үүргийг хүлээсэн гэсэн үг юм.

Гэвч маш олон засгийн газрууд эдийн засаг, нийгэм, соёлын эрхэд иргэний, улс төрийн эрхийн хэрэгжилтэд тавьдгаасаа бага анхаарал хандуулдаг. Өмнө дурьдсанчлан эрхүүд нь хоорондоо харилцан хамааралтай байдаг тул аль нэг эрх хэрэгжихгүй байгаа нь нөгөө эрхийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлдөг. Тухайлбал, амьдрах, эрх чөлөөтэй байх, аюулгүй байдлаа хангуулах эрх нь иргэдийн эдийн засгийн эрхийн хэрэгжилтээс бүрэн хамаарах нь тодорхой. Төр өөрт байгаа хязгаарлагдмал нөөцөө эдийн засаг, нийгэм, соёлын эрхүүдийг хэрэгжүүлэхэд оновчтой хуваарилах шаардлагатай. Манай улсад сонгуулийн амлалт биелүүлэх нэрээр хөрөнгийг үр ашиггүй зарцуулж, утга агуулгагүйгээр үрэх явдал түгээмэл байна. Тиймээс эдгээр бүлэг эрхийг хэрэгжүүлэхэд баримтлах дээрх зарчмуудын хүрээнд үзвэл Монгол улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ тун хангалтгүй биелүүлж байна.

1.2.3. Гурав дахь үеийн эрхүүд

Эдгээр бүлэг эрхийг заримдаа хамтын эрх хэмээн нэрлэх явдал байдаг. Гурав дахь үеийн эрхүүд нь 1970-аад оноос анх томъёологдож эхэлсэн бөгөөд маш өргөн хүрээний эрхүүд багтдаг.

Үүнд:

- Өөртөө засан тогтнох эрх
- Эдийн засаг, нийгмийн хөгжих эрх
- Хүн төрөлхтөний түгээмэл өвд оролцох болон түүнээс ашиг шим хүртэх эрх
- Энх тайван байх эрх
- Эрүүл, тогтвортой хүрээлэн буй орчны эрх

Эдгээр бүлэг эрхийн талаар НҮБ-ын Ерөнхий ассамблейгаас баталсан хэд хэдэн хөтөлбөр, тунхаглал байдаг ч заавал биелүүлэх хэм хэмжээ бүхий баримт бичиг хараахан гараагүй байна.

1.3 Сэтгүүл зүйд анхаарвал зохих хүний эрхийн зарим асуудал

Сэтгүүлчид нийгмийн аливаа асуудлаар бичихэд хүссэн хүсээгүй хүний эрхийн асуудлуудтай тулгарна. Аливаа нийгэмд хүнээс тусдаа асуудал гэж үгүй. Тиймээс сурч боловсрох, сонгох зэрэг тодорхой эрхүүд, эрүүл, аюулгүй орчин, хөгжих зэрэг хамтын эрх эсвэл хүүхэд, цөөнх гэх мэт бүлгийн асуудлаар нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэн, цацах тохиолдолд тухайн асуудлаар батлагдсан үндэсний хууль тогтоомж, олон улсын гэрээ конвенцийг сайн судалбал зохино. Тухайлбал, жендэрийн асуудлаар нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэх бол жендэрт суурилсан тэгш бус байдал нь бусад хүчин зүйлүүдэд хэрхэн нөлөөлж буйд сэтгүүлчид анхаарал хандуулах ёстой. Эмэгтэйчүүд нас, эдийн засгийн байдал, эрүүл мэнд, үндэстэн, угсаатны байдлаасаа болж тэгш бус хандлагын хохирогч болох нь элбэг байдаг. Хэрвээ тэгш бус байдлын тухай асуудалд анхаарал хандуулах гэж байгаа бол аливаа тоон болон чанарын мэдээнд дүн шинжилгээ хийх зайлшгүй шаардлагатай. Түүгээр ч зогсохгүй тухайн бүлэгт хэвлэл мэдээллийн хэрэгслээр өөрсдийн

эрхийн асуудлаар ярих боломжийг олгох ёстой. Ингэснээр тэгш бус байдлын эсрэг илүү үнэлэхүйц мэдээллийг олон нийтэд хүргэнэ. Харин хүүхдийн эрхийн асуудлаар нийтэлж, нэвтрүүлэх тохиолдолд хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалахад илүүтэй анхаарах шаардлагатай. Үүний тулд хүүхдийн хувийн мэдээлэл, нүүр царайг нууцлахыг шаарддаг бөгөөд энэ нь тэдний одоогийн болон ирээдүйн амьдралд аюул занал, таагүй байдал учрахаас сэргийлж байгаа явдал юм. Гэтэл хэвлэл мэдээллийн хэрэгслүүд гэмт хэрэг, зөрчилд холбогдсон хүүхдийг ямар нэг нууцлалгүйгээр гэрэл зургийг нь нийтэлж, телевизээр гаргах нь энгийн үзэгдэл болоод байна. .

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн шууд болон шууд бусаар ялгаварлан гадуурхагдах явдал нэн түгээмэл байгаа өнөө үед хэвлэл мэдээллийн хэрэгслийн гүйцэтгэх үүрэг асар их. Эхний ээлжид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар буруу нэр томъёо хэрэглэхээс татгалзах, нөгөө талаас олон нийтэд зөв нэр томъёог хэрэглэж сурахад нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл онцгой үүрэг гүйцэтгэх ёстой. Жишээлбэл, “тахир дутуу”, “сохор”, “хараагүй”, “дүлий” зэрэг олон буруу нэр томъёо өнөөдөр өргөн хэрэглэгдэж байна.

Дараагийн ээлжинд нийгэмд тогтсон буруу хандлага буюу “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бол нийгмийн халамж хүртэгч объект” хэмээх ойлголтыг өөрчилж “эрх эдлэгч, баялаг бүтээгч” болохыг нотлон харуулах, түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр гарсан олон улсын, үндэсний хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, энэ нь тэдэнд хүртээмжтэй байж чадаж буй эсэхэд анхаарал хандуулах ад анхаарал хандуулах шаардлагатай. Тухайлбал, хүнд хэлбэрийн тулгуур эрхтэний бэрхшээлтэй, нуруу нугасны гэмтэлтэй хүмүүст нийгмийн халамжийн сангаас тэргэнцэр өгөхдөө зөвхөн нэг хэмжээтэйг өгдөг, эсвэл сонсголын бэрхшээлтэй хүмүүст ижил аппарат өгч байгаа нь тэр хүмүүсийн ялгаатай хэрэгцээнд тулгуурласан, хүртээмжтэй үйлчилгээ гэж үзэхэд хүндрэлтэй юм.

Өнөөдөр зөөлөн болон хатуу дэд бүтэц хөгжлийн бэрхшээлтэй

хүмүүсийн нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд идэвхтэй оролцох оролцоог хязгаарлаж, тэдэнд тэгш боломж олгохгүй байгаа талаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүд шүүмжлэх нь энэ чиглэлээр ахиц дэвшил гарахад нөлөөлөх тун чухал арга хэмжээ болно. Үүний зэрэгцээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэлж, нэвтрүүлж байгаа мэдээлэл нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээг хангаж чадаж байна уу, тэдэнд хүртээмжтэй байна уу гэдэгт дүгнэлт хийж тодорхой алхам хийх зайлшгүй шаардлага гарч байна. Өнөөдөр Монгол Улсад үндэсний болон орон нутгийн хэмжээнд цацагддаг олон телевиз байгаа ч сонсголын бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй бус байгаа нь бас л анхаарах асуудлын нэг билээ.

Ер нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь тодорхой бүлгийн эрхийн асуудлыг хөндөх гэж байгаа бол өмнөөс нь яриад, дүгнэхийн оронд тэдэнд хэвлэл мэдээллээр өөрсдийгөө илэрхийлэх боломж олгох нь хүний эрхэд суурилсан хандлагын тун чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Энэ гарын авлагад НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн UPR-т монголын ТББ-ын форумас илгээх цөөнхийн эрхийн талаарх мэдээллийг бэлтгэсэн багаас ирүүлсэн танилцуулгыг хавсаргасан. Тус хавсралтад үндэсний цөөнх, бэлгийн цөөнх, ХДХВ/ДОХ-той амьдарч буй хүмүүс, биеэ үнэлэгч эмэгтэйчүүдийн асуудлаар хэвлэн нийтлэхдээ анхаарвал зохих асуудлууд тусгагдсан юм. Тиймээс сэтгүүлчид цөөнхийн асуудлаар хэвлэн нийтлэхдээ энэхүү хавсралт мэдээллийг анхааран үзнэ гэдэгт найдаж байна.

Тодорхой эрхийн асуудлаар хэвлэн нийтлэхэд зайлшгүй анхаарах асуудлууд их бий. Тухайлбал, сурч боловсрох эрхийн асуудлаар нийтэлж, нэвтрүүлэхэд зөвхөн боловсролын хүрэлцээтэй, хүртээмжтэй байдалд анхаарал хандуулаад зогсохгүй хүүхдүүд эрүүл мэнд, хоол тэжээл, аюулгүй байдал болон хүчирхийлэл, дарангуйллаас өөрийгөө хэрхэн хамгаалах мэдлэг, боловсролыг эзэмшиж чадаж буй эсэхэд анхаарах шаардлагатай. Мөн боловсрол дахь хүний эрхийн асуудалд боловсролын дэд бүтэц, хөтөлбөрийн чанар, сургууль хүүхдүүдэд хүртээмжтэй эсэх (энэ хүрээнд сургууль аюулгүй орчин мөн эсэх, бүх хүүхдэд сургуулийн хэрэгсэл нь хүртээмжтэй байж чадаж буй эсэх, сурах бичиг,

хэрэгсэл нь хүүхдийн хэрэгцээг хангасан эсэх) зэргийг хамтад нь авч үздэг.

Цаашлаад багш нарын мэргэшсэн байдал, мэргэжлийн ур чадвар, тэдний цалин хөлс, анги дүүргэлт, хүчирхийлэл, дарамтаас ангид эсэх зэрэг олон чухал асуудал энэ хүрээнд яригдана. Сургууль хүчирхийллээс ангид, аюулгүй орчин мөн эсэхэд бид ихэд эргэлздэг. Гэсэн хэдий ч энэ асуудлаар дорвитой хөөцөлдөж байгаа сэтгүүлчид тийм ч олон биш байна. Саяхны жишээ гэхэд 9 настай охиныг сургуулийн ариун цэврийн өрөөнд хүчирхийлсэн гэх жигшүүрт хэрэг гарахад хэвлэл мэдээллийн хэрэгслүүд энэ мэдээлэлд дуулиан, шуугиантай гэх талаас нь анхаарав уу хэмээн ажиглагдсан. Гэтэл сэтгүүл зүй өндөр түвшинд хөгжсөн орнуудад энэ хэргийг хүний эрхийн үүднээс авч үзэн нийгэмд танилцуулж, буруутай этгээдэд хариуцлага тооцуулах, хохирогчид туслах, цаашид энэ төрлийн гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх зэрэгт хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь онцгой анхаарч ажилладаг.

Хүний эрхийн аливаа асуудлын талаар сэтгүүлчид мэдээлнэ, нийтэлнэ гэдэг нь тэднээс мэргэжлийн ур чадвар, өндөр ёс зүйг, мөн хүний эрхийн боловсрол, тухайн асуудалд мэдрэмжтэй хандахыг шаарддаг. Гарын авлагын энэ хэсэгт тухайлсан хүний эрхийн асуудал, тодорхой бүлгийн эрхийн тухай асуудлыг хэвлэн нийтлэхэд анхаарахгүй байхын аргагүй зарим асуудлыг цухас дурьдлаа.

2. Хүний эрхэд суурилсан хандлага

2.1 Хүний эрхэд суурилсан хандлага гэж юу вэ?

Энэ нь аливаа үйл ажиллагаа, хөтөлбөр, төсөл нь олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд тулгуурласан, оролцогчдыг чадавхжуулахад чиглэсэн, хамгийн эмзэг байгаа бүлэгт илүү их анхаарал хандуулсан байхыг хэлнэ. Хүний эрхэд суурилсан хандлага нь бүх л хувь хүнийг эрхээ бүрэн дүүрэн эдлэхэд тусалцаа үзүүлэх, тэднийг чадавхжуулахад чиглэдэг тул үүрэг хүлээгч буюу төрийн

хүний эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах үүрэг хариуцлагын талаар байнга сануулж байдаг. Үүний талаар тайлагнах, мэдээлэх үүргийг зөвхөн төр дангаар хариуцахгүй нь тодорхой бөгөөд үүнд хэвлэл мэдээллийн хэрэгсэл чухал үүрэгтэй.

Энэхүү хандлага нь тодорхой нэг эрхтэй холбоотой бүх л асуудалд шинжилгээ хийх бөгөөд төрийн бодлого, эрх зүйн тогтолцоо, орон нутгийн болон үндэсний хүчин зүйл хэрхэн нөлөөлж байгаа зэргийг цогцоор авч үздэг. Хүний эрхийн асуудлуудын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр тогтмол мэдээлж байх нь олон нийт эргэн тойрондоо болж буй үйл явдлын талаар цогц, бодит мэдээлэл авахад тун чухал үүрэг гүйцэтгэнэ. Хүний эрх нь зөвхөн эрх зүйн асуудал биш бөгөөд тухайн улсын хөгжил дэвшилд шууд нөлөөлдөг. Хүний эрхийн мэдлэг, гэгээрлийг дээшлүүлэх явдал нь хүмүүсийн аюулгүй байдлаа хангах мэдрэмжийг сайжруулдаг. Тэд хэрвээ аливаа нэг хүний эрхийн зөрчил нь зүгээр өнгөрүүлэх асуудал биш гэдгийг мэддэг болбол хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан тэдэнд юу тохиолдсоныг олон нийтийн анхааралд хүргэдэг болно. Нөгөө талаас хүний эрхийн асуудлыг мэдээлдэг хэвлэл мэдээллийн хүрээг өргөжүүлснээр олон нийт өөрийнхөө болон бусдын эрхийн талаар илүү сайн мэддэг болох боломжтой юм.

2.2 Эрхэд суурилсан хандлагад баримтлах зарчмууд

Хүний эрхэд суурилсан хандлага нь хүний эрхийн тодорхой зарчмуудад суурилдаг. Эдгээр зарчмуудыг дурьдвал: оролцоо, хариуцлагатай байдал, үл ялгаварлан гадуурхах, эрх зүйн чадавх болон хүний эрхийн хэм хэмжээнүүдийн хоорондын уялдаа холбоо зэрэг юм.

Хүний эрхийн хэм хэмжээнүүдийн хоорондын уялдаа холбоо:

Хүний эрхэд суурилсан хандлага нь олон улсын хүний эрхийн хууль, хэм хэмжээтэй шууд холбогдох бөгөөд эдгээр нь хүний эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалахад шаардагдах наад захын хэм хэмжээ юм. Сэтгүүлчид нийгмийн аливаа асуудлын талаар ярихдаа засгийн газрын нэгдэн орсон гэрээ конвенц болон түүгээр

хүлээсэн үүргийн хэрэгжилтийн талаар заавал дурьдаж байх ёстой.

Оролцоо: Хүний эрхэд суурилсан хандлага нь эрх ашиг хөндөгдөж байгаа болон болзошгүй хувь хүн, эрэгтэй, эмэгтэй, олон нийт, иргэний нийгэм, нутгийн уугуул иргэд зэрэг бүхий л бүлгийн өргөн оролцоог шаарддаг. Оролцоо нь идэвхтэй, чөлөөтэй бөгөөд утга агуулга дүүрэн байх ёстой. Тиймээс эмзэг бүлгийг оролцуулах нь нэн тэргүүний зорилт юм.

Хариуцлагатай байдал: Хүний эрхэд суурилсан хандлага нь “эрх эдлэгч” болон “үүрэг хүлээгч” (хүний эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах үүрэг бүхий этгээд) хэн болохыг тодорхойлдог. Энэ хүрээнд эрх эдлэгчийн эрхээ эдлэх явцад хэн ямар үүрэг, хариуцлага хүлээж байгаа болохыг онцлон авч үздэг. Энэ зарчим нь үүрэг хүлээгч буюу төр, хувь хүмүүс, орон нутгийн байгууллага, хувийн компани, донор байгууллага, олон улсын байгууллага өөрийн хүлээсэн үүргээ биелүүлэх чадавхийг нэмэгдүүлэхэд анхаардаг.

Үл ялгаварлан гадуурхах: Хүний эрхийн суурь зарчмуудын нэг болох үл ялгаварлан гадуурхах зарчим нь эмзэг бүлэгт онцгой анхаарал хандуулдаг. Аливаа цөөнх, нутгийн уугуул иргэд, ядуу иргэд зэрэг нь энэ бүлэгт хамаарна. Энэ зарчмыг амжилттай хэрэгжүүлэх, ялгаварлан гадуурхах явдалтай үр дүнтэй тэмцэхэд чанарын болон тоон мэдээлэл онцгой ач холбогдолтой юм. Манай орны тоон мэдээлэл, статистик нь байнга эргэлзээ төрүүлж байдаг.

Тоон мэдээлэл тун чухал гэдгийг бүгд мэддэг хэдий ч статистикийн мэдээг анхны эх сурвалжаас авахдаа хүний эрхэд суурилсан хандлагыг баримталдаггүй нь аливаа асуудалд хүний эрхийн үүднээс дүгнэлт хийхэд бодит бэрхшээлийг учруулдаг. Жишээ нь, манай улсад хөгжлийн бэрхшээлтэй хүн хэд байгаа талаарх тоон мэдээ олон янзаар, өөр өөр аргачлалаар гардаг бол үндэсний, угсаатны цөөнхийн талаарх мэдээлэл нь монгол, казах, бусад гэсэн хэт ерөнхий хүрээнд гарах жишээтэй. Үүнээс улбаалаад тодорхой орон нутагт амьдран буй үндэсний, угсаатны цөөнхийг олонхтой

харьцуулахад ямар нөхцөлд байна вэ, ялгаварлан гадуурхалтад өртөж байна уу гэх зэрэг дүгнэлт хийх боломжийг хааж байна. Сэтгүүлчид эдгээр бүлгийн талаарх аливаа мэдээлэлд туйлын болгоомжтой хандахгүй бол ялгаварлан гадуурхалтыг буруушаах бус харин өдөөн хатгахад түлхэц өгөх аюултай юм.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр аливаа нэг бүлгийг дорд үзэх, ялгаварласан, үзэн ядсан үг хэллэг хэрэглэх зэрэг нь манай улсад түгээмэл байгаа нь туйлын харамсалтай. Хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй ч, энэ эрхээ эдлэхдээ бусдыг үзэн ядах, доромжлох, бусдын эрх, нэр төрд халдах нь хүний эрхийн ноцтой зөрчил болно. Үүнийг олон улсын болон үндэсний хууль тогтоомжоор хориглосон. Тиймээс ялгаварлан гадуурхах аливаа үзэл, хэлбэрийг устгахад хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь хүчирхэг зэвсэг юм.

Эрх зүйн чадавхи: Хүний эрхэд суурилсан хандлага нь эрх эдлэгчдийг эрхээ шаардах, эрхээ эдлэх чадавхтай болгоход анхаарал хандуулдаг. Тиймээс ч эрх эдлэгчид нь аливаа үйл явцын төвд байх ёстой. Аливаа асуудлаар шийдвэр гарах үйл явцад оролцох боломжгүй бүлгүүдийн олж, тэдний хэрэгцээ шаардлагыг тухайн шийдвэрт тусгахад дуу хоолойгоо хүргэх, үзэл бодлыг нь олон нийтэд дуулгахад сэтгүүлчдийн гүйцэтгэх үүрэг их билээ. Нэг жишээ хэлэхэд нэн ядуу иргэнд өгч буй халамж, үйлчилгээ тэдэнд хэр хүрч байгаа эсэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст олгогдож байгаа портейз, ортофейд, тусгай хэрэгсэл нь тэдний ялгаатай хэрэгцээг хангаж чадаж байна уу, үгүй юу гэдгийг бодитоор хэлэх субъект бол яах аргагүй тэдгээр эмзэг бүлгийн иргэд юм. Үүний зэрэгцээ тухайн бүлгийн бодит хэрэгцээ ямар байгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэлж, нэвтрүүлэх нь тухайн байдалд ахиц гаргахад чухал түлхэц болох нь дамжиггүй.

3. Сэтгүүл зүй дэх хүний эрхэд суурилсан хандлага

Сэтгүүлчид аливаа асуудлаар тэр дундаа хүний эрхийн талаар хэвлэн нийтлэхдээ эрхэд суурилсан хандлагын үүднээс хандвал зохино. Үүний тулд дараах зүйлд анхаарал хандуулах шаардлагатай.

3.1. Хүний эрхийн хэм хэмжээ хоорондын уялдаа холбоо

Үзэгчид хүний эрхийн талаар ихэвчлэн тодорхой мэдлэг байдаггүй тул энэ нь юу болохыг тодорхой тайлбарлах нь зүйтэй юм. Хүний эрхийн аливаа асуудлыг мэдээлэхдээ байнга “ХҮНИЙ ЭРХ” хэмээх үзэл баримтлалыг өмнөө барьж мэдээлэх шаардлагатай бөгөөд ингэснээр иргэд өөрийнхөө болон бусдын эрхийн талаар илүү ихийг мэдэж авах болно. Түүнчлэн Монгол Улсын нэгдэн орсон гэрээ конвенциор засгийн газар ямар үүрэг хүлээсэн, хэрэгжилтийн талаар НҮБ-ын Хороод хэрхэн дүгнэлт өгсөн зэргийг байнга дурьдаж байх нь зүйтэй.

3.2. Үл ялгаварлан гадуурхах

Сэтгүүлчид эмзэг бүлэгт тогтмол анхаарал хандуулж, таны мэдээлж буй асуудал тэдэнд хэрхэн нөлөөлж байгааг байнга анхаарах шаардлагатай. Хүйс, хөрөнгө чинээ, үндэс угсаа, жендэр зэрэг асуудлаарх тоо баримтыг мэдээ, баримтдаа сайтар ашиглаж чадаж байвал тухайн мэдээлэл нь бодитой, амьд байх болно.

Хэн нэгэн хүнтэй ярилцлага хийхдээ эрх мэдлийн тэгш бус байдал байгаа эсэхийг байнга нягтлах шаардлагатай. Тухайлбал, таньтай ярилцах гэж буй хүн тань таниас эрх мэдлийн хувьд ялгаатай байна уу, тэр таны асуултад хариулахдаа зөвхөн таны сонсохыг хүссэн зүйлийг л хэлээд байна уу, түүнийг явал илүү тохитой, тавтай байлгах вэ зэрэг асуултыг Та өөртөө байнга тавих хэрэгтэй.

Хэрвээ та нэгээс илүү хүнтэй ярилцах гэж буй бол тэдгээр хүмүүсийн дунд эрх мэдлийн ялгаа ямар байгаа эсэхийг мэдэх нь зүйтэй. Ярилцагч чинь хэн нэгний өмнө өөрийн үзэл бодлыг илэрхийлэхдээ таатай бус байна уу? Таньтай ярилцаж буй хүмүүс ижил үндэстэн, угсаатны бүлэг мөн үү? Тэд хүйсийн хувьд ижил байна уу? Тэд адилхан нийгэм, эдийн засгийн статустай юу? Эдгээр асуултад хариулт өгөхийн зэрэгцээ, нэгээс илүү хүмүүстэй зайлшгүй ярилцах шаардлага гарвал аль болох ойролцоо түвшний хүмүүс байлгахыг хичээх хэрэгтэй юм. Тиймээс хэрвээ эмэгтэй хүнтэй эмэгтэйчүүдийн асуудлаар ярилцах гэж буй бол эмэгтэй

сэтгүүлч хөтлөх нь илүү үр дүнтэй. Мөн зарим нэг үндэстэн, угсаатны төлөөлөлтэй ярилцлага хийх гэж буй бол сэтгүүлч нь тухайн соёлын төлөөлөл эсвэл тухайн соёлын талаар мэдээлэл, мэдлэгтэй байхыг шаарддаг.

3.3. Хариуцлагатай байдал

Хүний эрхийн асуудлаар мэдээлэл хийх гэж байгаа бол ул суурьтай баримтад тулгуурлах шаардлагатай. Хөнгөн хийсвэр хандаж болохгүй. Ярилцлага хийхийн өмнө тухайн хүнд та хаанаас ирсэн, юу асуухыг хүсч байгаа болон юуг мэдээлэх гэж байгаа тухай мэдээллээ өгсөн байх ёстой. Мөн хэрхэн мэдээлэх, тэднээс авсан мэдээллээ хэрхэн иш татах зэргээ тодорхой болгох ёстой. Энэ талаар тэдэнтэй урьдчилан зөвшилцөх хэрэгтэй.

Сэтгүүлчдийг тодорхой соёл, улс төр болон нийгмийн асуудлуудад мэдрэмжтэй байхыг шаарддаг. Бид хэдхэн жилийн өмнө Данид юу тохиолдсоныг мэднэ. Тэнд нэгэн шог зураачийн зурсан бүтээлийг сонинд нийтэлснээр исламын шашинтай орнууд ихээхэн хурц шүүмжлэл өрнүүлж, жагсаал цуглаан, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэх шалтгаан болсон билээ. Тиймээс аливаа асуудлаар мэдээлэхдээ цаана нь үүсч болох хүний эрхийн асуудлыг урьдчилан харах ёстой. Тухайлбал, хүчингийн гэмт хэргийн талаар хэвлэн нийтлэхдээ хохирогч эмэгтэйг замбараагүй явдалтай, хувцаслалт нь задгай гэх мэтээр шүүмжлэх нь энэ гэмт хэргийн хохирогчийг давхар хохироход хүргэж, улмаар эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах хандлагыг өөгшүүлэх аюултай.

Ярилцлага хийх үедээ ярилцаж буй хүнийхээ аюулгүй байдлыг байнга тооцоол. Хэрвээ ямарваа нэг хүчирхийллийн хохирогч байх юм бол аюулгүй газар ярилцаж, улмаар хувийн мэдээллийг нууцлах замаар мэдээлэх шаардлагатай. Хэрвээ тухайн хүн таньтай ярилцсанаар бий болох аюул заналыг мэдэхгүй байна гэж та бодож байвал ярилцлага хийхээсээ өмнө түүнд анхааруулах ёстой. Ярилцагчаа хамгаалах нь сэтгүүлчийн ёс зүйн асуудал төдийгүй хүний эрхийн асуудал. Хэрвээ засгийн газар олон улсын

гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд энэ тухай өөрийн нийтлэл, нэвтрүүлэгтээ мөн тусгах шаардлагатай юм. Энэ нь төрийн хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэхэд оруулах чухал хувь нэмэр билээ.

3.4. Оролцоо

Хэрвээ та ямар нэгэн эмзэг бүлгийн асуудлыг дэвшүүлэн тэдний дуу хоолой, үзэл бодлыг олон нийтэд хүргэх гэж буй бол, тэдний одоогийн болон ирээдүйн аюулгүй байдлыг сайтар бодолцох ёстой. Хүний эрхэд суурилсан хандлага бол оролцоог ихээхэн дэмждэг. Ингэснээр эдгээр бүлэг нь тухайн нөхцөл байдлын талаар мэдээлэл өгөөд зогсохгүй, тэдэнд нүүрлээд байгаа бэрхшээлийг шийдвэрлэх маш чухал арга замыг гаргаж тавих боломжтой юм.

3.5. Эрх зүйн чадавх

Таньтай ярилцсан хүмүүсийн аюулгүй байдалд заналхийлэл байхгүй нөхцөлд тэдэнд хандан цаашдын үйл явцын талаар мэдээлэл өгөхийг хүсч болно. Мөн тэдний эрхийн асуудалд мэдрэмжтэй ханддаг, тэдэнд асуудал тохиолдвол хүлээн авч, тухайн асуудлыг нь олон нийтэд хүргэхэд тусалж чадах сэтгүүлчтэй хэрхэн холбоо барих талаарх мэдээллийг тэдэнд өгөх нь тун чухал юм.

Бүлгийн дүгнэлт

Хүний эрхийн асуудлаар мэдээлнэ, хэвлэн нийтэлнэ гэдэг нь сэтгүүлчдэд тун чухал хариуцлагыг оногдуулдаг. Нөгөө талаас манай улсын хүний эрхийн салбарт чухал үйл явдал тохиож буй энэ цаг үед сэтгүүлчдэд зориулан хүний эрхэд суурилсан хандлагын талаар гарын авлагыг бэлтгэн хүргэж байгаа нь НҮБ-ын ХЭЗ-ийн шинэ механизмыг үр дүнтэй ашиглахад сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслийн оролцоо туйлын чухал гэдгийг хүлээн зөвшөөрч, тус ажилд та бүхнийг илүү их мэдлэгтэй, утга агуулга дүүрэн оролцоход тань дэмжлэг үзүүлэхийг зорьсон явдал юм. Энэ бүлэг нь эрхэмсэг сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнууд хүний эрхэд суурилсан хандлагын талаар мэдэхэд бяцхан ч атугай тус нэмэр болно гэдэгт гүнээ найдаж байна.

Бүлэг II. UPR ба НҮБ-ийн хүний эрхийн бусад механизм, хэвлэл мэдээллийн үүрэг

Бүлгийн товч танилцуулга

Та энэ бүлгээс НҮБ-ын хүний эрхийн байгууллагуудын бүтэц, үйл ажиллагааны чиглэл, бүрэн эрхийн талаар болон иргэний нийгмийн байгууллага, сэтгүүлчид тэдгээртэй хэрхэн хамтран ажиллах талаар тодорхой ойлголттой болно. Ялангуяа НҮБ-ын ХЭЗ-д түшиглэн байгуулагдсан цоо шинэ хяналтын механизм болох Хүний эрхийн ээлжит дүгнэлт, хэлэлцүүлэг буюу UPR-ийн тухай зохих мэдлэгтэй болно. Монгол улс 2010 оны 11-р сард анх удаа UPR-т хүний эрхийн төлөв байдлаа тайлагнан олон улсын өмнө тодорхой үүрэг, амлалт авах тул сэтгүүлчид энэ үйл явцын талаар мэдлэгтэй байж, идэвхитэй оролцох нь UPR-ийг үндэсний хэмжээнд үр дүнтэй үйл явц болгоход чухал ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл UPR-ийн үр дүнд Монгол улсын хүний эрхийн төлөв байдалд ямар нэгэн ахиц дэвшил заавал гарах ёстой бөгөөд үүнд сэтгүүлчдийн үүрэг асар чухал юм.

1.НҮБ-ийн хүний эрхийн механизм, бүтэц, ерөнхий ойлголт

Жаран сая гаруй хүний амь насыг авч одсон дэлхийн II дайны дараа бүх нийтийн энх тайван, аюулгүй байдлыг хангах, энх тайвныг бусниулахад хүргэж болзошгүй аливаа асуудлыг шударга ёс, олон улсын эрх зүйн дагуу эв зүйгээр шийдвэрлэх, улс орнуудын найрсаг хамтын ажиллагааг хөгжүүлэх, хүний эрхийг ямар ч ялгаваргүйгээр хүндэтгэх явдлыг хөхиүлэн дэмжих зорилгоор дэлхийн улс гүрнүүд санаа нэгдэн Нэгдсэн үндэстний байгууллагыг (НҮБ) байгуулсан билээ. НҮБ нь анх 1945 оны 10-р сарын 24-нд АНУ-ын Калифорни муж улсын Сан-Франциско хотод 51 гишүүн оронтойгоор үндэс сууриа тавьж байсан бол эдүгээ 192 улсыг эгнээндээ нэгтгэсэн олон улсын хамгийн том байгууллага болж чаджээ.


НҮБ-ын Дүрмийн 1 дүгээр зүйлд олон улсын энх тайван, аюулгүй

байдлыг хангах, хөгжлийг дэмжих, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хөхиүлэн дэмжих явдлыг НҮБ-ын эрхэмлэвэл зохих үндсэн зорилгууд хэмээн тодорхойлсон. Ийм ч учраас НҮБ нь дээрх зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа бүхий олон байгууллагаас бүрддэг.

Хүний эрх эрх чөлөөг хүндэтгэх, хөхиүлэн дэмжих явдал нь НҮБ-ын үйл ажиллагааны үндсэн 3 зорилгын нэг болохын хувьд хүний эрхийг хамгаалах бүхэл бүтэн тогтолцоо НҮБ-ын системд томоохон байр суурь эзэлдэг юм. Тухайлбал, НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1948 оноос эдүгээг хүртэл нийт 80 орчим хүний эрхийн олон улсын гэрээ, конвенци, тунхаглал баталсан бөгөөд тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэгтэй байгууллагууд байгуулагдан ажиллаж байна.

НҮБ-ын Хүний эрхийн тогтолцоог дүрмийн үндсэн дээр байгуулагдсан, хүний эрхийн гэрээнд үндэслэн байгуулагдсан гэсэн үндсэн 2 төрөлд хуваан үздэг бөгөөд доорхи схемд саарал өнгөөр ялган үзүүлэв.

Доорхи байгууллагуудын бүтэц, чиг үүрэг, үйл ажиллагааны хэлбэр, чиглэлийн талаар дараагийн бүлгүүдэд дэлгэрэнгүй авч үзэх болно.



Ерөнхий Ассамблей - ЕА

Аюулгүйн зөвлөл - АЗ

Эдийн засаг, нийгмийн зөвлөл - ЭЗНЗ

Хүний эрхийн зөвлөл – ХЭЗ

Нарийн бичгийн дарга нарын газар - НБДНГ

Зөвлөх хороо - ЗХ

Үйл ажиллагааны Комисс - УАК

Хүний эрхийн дээд комиссарын газар - ХЭДКГ

1.1 Хүний эрхийн зөвлөл

Хүний эрхийн Зөвлөл нь (ХЭЗ) нь НҮБ-ын Ерөнхий ассамблейн 2006 оны 3-р сарын 15-ны өдрийн 60/251 тоот шийдвэрээр 60 гаруй жилийн хугацаанд НҮБ-ын хүний эрхийн асуудлыг хариуцан ажилласан Хүний эрхийн комиссын оронд хүний эрхийн асуудлыг хариуцан ажиллахаар байгуулагдсан НҮБ-ын Засгийн газар хоорондын үндсэн байгууллага юм. Хүний эрхийн комисс нь НҮБ-ын ЭЗНЗ-д харъяалагддаг байсан бол ХЭЗ нь Ерөнхий Ассамблейд шууд хамаардаг. Өөрөөр хэлбэл ЭЗНЗ-тэй ижил статустай болжээ. Ерөнхий Ассамблейн **60/251** тоот шийдвэрийн дагуу Хүний эрхийн комиссоос уламжлан өвлүүлсэн бүхий л үүрэг хариуцлага, хүний эрхийг хамгаалах механизм, тэдгээрийн мандатыг дахин хянан үзэж, шаардлагатай бол сайжруулах үүргийг ХЭЗ-д олгосон. Ийнхүү ХЭЗ нь 2007.06.18-ны өдрийн **5/1** тоот шийдвэрээрээ өөрийн бүтэц-зохион байгуулалтын баримт бичгийг батлан гаргасан бөгөөд үүндээ Ерөнхий Ассамблейгээс өгсөн чиглэлийн дагуу ажлынхаа шинэ аргачлал, хэлэлцэх асуудал, гомдол хэлэлцэх процесс, ХЭЗ-ийн Зөвлөх хороо (Human Rights Council Advisory Committee), ХЭЗ-ийн ажлын үндсэн механизм болох Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт, хэлэлцүүлэг (UPR), Тусгай хэрэгслүүдийн мандат зэрэг гол асуудлуудыг тусгасан.

ХЭЗ нь хүний эрхийн ужиг болон ноцтой зөрчлүүдийг үүсгэж буй нөхцөл байдалд анхаарлаа хандуулах, энэ талаар зөвлөмж гаргах үндсэн зорилготой байгууллага юм.

ХЭЗ нь үйл ажиллагаандаа түгээмэл, шударга байх, чиглэл зорилготой байх, урьдчилан сонгохгүй байх, харилцан ойлголцож хамтран ажиллах, тодорхой, уян хатан байх, ил тод, хариуцлагатай байх, тэнцвэртэй байх, хүртээмжтэй, олон талт байх, хүйсийн тэгш байдлыг хүндэтгэх зарчмуудыг баримтлана.

ХЭЗ нь:

- Хүний эрхийн боловсрол, сургалтыг дэмжин, тухайн Гишүүн улстай зөвшилцсөний үндсэн дээр техникийн тусламж үзүүлэн чадавхийг нь бэхжүүлнэ.
- Хүний эрхийн тодорхой асуудлуудыг хэлэлцэх талбар болж ажиллана.
- Олон улсын хүний эрхийн хэм хэмжээг боловсронгуй болгох чиглэлээр ЕА-д хандан зөвлөмж гаргана.
- Улс орнуудаас сайн дураар хүлээсэн хүний эрхийн үүрэг болон НҮБ-ын дээд хэмжээний уулзалт, хурлаас гарсан хүний эрхийг хангах, хамгаалахад чиглэсэн зорилт, амлалт, үүргийн хэрэгжилтийг шаардах үүрэгтэй.
- Үнэн бодит мэдээлэл дээр үндэслэн UPR-ийг явуулна.
- Яриа хэлэлцээ, хамтын ажиллагаагаараа хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд хувь нэмэр оруулах ба хүний эрхийн онцгой нөхцөл байдалд яаралтай хариу арга хэмжээ авна.
- ХЭДК-тай холбоотой Хүний эрхийн комиссын үүрэг, хариуцлагыг хүлээн авч үргэлжлүүлнэ.
- Хүний эрхийн салбарт Засгийн газар, бүсийн байгууллагууд, хүний эрхийн үндэсний байгууллагууд болон иргэний нийгэмтэй нягт хамтран ажиллана.
- Хүний эрхийг хангах, хамгаалах талаар зөвлөмж гаргана.
- Жил бүр үйл ажиллагаагаа ЕА-д тайлагнана.

ХЭЗ-ийн гишүүнчлэл: ХЭЗ нь нууц санал хураалтаар, 3 жилийн хугацаатай Ерөнхий Ассамблейн гишүүдийн олонхоос шууд

сонгогдсон 47 Гишүүн улсаас бүрдэнэ. Гишүүнчлэл нь газар зүйн бүсийн төлөөллийг тэнцвэртэй хангасан байх ёстой. НҮБ-ын гишүүн бүх улс ХЭЗ-ийн гишүүн байж болох ба ХЭЗ-ийн гишүүнээр сонгогдохдоо өөрийн улс орны хүний эрхийг хангах, хамгаалах асуудалдаа тодорхой хувь нэмэр оруулахыг анхаарах бөгөөд сайн дурын үүрэг, амлалт авах үүрэгтэй. ХЭЗ-ийн гишүүд нь гишүүнийхээ бүрэн эрхийн хугацаанд UPR-ийн хэлэлцүүлэгт орох бөгөөд хүний эрхийг хангах, хамгаалахад дээд зэргээр анхаарч, ХЭЗ-тэй байнга холбоотой ажиллана. Монгол улс ХЭЗ-ийн гишүүнээр сонгогдох хугацаа нь дараагийн циклээр таарч буй бөгөөд мөн эл хугацаанд UPR-ын хэлэлцүүлэгт Монголын иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээллийнхэн энэ боломжийг ашиглан хүний эрхийн нөхцөл байдлаа сайжруулах талаар нөлөөлөл, лобби ажиллагаа эрчимтэй явуулах шаардлагатай байна.

ХЭЗ нь өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дараах гол механизмуудыг ашигладаг:

ХЭ-ийн төлөв байдлын ээлжит дүгнэлт, хэлэлцүүлэг (UPR):

UPR нь “гишүүн бүх улсынхаа хүний эрхийн үүрэг, амлалтынх нь биелэлт, хүний эрхийн төлөв байдлыг үнэн бодит мэдээлэлд үндэслэн дүгнэх хэлэлцүүлгийг 4 жил тутамд хийдэг” ХЭЗ-ийн тусгай цоо шинэ механизм юм. Гарын авлагын дараагийн хэсэгт UPR-ийн талаар дэлгэрэнгүй өгүүлэх болно.

ХЭЗ-ийн Зөвлөх Хороо: Зөвлөлийн үйл ажиллагааны бодлого, чиглэлийг тодорхойлох үүрэг бүхий Зөвлөх Хороо нь өөрийн итгэл үнэмшэл дээр ажиллах 18 шинжээчдээс бүрдэнэ. Зөвлөх хороо нь судалгаа, шинжилгээний ажилд төвлөрөн судалгаанд үндэслэсэн ХЭЗ-ийн эрх хэмжээнд хамаарах асуудлаар арга зүйн зөвлөмж өгдөг. Зөвлөх хорооны гишүүдийг бүс нутгийн харъяалал, хүний эрхийн мэдлэг туршлага, ёс зүй зэргийг нь харгалзан НҮБ-ын гишүүн улсуудаас өөрийн орны хүний эрхийн үндэсний байгууллага, болон иргэний нийгмийн байгууллагуудтай зөвшилцсөн нэр дэвшүүлж ХЭЗ-ийн хуралдаанаас нууц санал хураалтаар сонгоно. Зөвлөх хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа 3 жил байна.

Гомдол гаргах журам: Ерөнхий Ассамблейгээс олгосон эрхийн дагуу ХЭЗ нь “дэлхийн улс орнуудын аль ч цэгт гарсан, хүний эрхийн ноцтой болон ужиг зөрчлийн талаарх гомдлыг хүлээн авч шалгах” эрхтэй. Гомдол нь дараах шаардлагыг хангасан байна:

- Гомдол нь илэрхий улс төрийн агуулгагүй байх ба НҮБ-ын дүрэм, ХЭТТ болон хүний эрхийн бусад хэм хэмжээгээр баталгаажсан хүний эрхийг зөрчсөн тухай байх

- Зөрчигдөж буй эрх, түүнийг хэрхэн зөрчсөн талаар тодорхой дурдсан байх

- Бүдүүлэг үг хэллэг хэрэглээгүй байх

- Эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн нэг буюу бүлэг хүмүүс гомдол гаргах эрхтэй ба хүний эрх, эрх чөлөөний талаар үнэн бодит, шууд мэдээлэл бүхий бусад этгээд, ТББ гомдол гаргаж болно. Гэхдээ гомдол нь НҮБ-ын Дүрэмд харшлаагүй, улс төрийн сэдэлгүй байх ёстой. Гомдолд дурдсан мэдээлэл нь дам мэдээлэл боловч хангалттай нотлох баримтуудаар нотлогдсон бол түүнийг хянан хэлэлцэнэ.

- Хэвлэл мэдээлэлд нийтлэгдсэн мэдээлэлд үндэслээгүй байх

- Тухайн зөрчил өмнө нь НҮБ-ын тусгай хэрэгслүүд, гэрээний хороод, НҮБ-ын бусад байгууллага, тэдгээртэй төсөөтэй бүсийн хүний эрхийн байгууллагуудаар шийдвэрлэгдээгүй байх

- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь үр дүн муутай эсвэл хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удааширсанаас бусад тохиолдолд дотоодын хүний эрхийг хамгаалах механизмуудаар хянагдсан байх.

ХЭЗ-д гаргах гомдлыг дараах хаягаар илгээнэ:

Human Rights Council and Treaties Division

Complaint Procedure, OHCHR-UNOG

1211 Geneva 10, Switzerland

Fax: (41 22) 917 90 11

E-mail: CP@ohchr.org

Хүний эрхийн ноцтой зөрчлүүдэд ХЭЗ-ийн анхаарлыг хандуулах,

гомдлыг хянан шийдвэрлэх үүрэг бүхий хоёр ажлын хэсэг (Working group on communications and Working group on Situations) ажилладаг. Эдгээр ажлын хэсгийг хүйсийн тэнцвэрт байдал болон бүс нутгийн төлөөллийг харгалзан ХЭЗ-ийн Зөвлөх хорооноос байгуулна².

ХЭЗ-ийн гомдол хянан шалгасан Ажлын хэсгээс дараах арга хэмжээнүүдийн аль нэгийг авч болно:

- Хэргийг цаашид хэлэлцэх шаардлагагүй бол хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоох
- Холбогдох улсаас нэмэлт мэдээлэл ирүүлэхийг шаардах, хариу иртэл гомдол хянан шийдвэрлэх ажиллагааг сунгах
- Хэргийг судлан ХЭЗ-д тайлагнах үүрэг бүхий өндөр мэргэшсэн шинжээчийг томилох
- Гомдлыг олон нийтэд ил тод хэлэлцэх
- Холбогдох улсын чадавхийг дээшлүүлэх, техникийн болон арга зүйн бусад туслалцаа үзүүлэхийг ХЭДКГ-аас хүсэх

1.1.1 ХЭЗ-ийн Тусгай хэрэгслүүд

“Тусгай хэрэгсэл” нь хуучин Хүний эрхийн Комиссоос байгуулагдан өдгөө Хүний эрхийн зөвлөлд уламжлагдан шилжсэн, улс оронд үүссэн тодорхой асуудлаар, эсвэл сэдэвчилсэн асуудалд анхаарч ажилладаг механизмын ерөнхий нэр юм. Одоогийн байдлаар 31 сэдэвчилсэн асуудлаар ажилладаг (thematic mandates), 8 тодорхой улсын (country mandates) асуудлаар ажилладаг тусгай хэрэгслийн эрх эзэмшигчдийг ХЭЗ-өөс шинэчлэн томилоод байна.

ХЭДКГ нь эдгээр тусгай хэрэгслүүдийг эрхээ хэрэгжүүлэхэд нь бодлого, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлдэг.

Тусгай хэрэгсэл нь дараах байдлаар ажилладаг:

Хувь хүний гомдлыг шалгах, хариу өгөх (Communications): Ихэнх Тусгай хэрэгслүүд нь хүний эрхийн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч шалгах бүрэн эрхтэй бөгөөд гомдол мэдээлэл хүлээн авсан тохиолдолд холбогдох Засгийн газраас нь тодруулахаар “Яаралтай захидал” (urgent appeals эсвэл letters of

² ХЭЗ-ийн 5/1 тоот шийдвэрээс дэлгэрэнгүйг үзнэ үү

allegation)-ыг илгээдэг. 2008 онд 118 улс руу нийт 911 ийм захидал (communication)- илгээжээ. Үүний 66 хувийг нь 2 буюу түүнээс дээш тооны Тусгай хэрэгслүүдээс хамтран явуулсан байна.

Хувь хүнээс ирүүлэх гомдолд хүний эрхийн зөрчлийн хохирогч, холбогдогч, гомдлыг шилжүүлж буй этгээдийн талаарх мэдээлэл, зөрчил болсон газар, өдөр, зөрчлийн хэрхэн үйлдэгдсэн талаарх мэдээлэл зэргийг агуулсан байх ёстой.

Улс орнуудад албан айлчлал хийх (Country visits): Ихэнх Тусгай хэрэгслүүд нь улс орны хэмжээнд хүний эрхийн нөхцөл байдлыг шалгах, зөрчлийн баримт цуглуулах зорилгоор тухайн улсад очин газар дээр нь үзэж шалгадаг. Энэ тохиолдолд тухайн улсын Засгийн газраас урилга хүсдэг бөгөөд зөвшөөрсөн тохиолдолд хүний эрхийн нөхцөл байдалтай биечлэн танилцаж, шаардлагатай бол холбогдох этгээдээс нэмэлт мэдээлэл хүсч болдог. Зарим улс орон “Байнгын урилга”-тай бөгөөд Монгол улс үүнд багтаж байна. Өөрийн айлчлалынхаа үр дүнд Тусгай хэрэгслийн эрх эзэмшигч нь холбогдох дүгнэлт зөвлөмжийг агуулсан илтгэл бэлтгэн хэлэлцүүлдэг.

- **Сэдэвчилсэн асуудлаар судалгаа явуулах:** Хэм хэмжээ, стандарт тогтоох зорилгоор энэ ажлыг хийж болно.

- **Илтгэл хэвлүүлэх, хэвлэлийн хурал хийлгэх**

- **Улс орны түвшинд техникийн хамтын ажиллагааны зөвлөгөө өгөх**

- **Хүний эрхийг хөхиүлэн дэмжих үйл ажиллагаа явуулах:** Өөрийн мандатын хүрээнд олон нийтийн хүний эрхийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж болно.

Тусгай хэрэгслийн төрөл: Тусгай хэрэгсэл нь нэгдүгээрт, хувь хүн (Тусгай илтгэгч, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын Тусгай төлөөлөгч, Бие даасан шинжээч гэсэн нэртэй байж болно); хоёрдугаарт, ихэвчлэн 5 гишүүдээс бүрдэх (бүс бүрээс нэг хүний төлөөлөл бүхий) ажлын хэсэг байж болдог.

Хүний эрхийн тодорхой асуудлаар ажилладаг тусгай хэрэгслүүдийн жагсаалт

- Хүний эрх болон олон улсын эв нэгдлийн асуудлаархи хараат бус шинжээч
- Цөөнхийн асуудлаархи хараат бус шинжээч
- Эдийн засгийн шинэчлэлийн бодлого болон гадаадын хөрөнгө оруулалтын хүний эрх ялангуяа эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хэрэгжилтэд үзүүлж буй сөрөг нөлөөний талаархи хараат бус шинжээч
- Хүний эрх болон нэн ядуу байдлын асуудлаархи хараат бус шинжээч
- Зохистой орон байртай байх явдал нь зохистой амьжиргаатай байх эрхийн үндсэн нөхцөл болох асуудлаархи Тусгай илтгэгч
- Үл тэвчих болон арьс үзэл болон арьс өнгөөр ялгаварлан гадуурхах байдлын асуудлаархи Тусгай илтгэгч
- Шүүн таслах ажиллагаа явуулахгүйгээр цаазаар авах ял оноох болон цаазаар авах ялыг хилсээр гүйцэтгэх асуудлаархи Тусгай илтгэгч
- Шашин шүтэх эс шүтэх эрх чөлөөний асуудлаархи Тусгай илтгэгч
- химийн хорт хаягдлыг хууль бусаар тээвэрлэх, аюултай бодис, хог хаягдлаас хүний эрхийн хэрэгжилтэд үзүүлж буй сөрөг нөлөөний асуудлаархи Тусгай илтгэгч
- Хүний наймаа, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдийг худалдах явдлын хохирогч нарын хүний эрхийн асуудлаархи Тусгай илтгэгч
- Чагаачдын хүний эрхийн асуудлаархи Тусгай илтгэгч
- Шүүх хуульчдын хараат бус байдлын асуудлаархи Тусгай илтгэгч
- Терроризмтэй тэмцэхэд хүний эрх, үндсэн эрх чөлөөг хангах хамгаалах асуудлаархи Тусгай илтгэгч
- Сэтгэцийн болон эрүүл мэндийг хангах дээд нөхцлөөр хангуулах эрхийн хэрэгжилтийн асуудлаархи Тусгай илтгэгч
- Боловсрох эрхийн асуудлаархи Тусгай илтгэгч
- Хоол хүнсний эрхийн асуудлаархи Тусгай илтгэгч
- Хүүхдийг садар самуун уруу татах, хүүхдийг биеийг нь үнэлүүлэх болон хүүхэд худалдаалах асуудлаархи Тусгай илтгэгч
- Уугуул иргэдийн хүний эрх Үндсэн эрх чөлөөний асуудлаархи Тусгай илтгэгч
- Эрүүдэн шүүх болон нэр төрийг нь гутаах хүнлэг бусаар хэрцгийн харьцахтай холбоотой асуудлаархи Тусгай илтгэгч
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, түүний сөрөг нөлөө, үр дагаврын асуудлаархи Тусгай илтгэгч
- Үндэстэн дамжсан корпораци болон бусад бизнесийн үйл ажиллагаа ба хүний эрхийн асуудлаархи Ерөнхий нарийн бичгийн даргын Тусгай төлөөлөгч
- Хүний эрхийг хамгаалагчдын хүний эрхийн асуудлаархи Ерөнхий нарийн бичгийн даргын Тусгай төлөөлөгч
- Дотооддоо шилжин сууршсан хүмүүсийн хүний эрхийн асуудлаархи Ерөнхий нарийн бичгийн даргын Төлөөлөгч
- Африк гаралтай хүмүүсийн асуудлаарх Шинжээчдийн ажлын хэсэг
- Хууль бусаар баривчлах асуудлаарх Ажлын хэсэг
- Хүчээр алга болгох асуудлаарх Ажлын хэсэг

Тусгай хэрэгслийн мандат нь тэдгээрийг байгуулж буй шийдвэрээр тодорхойлогддог. Тусгай хэрэгслийн мандат эзэмшигчид нь үүргээ биелүүлсний төлөө цалин хөлс, санхүүгийн дэмжлэг авдаггүй бөгөөд өөрсдийн мэдлэг чадавхиа бүрэн зориулан ажилладаг. Тусгай хэрэгслийн эрх эзэмшигчдэд мэргэшил, туршлага зэрэг хувь хүний нэлээд өндөр шалгуур тавьдаг бөгөөд иргэний нийгмийн байгууллагаас тодорхой хүнийг нэр дэвшүүлж болно. Түүнчлэн Тусгай хэрэгслийн эрх эзэмшигчид хэн ч, хэзээ ч гомдол гаргаж болдог давуу талтай.

1.2. Гэрээний хороод

Гэрээний хороод нь НҮБ-ын системийн хүрээнд гэрээнд үндэслэсэн байгууллагын төрөлд хамаарах бөгөөд хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийг хянах үндсэн үүрэг хүлээнэ. Гэрээний хороод нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт зэрэг хүний эрхийн олон улсын гол гэрээнүүдэд үндэслэн байгуулагдсан байна. ХЭДКГ-аас Ажлын албадаараа дамжуулан тэдэнд ажлын аргачлал, илтгэлийг хянан хэлэлцэх үйл ажиллагаанд нь туслалцаа үзүүлдэг.

Гэрээний хороод нь хүний эрхийн зөрчлийн асуудлыг дараах байдлаар хянан үзэж болдог:

Хувь хүний гомдлыг хянан хэлэлцэх: НҮБ-ын дүрэм, ХЭТТ, бусад хүний эрхийн гэрээгээр олгогдсон эрх нь зөрчигдсөн гэж үзэж буй хэн ч гомдлоо холбогдох Гэрээний хороонд гаргаж болох ба зөвхөн 5 гэрээний хороод л ийм гомдлыг хүлээн авдаг

Улс хоорондын гомдлыг хэлэлцэх: Хүний эрхийн гэрээний гишүүн улсаас өөр гишүүн улс нь уг Конвенцээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байна гэж үзвэл Гэрээний хороонд гомдол гаргаж болох ба энэ эрхийг мөн л зарим Конвенцуудад л олгосон. Гэвч энэхүү зохицуулалтыг ашигласан тохиолдол хараахан гараагүй байгаа юм.

Шалгах (Inquiry): Гэрээний гишүүн улс нь хүний эрхийг ноцтой зөрчиж буй талаар бодитой мэдээлэл хүлээн авсан тохиолдолд тухайн улсыг дуудаж асуух, нэмэлт мэдээлэл ирүүлэхийг хүсэх, шаардлагатай тохиолдолд тухайн улсад айлчлах зэргээр хүний эрхийн зөрчлийнх нь асуудалд дүгнэлт, зөвлөмж гаргаж болдог.

Конвенцийн оролцогч улсуудын бага хурал: Энэ нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилттэй холбоотой асуудлуудыг хэлэлцэх зорилго бүхий механизм юм. Эхний хурлыг уг конвенцийг хүчин төгөлдөр болсноос хойш 6 сарын дотор НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга зарлан хуралдуулах ба дараагийн ээлжит хурлыг 2 жил тутамд нэг удаа НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга зарлан хуралдуулна.

- Улс орнуудаас гэрээний хэрэгжилтийн талаар эхний болон ээлжит илтгэлүүдийг хүлээн авч хэлэлцэх: Гэрээний хороод нь гишүүн улсууд тухайн гэрээний дагуу хүлээсэн үүргээ хэрхэн хэрэгжүүлж буйг хянах механизм учраас бүх гишүүн улс тухайн Конвенцид нэгдэн ормогцоо түүнд дурдагдсан эрхийн хэрэгжилтийн талаар ээлжит илтгэлүүдийг хороонд шилжүүлэх үүрэг хүлээдэг. Гишүүн улс нь эхний илтгэлийг Конвенцид нэгдэн орсноос хойш нэг жилийн дараа, харин дараагийн илтгэлүүдээ Хорооноос хүссэн үед (ихэвчлэн 4 жил тутамд) шилжүүлэх үүрэгтэй. Гэрээний хороод илтгэл бүрийг хянан үзэж, зөвлөмж, дүгнэлтийг багтаасан “Ажиглалт дүгнэлт” (Concluding observations) гаргадаг.

Гэрээний хороодоос Гишүүн улсуудад хандаж гаргах дүгнэлт, зөвлөмж нь заавал биелэгдэх, хууль зүйн үр дагаврыг агуулдаггүй хэдий ч энэ талаарх ёс зүйн үүрэг хариуцлага Гишүүн улсуудад байнга үүсгэж байдаг.

Монгол улсад ТББ-ууд нь өөрсдийн ажилладаг хүний эрхийн асуудлаараа Гэрээний хороодод сүүдэр илтгэл бичиж явуулж байсан туршлага бий. Т ухайлбал, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн Монголын Үндэсний Сүлжээ, Хүүхдийн байгууллагуудаас холбогдох конвенциудын хэрэгжилтийн асуудлаар сүүдэр илтгэл бэлтгэн явуулж байсан.

Монгол улс Гэрээний хороодод тайлан илтгэл явуулах үүргээ хэрхэн хэрэгжүүлж буйг доорхи хүснэгтээр үзүүлэв.

№	Хүний эрхийн гэрээ (нэмэлт протокол) батлагдсан огноо	Хяналт тавих гэрээний хороо	Эхний илтгэл шилжүүлэх хугацаа (жилээр)	Ээлжит илтгэл явуулах хугацаа (жилээр)	Хоцорч буй илтгэлүүд
1	ИБУТЭХОУП, 1966	Хүний эрхийн хороо	1	4	2003.03.31-нд 5-р илтгэлээ шилжүүлэх ёстой байсан ч 2009.6 сард илгээжээ.
	ИБУТЭХОУП-ын нэмэлт протокол 1				
	ИБУТЭХОУП-ын нэмэлт протокол 2				
2	НЭЗСЭТОУП, 1966	ЭЗНСЭ-ийн хороо	2	5	2003.06.30-нд 4-р илтгэлээ шилжүүлэх ёстой. (7 жилээр хоцорч байна)
3	Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай Конвенц, 1965	АҮАБХУТК-ийн хороо	1	2	19-р илтгэлийг 2002 оноос хойш шилжүүлээгүй ба 19, 21-р илтгэлүүдийг 2010.09.05-нд шилжүүлэх үүргийг хүлээсэн.
4	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц, 1979	ЭАБХУТК-ийн хороо	1	4	5-р илтгэлийг 2002.09.03-наас хойш 4 жилээр хоцроосон ба 8, 9-р илтгэлүүдийг 2014 онд шилжүүлэх үүргийг хүлээсэн.
	ЭАБХУТК-ийн нэмэлт протокол				
5	Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенц, 1984	Эрүүдэн шүүхийн эсрэг хороо	1	4	2-р илтгэлийг 2007.02.23-наас одоог хүртэл шилжүүлээгүй байна.
6	Хүүхдийн эрхийн тухай Конвенц, 1989	Хүүхдийн эрхийн хороо	2	5	3, 4-р илтгэлийг 2008.03.31-нд илгээсэн.
	Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн нэмэлт Протокол 1, 2		2	5 жил, эсхүл дараагийн Хүүхдийн эрхийн Конвенцийн илтгэлийн хамт	
8	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенц, 2008	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороо	2011 оны 5 сард		2 нэмэлт протоколуудын эхний илтгэлүүдийг 2008.03.31-нд 2 жилээр хоцорч явуулсан
	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцийн Нэмэлт протокол				2011.06.12-нд эхний илтгэлийг шилжүүлнэ

Иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээллийнхэн хүний эрхийн гол гэрээ, конвенциудын ээлжит илтгэлийг Засгийн газраас илгээхэд өөрсдийн сүүдэр илтгэлээ бэлтгэн илгээх, Гэрээний хороодоос өөрийн улсад хандан гаргасан баримт бичгүүдтэй танилцан, үүрэг, зөвлөмжүүдийг нь хэрэгжүүлэхийг Засгийн газраасаа шаардах, нөлөөлөх зэргээр ажиллаж болно. Гэрээний хороодоос гаргах “Ажиглалт дүгнэлт”-д “Гэрээний хорооноос тухайн улсад хандаж гаргасан Зөвлөмжийг олон нийтэд тараан сурталчлах”-ыг зөвлөсөн байдгийг иргэний нийгэм, хэвлэл мэдээллийнхэн ашиглах хэрэгтэй юм.

1.3 Хүний эрхийн дээд комиссарын газар (ХЭДКГ)

ХЭДКГ нь НҮБ-ын хүний эрхийн байгууллагууд дотор нилээд онцлог байр суурь эзлэх бөгөөд Хүний эрхийн зөвлөл, Гэрээний хороод зэрэг хүний эрхийн бусад байгууллагуудын хоорондын уялдаа холбоог хангах, үйл ажиллагаанд зохион байгуулалт, арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилго бүхий тэргүүлэгч байгууллага юм. Товчоор хэлбэл, ХЭДКГ нь хүн бүрт, бүх эрхийг нь эдлүүлэх, хамгаалах, хөхиүлэн дэмжих зорилго бүхий НҮБ-ын дүрмээр олгогдсон өвөрмөц мандат бүхий байгууллага юм.

ХЭДКГ-ын ажлын тэргүүлэх чиглэл нь хүний эрхийн олон улсын гэрээнүүдийн хэрэгжилтийг хангахын тулд улс орнууд, орон нутгийн түвшинд нягт хамтран ажиллах, ХЭДКГ үүнд тэргүүлэгч үүрэгтэй байх, иргэний нийгмийн байгууллагууд, НҮБ-ын агентлагуудтай нягт хамтран ажиллах зэрэг болно.

ХЭДКГ нь энэ зорилгоо хэрэгжүүлэхийн тулд улс орнуудын Засгийн газар, Парламент, шүүх эрх мэдлийн болон цагдаа, хорих ял эдлүүлэх байгууллагууд, хүний эрхийн үндэсний байгууллагууд, ТББ, иргэний нийгмийн бусад субъектүүдтэй хамтран ажилладаг.

Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийнхэнд ХЭДКГ нь нээлттэй бөгөөд хэрэв Та бүхэн www.ohchr.org веб сайт руу нь зочилбол хэвлэл мэдээллийн төвдөө ирүүлсэн шинэ мэдээлэл, ХЭДКГ-ын хийхээр төлөвлөж буй арга хэмжээнүүдийн хуваарь, номын сан, улс орнууд

болон бүсийн хэмжээний салбар оффисууд, холбогдох хаяг зэрэг хэрэгцээтэй мэдээллүүдийг олж авах болно.

ХЭДКГ нь статусын хувьд НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын газрын нэгэн хэсэг бөгөөд 1993 онд байгуулагдсан.⁴

ХЭДКГ-ыг Хүний эрхийн дээд комиссар (ХЭДК) удирдан ажилладаг. ХЭДК нь НҮБ-ын хүний эрхийн асуудал хариуцсан гол албан тушаалтан болно. Одоогийн ХЭДК Navanethem Pillay нь 6 дахь ХЭДК бөгөөд 2008 оны 07-р сарын 28-ны өдөр Ерөнхий

ХЭДК-ын бүрэн эрх

ХЭДК-т Ерөнхий Ассамблейгээс 1993 оны 12 сарын 20-ны 48/141 тоот шийдвэрээр олгосон мандатын дагуу ХЭДК нь дараах бүрэн эрхийг эдэлдэг:

- Хүн бүрт, бүх эрхийг нь эдлүүлэх, хөхиүлэн дэмжих, хамгаалах
- Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах зорилгоор НҮБ-ын системийн эрх бүхий байгууллагуудад зөвлөмж гаргах
- Хүний эрхийн үйл ажиллагаанд техникийн туслалцаа үзүүлэх
- Хүний эрхийн боловсрол, олон нийтэд мэдээлэл түгээх НҮБ-ын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах
- Хүн бүрт эрхийг нь эдлүүлэхэд учирч буй бэрхшээлийг даван туулах, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах
- Хүний эрхийн хэрэгжилтийг баталгаажуулах үүднээс Засгийн газруудтай ярилцлага зохион байгуулах
- Олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх
- НҮБ-ын системийн байгууллагуудын хүрээнд хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах,
- НҮБ-ын хүний эрхийн механизмыг боловсронгуй болгох, үр нөлөөг нь нэмэгдүүлэх

⁴ Ерөнхий Ассамблейн 1993 оны 12 сарын 20-ны 48/141 тоот шийдвэр

Ассамблейгаас томилогдсон, Өмнөд Африкаас гаралтай, хуульч мэргэжилтэй хүн юм.

ХЭДКГ-ын Женев болон Нью-Йоркод орших төв байр, 11 улс дахь салбар оффис, 7 бүсийн хэмжээний оффист нь нийт 850 гаруй ажиллагсадтай (2007 оны 4-р сарын байдлаар).

ХЭДК-ын мандатын хүрээнд эрхлэх ажлыг нь төрөлжүүлэн авч үзвэл:

- Тодорхой сэдэвчилсэн ажлынхаа (thematic issues) хүрээнд ХЭДК нь, уур амьсгалын өөрчлөлт, жөндөрт суурилсан хүчирхийлэл зэрэг тулгамдаж буй хүний эрхийн тодорхой асуудлуудаар ажилладаг. Өөрөөр хэлбэл, ХЭДК нь хүний бүхий л төрлийн эрхийг хамгаалах, дэмжин ажиллах мандаттайн хувьд, хүний эрхийн тодорхой төрлүүдэд тусгайлан анхаарч болно.

- Стандарт тогтоох ажлын (standard-setting) хүрээнд, хүний эрхийн олон улсын хэм хэмжээг бий болгоход хувь нэмрээ оруулан ажилладаг.

- Мониторингийн ажлын хүрээнд ХЭДКГ нь, хүний эрхийн олон улсын стандарт, хэм хэмжээнүүдийн хэрэгжилтийг баталгаажуулах зорилгоор ажилладаг. Энэ хүрээнд, ХЭДКГ нь ХЭЗ-ийг дэмжиж, өдөр тутмын ажлыг эрхлэн хэрэгжүүлдэг. Түүнчлэн ХЭЗ-өөс сонгогддог Тусгай хэрэгслүүд (тусгай илтгэгч, бие даасан шинжээч, ажлын хэсэг зэрэг)-үүдийн үйл ажиллагааг дэмжиж ажилладаг.

- Хүний эрхийн ноцтой зөрчил, хямрал үүсэх, хурцдахаас урьдчилан сэргийлэхэд улс орнуудад техникийн туслалцаа үзүүлэх, шаардлагатай тохиолдолд төлөөлөгчөө илгээх зэргээр ажилладаг.

- Хүний эрхийн боловсролыг дэмжих хүрээнд ХЭДКГ нь НҮБ-ын системийн байгууллагууд дотроо болон олон нийтэд хүний эрхийн тодорхой ажлыг зохион байгуулах, дэмжих, мэдээлэл түгээх ажлыг зохион байгуулдаг. Тухайлбал, олон нийтийн хүний эрхийн боловсролыг дэмжих зорилгоор НҮБ-ын хүний эрхийг хамгаалах механизмууд (ХЭЗ, Тусгай хэрэгслүүд, гэрээний хороод зэрэг)

болон тодорхой эрхийн асуудлаар цуврал мэдээллийн хуудас, гарын авлага тогтмол хэвлүүлэн үнэгүй тараадаг юм.

Тиймээс ХЭДКГ-ыг НҮБ-ын “хүний эрхийн элч байгууллага”, ХЭДКГ-ыг “хүний эрхийн элч” хэмээн ойлгож болно. Иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээллийнхэн Женев дэхь ХЭДКГ-аас гадна өөрийн орон дахь ХЭДКГ-ын салбар оффистой хамтран ажиллаж болно. Монгол улсад салбар нь байхгүй ч НҮБ-ын тодорхой салбар эрхийн чиглэлээр ажилладаг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүн амын сан зэрэг төрөлжсөн байгууллагууд үйл ажиллагаа явуулдаг.

1.4 НҮБ-ын хүний эрхийн механизмуудтай иргэний нийгмийн байгууллагууд хэрхэн хамтран ажиллаж болох вэ?

Иргэнийн нийгмийн байгууллагууд НҮБ-ын хүний эрхийн механизмууд (ХЭДКГ, ХЭЗ, Гэрээний хороод, Тусгай хэрэгслүүд) дараах байдлаар хамтран ажиллаж болно:

- Тодорхой хувь этгээдтэй холбоотой гомдол гаргах
- НҮБ-ын хүний эрхийн дээр дурдсан механизмуудаас өөрийн улсад хандаж гаргасан Зөвлөмж, илтгэлүүдийг олон нийтэд эх хэлнээ орчуулж тараах, биелүүлэх талаар тодорхой арга хэмжээ авахыг Засгийн газраасаа шаардах,
- Хүний эрхийн тодорхой асуудлуудын талаар мэдээлэл, анализаар Тусгай хэрэгслийн мандат эзэмшигчийг хангах, илтгэл бэлтгэж шилжүүлэх
- ХЭДК, Тусгай хэрэгслийн мандат эзэмшигч, гэрээний хороодыг улс орондоо айлчлал хийлгэхэд нь дэмжлэг үзүүлэх
- Дээрх субъектүүдийг бүрэн эрхээ эдлэх, дагалдах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, олон нийтэд түгээх ажилд нь үндэсний болон орон нутгийн түвшинд ажиллах

- Өөрсдийн санаачилсан арга хэмжээндээ оролцуулахаар урих
- Жилийн туршид эдгээртэй уулзалт зохион байгуулах, хуралдаанаараа Хэлэлцэх асуудал (Agenda)-ынх нь төлөвлөгөөтэй танилцах, хуралдаанд нь оролцох зэрэг байж болно.

2. UPR буюу Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт, хэлэлцүүлэг

2.1 UPR-ийн тухай ойлголт, ач холбогдол

UPR нь НҮБ-ын гишүүн 192 улс дахь хүний эрхийн төлөв байдлыг дөрвөн жил тутамд дүгнэн хэлэлцдэг өвөрмөц үйл явц юм. Энэ нь ХЭЗ-д суурилсан, үр нөлөө бүхий шинэ арга хэрэгсэл бөгөөд 2006 оны 3-р сарын 15-ны өдөр НҮБ-ын Ерөнхий ассамблейн 60/251 тоот шийдвэрээр ХЭЗ-ийг байгуулахад нэг үндсэн чиг үүрэг нь болон батлагдсан.

Гэрээний хороод нь зөвхөн тухайн гэрээний гишүүн орнуудад хамааралтай бөгөөд зөвхөн тухайн гэрээнийхээ хэрэгжилтийг хянан хэлэлцдэг. Гэтэл НҮБ-ын гишүүдээс олон улсын хүний эрхийн гэрээ хэлэлцээрт нэгдэн ороогүй олон улс орон гэрээний хороодын хяналтаас гадуур үлддэг байв. Харин UPR бий болсоноор аль нэгэн гэрээгээр хязгаарлагдахгүй хүний эрхийн бүхий л асуудлыг нэг дор хэлэлцэх боломж олгосноос гадна НҮБ-ын гишүүн бүх улсыг хамрах болсноороо илүү ач холбогдолтой бөгөөд одоогийн байдлаар энэ төрлийн өөр механизм байхгүй байгаа юм.

UPR-ийн бас нэгэн онцлог нь бүх улсуудад ялгаваргүй, тэгш хандах, хэлэлцүүлэгт орж байгаа улстай хамтран ажиллах зарчимд үндэслэдэгт оршино.

UPR-ийн эцсийн зорилго нь бүх дэлхийн хүмүүсийн тусын тулд улс орнуудын хүний эрхийн нөхцөл байдлыг газар дээр нь сайжруулахад оршино. Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд улс орнууд дахь хүний эрхийн төлөв байдлыг үнэлэх, хүний эрх зөрчигдөх тохиолдол бүрт

анхаарлаа хандуулах боломжийг эрэлхийлэх бөгөөд улс орнуудад техникийн туслалцаа үзүүлэх, хүний эрхийн салбар дахь сайн туршлагаа хуваалцах, бие биенээсээ суралцах боломжийг олгох, хүний эрхийн асуудлаа сайнаар шийдвэрлэх чадавхийг бэхжүүлэх явдал юм.

2.2 UPR-ийг хэн явуулах вэ?

Дээр дурьдсанаар UPR –ийг ХЭЗ эрхлэн явуулах ба зөвлөлийн 47 гишүүнээс бүрдсэн UPR-ийн Ажлын хэсэг гардан явуулна. UPR-д орж буй улсын хүний эрхийн төлөв байдлыг Ажлыг хэсгээр авч хэлэлцэх ба Ажлын хэсгийн хуралдаанаас гаргасан шийдвэрийг ХЭЗ-ийн Бүгд хурлаар хэлэлцэн батлана. Ажлын хэсгийн хуралдааныг удирдан явуулах, ажлын хэсгийн илтгэлийг бэлтгэх үүрэг бүхий 3 илтгэгчийг (Гурвал) ХЭЗ-ийн гишүүдийн дундаас шодох аргаар сонгоно. Гэхдээ газар зүйн өөр өөр бүсийн төлөөлөл байх ёстой. UPR-т орж буй тухайн улс 3 илтгэгчийн нэгийг нь өөрийн хамаарах бүсээс сонгохыг санал болгож болно. Гурвал нь Ажлын хэсгийн хуралдааны үеэр хэлэлцүүлэгт орж буй улсад тавигдах асуулт болон хэлэлцэх асуудлуудыг урьдчилан бэлтгэж болно. ХЭДКГ нь Гурвалыг шаардлагатай тусламж, мэдээллээр хангах үүрэг хүлээнэ.

2.3 Монгол улс хэлэлцүүлэгт хэзээ орох вэ?

Нэг жилд нийт 48 улс UPR-т орох ба 4 жилд НҮБ-ын 192 гишүүн улсууд хүний эрхийнхээ төлөв байдлыг хэлэлцүүлж дууссан байна. Үүнийг UPR-ийн нэг мөчлөг гэнэ. Ажлын хэсэг жилд 3 удаа хуралддаг тул 2 долоо хоног үргэлжлэх нэг удаагийн хуралдаанаар 16 улсын хүний эрхийн асуудлыг авч хэлэлцдэг.

Дүгнэлт хэлэлцүүлгийн ээлж дарааллыг тогтооход газар зүйн тэнцвэрт байдлыг харгалзан үзэх ба үүний тулд эхний ээлжинд хэлэлцүүлэгт орох гишүүн болон ажиглагч улсуудыг бүсийн бүлгүүдээс сугалах байдлаар сонгоно. Сайнд ураараа хэлэлцүүлэгт орохоос бусад тохиолдолд хэлэлцүүлэгт орохоор сонгогдсон улсууд нь цагаан толгойн үсгийн дарааллаар хэлэлцэгдэнэ. Ингэхдээ

ХЭЗ-ийн гишүүн улс гишүүнийхээ бүрэн эрхийн хугацаанд дүгнэлт хэлэлцүүлэгт орох зарчмыг баримтлана.

ХЭЗ-нь дээрх зарчмын дагуу 2007 оны 9-р сарын 21-нд UPR-ийн эхний мөчлөгийн календарийг баталсан ба үүний дагуу UPR-ийн эхний хэлэлцүүлэг 2008 оны 4-р сард эхэлсэн байна.

Монгол улс 2010 оны 11-р сарын 23-ны өдөр UPR-т орж, хүний эрхийн төлөв байдлаа НҮБ-ийн ХЭЗ-д тайлагнан, хүний эрхийн хэрэгжилтийг сайжруулах талаар дүгнэлт зөвлөмжийг хүлээн авах ба сайн дурын амлалт үүрэг ч авч болно. Монгол улсын хүний эрхийн төлөв байдлыг хэлэлцээд гаргасан Ажлын хэсгийн хуралдааны шийдвэрийг 2011 оны 3-р сард болох ХЭЗ-ийн Ээлжит Бүгд хурлаар батлана.

2.4 UPR юунд үндэслэх вэ?

UPR-ийн хэлэлцүүлэгт орж буй улсын хүний эрхийн төлөв байдлыг үнэлэхдээ тухайн улс нь хүний эрхийг хангах хамгаалах талаар олон улсын өмнө хүлээсэн дараахь үүрэг амлалтуудаа хэрхэн биелүүлж байгааг дүгнэн үзнэ.

Үүнд:

- НҮБ-ын дүрэм;

- ХЭТТ;

- Нэгдэн орсон хүний эрхийн олон улсын болон бүс нутгийн гэрээ, хэлэлцээр;

- Тухайн улсаас ХЭЗ-ийн гишүүнд нэр дэвшихдээ авсан болон олон улсын өмнө авсан бусад үүрэг амлалтууд;

- Түүнчлэн Олон улсын хүний эрхийн хэм хэмжээ болон олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн харилцан хамааралт байдлаас хамааран хэлэлцүүлэгт олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг хэрэглэж болно. Ингэхдээ дараахь баримт бичгүүдэд үндэслэн хэлэлцүүлэг явагдана.

- UPR-т орж буй улсын Засгийн газрын бэлтгэн ирүүлсэн Үндэсний илтгэл. Үндэсний илтгэл нь 20 хуудсаас илүүгүй байх ба хүний эрхийн үндэсний байгууллага, иргэний нийгмийн байгууллагууд зэрэг бүх талуудтай өргөнөөр зөвлөлдсөний үндсэн дээр бэлтгэхийг НҮБ зөвлөмжилсөн.

- НҮБ-ийн хүний эрхийн тусгай хэрэгслүүд, гэрээний хороод, бусад хүний эрхийн болон төрөлжсөн байгууллагуудын мэдээллийн эмхтгэл. Эдгээр байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийг ХЭДКГ 10 хуудсанд багтаан эмхтгэнэ.

- ТББ-ууд, хүний эрхийн үндэсний байгууллагууд зэрэг холбогдох бусад талуудаас ирүүлсэн мэдээлэл. Нэг илтгэл 5 хуудсаас илүүгүй байх ба ХЭДКГ тэдгээрийг нэгтгэн 10 хуудас эмхтгэл бэлтгэнэ.

2.5 UPR дахь ТББ-ууд, хэвлэл мэдээллийнхний үүрэг

ХЭЗ нь хуучин НҮБ-ын Хүний эрхийн комиссын зарим чиг үүргийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж буй байгууллагын хувьд тухайн үед мөрдөж байсан зарим нэг журмыг үйл ажиллагаандаа хэвээр баримталж байна. Үүний нэг нь ХЭЗ-ийн үйл ажиллагаанд ТББ-уудын оролцох журмын талаар Хүний эрхийн комиссын үед дагаж мөрдөж байсан Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн 1990/31 тоот тогтоол юм. Энэ тогтоолын дагуу зөвхөн Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн зөвлөх болон тусгай статус бүхий ТББ-ууд ХЭЗ-ийн үйл ажиллагаанд оролцох, аман болон бичгэн мэдэгдэл, мэдээлэл хийх боломжтой юм. Гэхдээ ийм статусгүй ТББ нь статус бүхий ТББ-тай хамтран эсвэл уламжлан ХЭЗ-ийн хуралдаанд мэдээлэл, мэдэгдэл хүргүүлж болно.

Гэхдээ олзуурхууштай нь UPR нь ТББ-уудын оролцоог илүү нэмэгдүүлж чадсанаараа давуу талтай шинэ механизм болж чадсан. Учир нь Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн статусаас үл хамааран ямар ч ТББ UPR-т тайлан мэдээлэл хүргүүлэх, Ажлын хэсгийн хуралдаан болон түүний шийдвэрийг хэлэлцэн батлах ХЭЗ-ийн Бүгд хуралд оролцох боломжтой юм.

Ингээд UPR-ийн үе шат бүрд ТББ хэрхэн оролцож болох талаар авч үзье. UPR нь үндэсний хэмжээнд жинхэнэ үр дүн авчрах буюу хүний эрхийн байдлыг газар дээр нь сайжруулах, Засгийн газрын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх үндэсний үйл явц байх ёстой, олон нийт ч энэ шинэ механизмаас чухам үүнийг л хүсэж байна. Хүмүүсийн энэ хүлээлтийг хэрэгжүүлэхэд хэвлэл мэдээллийн үүрэг оролцоо нэн чухал юм. Иймээс ч UPR-ийн асуудлаарх төрийн бус байгууллагын форумаас хэвлэл мэдээллийн цогц стратеги боловсруулан UPR-ийн явцад хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

2.5.1 Илтгэл бэлтгэн илгээх шатанд:

ТББ-ын илтгэл бэлтгэн илгээх: Иргэний нийгмийн байгууллагууд өөрийн улс орон дахь хүний эрхийн анхаарал татсан асуудлаар илтгэл бэлтгэн илгээж болно. Хэд хэдэн байгууллага хамтран нэгдсэн илтгэл бэлтгэх эсвэл нэг байгууллага дангаараа ч илтгэл илгээж болно. Төрийн бус байгууллагуудаас ирсэн илтгэлүүдийг ХЭДКГ нэгтгэн 10 хуудас эмхтгэл бэлтгэдэг. UPR-т илгээх төрийн бус байгууллагын илтгэл нь гэрээний хороодод илгээдэг илтгэлээс дараахь байдлаар ялгаатай:

- Гэрээний хэрэгжилтийн илтгэл нь Засгийн газрын илтгэл илгээгдсэний дараа гардаг “Сүүдэр илтгэл” байдаг бол UPR-ийн үед ТББ-уудын илтгэл нь Засгийн газрын бэлтгэх үндэсний илтгэлээс түрүүлж гардаг.

- Гэрээний хороодын хуралдаан дээр хэлэлцэгдэх асуудал нь Засгийн газрын илтгэл дээр үндэслэн явагддаг бол UPR-т ТББ-уудын илтгэл нь Засгийн газрын бэлтгэх үндэсний илтгэлтэй адил хэмжээнд хэлэлцэгдэнэ.

- Гэрээний хороодод зөвхөн тухайн хүний эрхийн гэрээний хэрэгжилтийн талаар илтгэл илгээдэг бол UPR-т хүний эрхийн аль ч асуудлыг хөндөж болно.

Иймээс UPR нь ТББ-уудад өөрийн улсын хүний эрхийн зөрчилтэй асуудлыг олон улсын тавцанд гарган ирж, дэмжлэг авах, төр

засагтаа шахалт үзүүлэх нэг боломж учраас улс орнуудын ТББ-ууд UPR хэмээх хүний эрхийн ээлжит дүгнэлт, хэлэлцүүлгийн энэ шинэ механизмыг үр дүнтэй ашиглахад онцгой анхаарч байна. Монголын ТББ-ууд ч 2010 оны нэгдүгээр сарын 11-13-ны өдрүүдэд чуулж, **“UPR-ийн асуудлаарх төрийн бус байгууллагуудын форум”**-ыг үүсгэн байгуулж, UPR-т Форумаас илгээх нэгдсэн болон тодорхой асуудлуудаар сэдэвчилсэн илтгэл бэлтгэх Ажлын хэсгүүд байгуулан идэвхитэй ажиллаж байна. ТББ-ын илтгэл илгээх сүүлийн хугацаа нь 2010 оны 4 сарын 19-ны өдөр юм.

Үндэсний илтгэл бэлтгэхэд оролцох: ХЭЗ-ийн 2007 оны 6-р сарын 18-ны өдрийн 5/1 тоот тогтоолд зааснаар Засгийн газар нь Үндэсний илтгэл бэлтгэн илгээх үүрэгтэй ба үндэсний хэмжээнд холбогдох бүх талуудтай өргөнөөр зөвлөлдөн илтгэлээ бэлтгэхийг Засгийн газарт зөвлөмжилсөн байдаг нь төрийн бус байгууллагуудад бас нэгэн боломж олгосон хэрэг юм.

Иймд энэ үе шатанд хийх ТББ-уудын нэг ажил бол Үндэсний илтгэлийг бүх талын оролцоотой бэлтгэх талаар Засгийн газарт нөлөөлөх явдал юм. Бусад улс орнуудад Засгийн газрын бэлтгэсэн Үндэсний илтгэлийг Парламент дээр хэлэлцэн батлах, ингэхдээ олон нийтийн хэлэлцүүлэг явуулж санал авах зэрэг ажил хийгдэж байна. Монголын ТББ-ууд энэ чиглэлээр тодорхой ажлууд төлөвлөсөн бөгөөд Үндэсний илтгэл бэлтгэх Засгийн газрын ажлын хэсэгт иргэний нийгмийн төлөөллийг оролцуулах хүсэлт тавиад байна.

Энэ үе шатанд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд Үндэсний илтгэлийг олон талын оролцоотой, ил тод байдлаар бэлтгэх талаар Засгийн газарт нөлөөлөх, Үндэсний илтгэлийг олон нийтэд мэдээлэхэд чиглэсэн нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэхэд анхаарах хэрэгтэй. Ингэснээр хүний эрхийн ноцтой зөрчлүүд, тэдгээрийг арилгах арга хэмжээний талаар авч хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхгүй байгаа арга хэмжээнүүдийн талаарх мэдээлэл Үндэсний илтгэлд үнэн зөв тусгасан эсэхэд олон нийтээс үнэлэлт дүгнэлт өгөх, хариуцлага шаардахад их хувь нэмэр оруулах юм. Монголын Засгийн газар Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ахлуулсан Үндэсний илтгэл бэлтгэх ажлын хэсэг байгуулсан байна.

Хүний эрхийн үндэсний комиссын илтгэлд оролцох: Хүний эрхийг хангах, хамгаалах үндсэн чиг үүрэг бүхий, хуулиар олгогдсон өргөн эрх мэдэлтэй, бие даасан хүний эрхийн байгууллагын хувьд улс орнуудын хүний эрхийн үндэсний байгууллага UPR-т илтгэл мэдээлэл илгээх боломжтой. Хүний эрхийн үндэсний комиссын илтгэлээ илгээх сүүлийн хугацаа нь 2010 оны 4-р сарын 19-ний өдөр буюу ТББ-уудтай ижил юм. Бусад улс орны хүний эрхийн үндэсний байгууллагууд илтгэлээ бэлтгэхдээ бусад талууд, ялангуяа иргэний нийгмийн байгууллагуудтай зөвлөлдөн бэлтгэдэг. Түүнчлэн Засгийн газрын бэлтгэж буй Үндэсний илтгэлд нилээд шүүмжлэлтэй байр сууринаас хандан оролцдог.

Иймд Монголын ТББ-ууд илтгэлээ олон талын оролцоотой бэлтгэхийг Хүний эрхийн үндэсний комиссоос шаардах нөлөөллийн ажлуудыг Хүний эрхийн үндэсний комиссын дэргэд ажилладаг Орон тооны бус зөвлөлөөр дамжуулан хийхээр төлөвлөж байна. Гэхдээ илтгэл явуулах цаг хугацаа тулсан энэ үед Хүний эрхийн үндэсний комисс ТББ-уудтай ямар хэмжээгээр хамтран ажиллах, илтгэлээ ил тод болгох талаар авсан тодорхой арга хэмжээ байхгүй байна.

Иймд энэ шатанд хэвлэл мэдээллийн байгууллагууд Хүний эрхийн үндэсний комиссын илтгэлийг олон талын оролцоотой бэлтгэж буй эсэхэд асуулга тавих зэргээр илтгэлийг олон нийтэд нээлттэй, ил тод болгоход чиглэсэн мэдээ, мэдээлэл, ярилцлага, хэлэлцүүлэг өрнүүлж болно.

НҮБ-ын Гэрээний хороод бусад НҮБ-ын байгууллагуудад мэдээлэл явуулж, тодорхой асуудлууд тусгахыг хүсэх: Дээр дурьдсанаар UPR-ийн хэлэлцүүлэг үндэслэх баримт бичгүүдийн нэг нь НҮБ-ын байгууллагуудаас тухайн улсын хүний эрхийн төлөв байдлын талаар гаргасан тайлан, мэдээ, мэдээлэл, шаардлагуудын эмхэтгэл байдаг. Иймд энэ үе шатанд улс орны дотоод дахь хүний эрхийн ноцтой болон ужиг зөрчлүүдийн талаар, ялангуяа Засгийн газрын илтгэлд тусгагдаагүй үлдсэн асуудлуудын тухай мэдээллийг НҮБ-ын байгууллагуудад явуулж илтгэлдээ тусгахыг хүсэх нь чухал юм.

Хэвлэл мэдээллийн байгууллагууд нь хүний эрхийн тодорхой асуудалд НҮБ-ын хүний эрхийн болон төрөлжсөн байгууллагууд, гадаад орнуудын төр засаг, Монгол улс дахь дипломат төлөөлөгчдийн газрын анхаарлыг хандуулах чиглэлээр ажиллах нь чухал. Учир нь Женевт суугаа дипломат төлөөлөгчид ажлын хэсгийн хуралдаан дээр асуух асуулт, гаргах зөвлөмжөө бэлтгэхдээ ихэвчлэн тухайн улсад суугаа өөрийн орны дипломат төлөөлөгчдөөс мэдээлэл хүсдэг тул энэ чиглэлийн үйл ажиллагаа чухал байдаг.

2.5.2 UPR-ийн Ажлын хэсгийн хуралдааны үеэр

2010 оны 11-р сарын 23-ны өдрийн ХЭЗ-ийн UPR-ийн Ажлын хэсгийн хуралдаанаар Монгол улсын хүний эрхийн төлөв байдлыг хэлэлцэнэ. Ажлын хэсэгт ХЭЗ-ийн гишүүн 47 улс оролцох ба ажиглагч улсууд ч оролцож болно. Энэ хуралдаан нь 3 цаг үргэлжлэх ба асуулт хариултын хэлбэрээр явагдаж, Монгол улсын засгийн газрын төлөөлөгчид хуралдаанд оролцоно. Ажлын хэсгийн хуралдаанаас Монгол улсын Засгийн газарт хандсан дүгнэлт, зөвлөмжүүд гарах ба Засгийн газар сайн дурын амлалт үүрэг авах боломжтой.

Ажлын хэсгийн хуралдаанд ТББ-ууд оролцож болох ч үг хэлэх, асуулт асуух эрхгүй. Иймд энэ үе шатанд ТББ-ууд UPR-ийн Ажлын хэсгийн гишүүдэд хандсан нөлөөлөл хийж, үндэсний тайланд тусгагдаагүй, Засгийн газар арга хэмжээ авахгүй байгаа хүний эрхийн асуудлуудын талаар асуулт асуулгаж болно. Ийнхүү асуусан асуулт, Засгийн газрын хариулт нь ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлд тусгагдан, UPR-ын эцсийн шийдвэрт нөлөөлөх тул энэ чиглэлийн нөлөөллийн үйл ажиллагаа маш чухал. Түүнчлэн Засгийн газар олон улсын өмнө хүний эрхийн үүрэг, хариуцлагаа хэрхэн тайлбарлаж, ямар амлалт авч байгаад хяналт тавих, түүнийг нь ард түмэндээ мэдээлэхэд энэ үе шат маш их ач холбогдолтой.

Энэ хэсэгт хэвлэл мэдээлэл ямар үүрэгтэй вэ?

- Хуралдаанаас өмнө хүний эрхийн тодорхой асуудалд ХЭЗ-ийн

гишүүдийн анхаарлыг хандуулах

- Ажлын хэсгийн хуралдааныг шууд сурвалжлах
- Ажлын хэсгийн хуралдааныг webcast-аар (интернэтээр) шууд дамжуулдаг бичлэг нь архивт хадгалагддаг тул түүнийг олон нийтэд хүргэх
- Засгийн газрын төлөөлөгчийн хэлсэн үг, хариулт, авсан амлалтыг олон нийтэд хүргэх

2.5.3 Ажлын хэсгийн хуралдаанаас ХЭЗ-ийн Бүгд хурал хүртэл (2010.11.23 - 2011.03 сар)

Энэ хугацаа Засгийн газар Ажлын хэсгийн хуралдаанаас гарсан аль зөвлөмжийг хүлээн зөвшөөрөх эсэхээ шийдэх, эсвэл амлалт үүрэг авах үе тул аль болох олон зөвлөмжийг хэрэгжүүлнэ гэсэн амлалтыг Засгийн газраар авахуулахад ТББ-уудын нөлөөлөл чиглэгдэнэ. Түүнчлэн Бүгд хуралд ТББ оролцох, үг хэлэх, асуулт асуух эрхтэй тул түүнийг ашиглах хэрэгтэй.

Үүний тулд Ажлын хэсгээс гаргасан дүгнэлт зөвлөмжид дүн шинжилгээ хийж, нөлөөллийн ажлын чиглэлээ тодорхойлно. Иймд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд Засгийн газраар аль болох олон зөвлөмжийг хүлээн зөвшөөрүүлэх, олон амлалт авахуулахад иргэний нийгмийн байгууллагуудыг дэмжихэд нийтлэл, нэвтрүүлгээ чиглүүлэх нь чухал юм.

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд энэ үе шатанд дээрхийн адил Бүгд хурлыг шууд сурвалжилж, бичлэгийг олон нийтэд хүргэх боломжтой. Энэ нь Бүгд хуралд оролцож байгаа Засгийн газрын төлөөлөгчдөд ард түмэн өөрийг нь хянаж байгаа гэдгийг мэдрүүлэн хариуцлагатай байх эрмэлзлийг төрүүлэхэд тус дэм болно.

2.5.4 UPR-ын дараа

UPR-аас дараахь агуулга бүхий шийдвэр гарна:

- Хүний эрхийн төлөв байдалд өгсөн үнэлэлт
- Дэвшилттэй талууд
- Хүний эрхийг хамгаалахад хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай асуудлууд

- Хүний эрхийг хангах, хамгаалах талаар тухайн улсын чадавхийг бэхжүүлэх, техникийн туслалцааны асуудлууд
- Засгийн газрын авсан сайн дурын амлалт, үүрэг
- ХЭЗ-өөс Засгийн газарт, Хүний эрхийн үндэсний байгууллагуудад өгсөн зөвлөмжүүд

Дээрх шийдвэрүүдийг олон нийтэд ойлгуулах замаар хэрэгжилтийг хангахад чиглэсэн олон талын нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах шаардлагатай. Шийдвэрийг олон нийтэд хүргэх, хэрэгжилтийг Засгийн газраас шаардахад хэвлэл мэдээллийн үүрэг асар чухал билээ.

2.5.5 НҮБ-ийн ХЭЗ дээрх UPR-ийн хэлэлцүүлгийг хэрхэн сурвалжлах вэ?

UPR-ийн ажлын хэсгийн хуралдааныг Женевээс шууд сурвалжлахаас гадна интернет webcast-ийн бичлэгээс

<http://www.un.org/webcast/unhrc/index.asp>

хаягаар орж үзэж болно.

Түүнчлэн уулзалт бүрийн талаарх хураангуй мэдээллийг хуралдаан тус бүрээр дараахь цахим хуудаснаас авч болно.

<http://www.ohchr.org/EN/HRBodies/UPR/Pages/MediaInformation.aspx>

Женевт очин шууд сурвалжлага хийх хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь НҮБ-ын Мэдээллийн үйлчилгээний газраас зөвшөөрөл авсан байх шаардлагатай. Мэдээллийн үйлчилгээний газартай энэхүү **uprpress@ohchr.org** хаягаар холбоо барьж болно.

Зөвшөөрлийг хэрхэн авах вэ? Зөвшөөрөл авахад дараахь баримт бичгийг илгээнэ.

- Тухайн сэтгүүлчийг томилсон тухай хэвлэл мэдээллийн байгууллагын удирдлагын албан бичиг. Албан бичигт сэтгүүлчийн овог нэр, албан тушаал, НҮБ-д хичнээн хоног ажиллахаар томилогдсон тухай тодорхой дурьдсан байна.

- Сонин, сэтгүүл гэх мэт хэвлэмэл бүтээгдэхүүн гаргадаг хэвлэл

мэдээллийн байгууллага нь сүүлийн удаагийн 2 хэвлэлийг, харин телевиз, радиогийн байгууллагууд сүүлийн 2 удаагийн сурвалжлага, нэвтрүүлгээ хавсаргана.

- Хараат бус телевизүүд нэвтрүүлгийг нь цацах байгууллагын албан бичиг

Дээрхээс гадна интернетийн хэвлэл мэдээллийн байгууллага нь дараахь зүйлсийг илгээх шаардлагатай:

- Тухайн вэбсайт нь хэвлэл мэдээллийн аль нэг хэрэгсэлд хамаардаг болохыг гэрчлэх баримт болон утас, факс, шуудангийн хаяг, ажлын хаяг гэх мэт онлайн бус хаяг

- Түүнчлэн сэтгүүлч илгээхийг хүсэж байгаа онлайн мэдээллийн байгууллагууд өмнө нь олон улсын үйл явдлын талаар ямар нэгэн шууд сурвалжлага, нийтлэл бэлтгэн хэвлэж байснаа гэрчлэх баримт

- Хэрэв тухайн онлайн мэдээллийн хэрэгсэл нь шинээр байгуулагдаж байгаа бол хамгийн сүүлд вэбэд орсон зочны мэдээлэл, эсвэл вэб нь олон нийтэд хэрхэн танигдаж байгаа талаар гэрчлэх бусад баримтууд. Түүнчлэн итгэмжлэл авахыг хүсэж байгаа тухайн сэтгүүлч нь олон улсын үйл явдлын талаар өмнө нь мэдээ, сурвалжлага бэлтгэж байсан туршлагатайг харуулах баримт буюу хамгийн сүүлд бичсэн 3 сурвалжлага, мэдээ, нийтлэлийн хувийг илгээх.

Зураг бүхий биеийн байцаалт

Сэтгүүлчид 2 төрлийн зурагтай биеийн байцаалт үзүүлэх шаардлагатай. Үүнд:

- Тухайн улсын паспорт

- Ажлын үнэмлэх, сэтгүүлчийн үнэмлэх, жолооны үнэмлэх зэрэг зураг бүхий бусад биеийн байцаалт

Зөвшөөрөл хүсэх тухай өргөдлийн маягтыг дараахь цахим хуудаснаас татаж авч болно.

[http://www.unog.ch/80256EDD006B8954/%28httpAssets%29/4A6150755653B661C12573410046C989/\\$file/Accreditation+Press+IGF.pdf](http://www.unog.ch/80256EDD006B8954/%28httpAssets%29/4A6150755653B661C12573410046C989/$file/Accreditation+Press+IGF.pdf)

Зөвшөөрөл авах тухай хүсэлтээ дараахь хаягаар илгээнэ: Хэвлэл мэдээлэл ба Гадаад харилцааны хэсэгт хүсэлт гаргана. Гэхдээ хүсэлтийг хүлээж авсан эсэх талаар хүсэлт гаргагчид эргэж мэдэгддэггүй тул дараахь утсаар заавал лавлаж асуугаарай.

Факс: 41(0)22 917 00 73

Утас: +41 (0)22 917 23 13/36

Зөвшөөрөл авсаны дараа Аюулгүй байдлын хэсгээс үнэмлэх авсанаар та сурвалжлага хийхэд бэлэн болно.

Анхааруулах зүйлс: Олон нийтийн мэдээллийн хэлтэс нь тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслийг өөрийн улсдаа албан ёсны бүртгэлтэй бөгөөд сэтгүүлч нь уг байгууллагын жинхэнэ төлөөлөл мөн болохыг баталгаажуулсны дараа зөвшөөрөл олгодог. Сурвалжлага зөвхөн албан ёсны хуралдааны үеэр хийгдэх ба төрийн бус байгууллагуудаас өгч буй мэдээллийг албан ёсны сурвалжлага мэтээр нийтлэх ёсгүй. Зөвшөөрөл нь зөвхөн нэг удаагийн байна. Хэрэв сэтгүүлч НҮБ-ын дүрэмд заасан зарчмууд болон бусад журам, шаардлагуудыг зөрчсөн, зүй бусаар ашигласан, бусдын нэр төрийг гутаасан мэдээ тараасан бол зөвшөөрлийг цуцлана.

Мэдээллийн үйлчилгээний газраас сэтгүүлчдэд дараахь үйлчилгээ үзүүлдэг:

- Хэвлэх үйлчилгээ
- 2 долоо хоног тутам хэвлэл мэдээлэлд албан ёсны мэдээлэл өгөх уулзалт хийдэг. Уулзалтыг Мэдээллийн үйлчилгээний газрын дарга удирдан явуулах бөгөөд тэрээр Женев дэх НҮБ-ын байгууллагуудын хэвлэлийн асуудлыг хариуцдаг.
- Хэвлэлийн бага хурал, ярилцлага зохион байгуулах
- Женевт болж байгаа НҮБ-ын бүх үйл ажиллагааны талаарх хэвлэлийн мэдээг Англи, Франц хэлээр бэлтгэн гаргадаг.
- НҮБ-ын мэдээллүүдийг Европын болон олон улсын томоохон телевизүүдээр цацдаг.
- Хурал уулзалтууд, хэвлэлийн хурлын бичлэг зэрэг аудио материал бэлтгэдэг.
- Мөн хүсэлт гарган гэрэл зургаас сонгон авч хэрэглэх боломжтой.
- Сэтгүүлчдэд зориулсан өрөөтэй. Үүнд зөвхөн Женев хот дотор хэрэглэх утас байхаас гадна сурвалжлага, нэвтрүүлгээ бэлтгэх студи ажилладаг.

Бүлгийн дүгнэлт

UPR бол хүний эрхийн хэрэгжилтийг газар дээр нь сайжруулах, хүний эрхийн зөрчлийн хохирогч нарт туслах, улс оронд өөрчлөлт авчрах үндэсний үйл явц байх ёстой гэдгийг дахин сануулж, ийнхүү үндэсний үйл явц болгоход иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээллийнхний үүрэг, хамтын ажиллагаа шийдвэрлэх ач холбогдолтой болохыг давтан хэлэхийг хүслээ.

Хавсралт

Товчилсон үг

НҮБ – Нэгдсэн Үндэстний байгууллага
ЕА – Ерөнхий Ассамблей
АЗ – Аюулгүйн зөвлөл
ХЭЗ – Хүний эрхийн зөвлөл
НБДНГ – Нарийн бичгийн дарга нарын газар
ЗХ – Зөвлөх хороо
ҮАК - Үйл ажиллагааны комисс
ХЭДКГ – Хүний эрхийн дээд комиссарын газар
ХЭДК – Хүний эрхийн дээд комиссар
ХЭК – Хүний эрхийн комисс
ЭЗНЗ – Эдийн засаг, нийгмийн зөвлөл
ХЭТТ – Хүний эрхийн түгээмэл тунхаглал
ТББ – Төрийн бус байгууллага
ИНБ – Иргэний нийгмийн байгууллага
ИБУТЭТОУП – Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
НЭЗСЭТОУП – Нийгэм, эдийн засаг, соёлын эрхийн тухай олон улсын пакт
ЭЗНСЭХ – Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо
АҮАБХУКХ – Арьс үндсээр алагчлах бүх хэлбэрийг устгах Конвенцийн хороо
ЭАБХУТКХ – Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн хороо
ЭШЭ – Эрүүдэн шүүхийн эсрэг
ХБИЭТК – Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай Конвенци

Хүний эрхийн олон улсын гол гэрээ, конвенцууд

Дараах хүснэгтэд олон улсын хүний эрхийн гол гэрээнүүд, тэдгээрт Монгол улсын нэгдэн орсон байдал ба гэрээнүүдийн эх хувийг олж авч болох сурвалжуудыг дурьдлаа. Монгол улсын нэгдэн орсон хүний эрхийн олон гэрээ конвенц байдаг боловч дор дурьдсан конвенциуд нь олон улсад хүний эрхийн суурь баримт бичгүүд хэмээн хүлээн зөвшөөрөгддөгөөс гадна гэрээний хэрэгжилтийг хянах хороод ажилладаг учраас онцлон авч үзсэн болно.

№	Хүний эрхийн гэрээ (нэмэлт протокол) батлагдсан огноо	НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас батлагдсан он	Монгол улсын нэгдэн орсон он	Хаанаас олж авч болох вэ?			
				Англи хэлээр	Монгол хэлээр		
1	ИБУТЭХОУП	1966	1974	http://www2.ohchr.org/english/law/index.htm#core			
	ИБУТЭХОУП-ын нэмэлт протокол	1966	1991				
	НЭЭСЭТОУП	1966	1974				
3	Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай Конвенц	1965	1969				
4	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц	1979	1981				
	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн нэмэлт протокол	1999	2002				
5	Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенц	1984	2002				
6	Хүүхдийн эрхийн тухай Конвенц	1989	1990		www.legalinfo.mn эсвэл Төрийн мэдээлэл сэтгүүлийн тусгай дугаарууд		
	Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол	2000	2004				
	Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эсрэг конвенцид оруулах нэмэлт протокол	2000	2003				
7	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенц	2006	2009 (а)				
	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцийн Нэмэлт протокол	2006	2009 (а)				

Хүний эрхийн түгээмэл тунхаглал

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 217/A/ III/ тогтоолоор 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалжээ.

УДИРТГАЛ

Хүн төрөлхтний ам бүлийн гишүүн бүхэнд угаас заяасан нэр төр болон тэдний адил тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шударга ёс, бүх нийтийн энх тайвны үндэс мөнийг иш үндэс болгон;

хүний эрхийг үл тоомсорлох, басамжлах нь зон олны ариун сэтгэлийг сэвтээн жигшээсэн балмад үйлдэлд хүргэж байсан бөгөөд хүмүүс үгээ хэлэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөтэй түүнчлэн айх аюулгүй, гачигдах зовлонгүй дэлхий ертөнцийг бий болгох нь хүн ардын эрхэм дээд эрмэлзэл мөн хэмээн үзэж;

хүмүүс эзэрхэг засаглал, дарлалын эсрэг өөрийн эрхгүй эцсийн арга болгон зэвсэглэн босоход хүргэхгүйн тулд хүний эрхийг хуулиар хамгаалах нь нэн чухал гэдгийг анхааран; улс түмний хооронд найрсаг харилцаа хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх нь нэн чухлыг харгалзан;

хүн үндсэн эрхтэй, хувь хүн нэр төр, үнэ цэнэтэй, эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш эрхтэй гэдэгт Нэгдсэн Үндэстний улс түмэн итгэл төгс байгаагаа дүрмээрээ нотлохын хамт, илүү эрх чөлөөтэй байдалд нийгмийн дэвшлийг урагшлуулах, амьдралын нөхцлийг сайжруулахад дөхөм үзүүлэхээр шийдвэрлэснийг харгалзан;

гишүүн улсууд Нэгдсэн Үндэстний Байгууллагатай хамтран хүний эрх, үндсэн эрх чөлөөг нийтээр хүндлэн сахихад тус дөхөм үзүүлэх үүрэг авсныг үндэслэн;

энэхүү үүргийг бүрэн биелүүлэхэд хүний эрх, эрх чөлөөг нийтээр нэг мөр ойлгох явдал нэн чухал ач холбогдолтойг харгалзан;

тийнхүү, үүний учир,

Ерөнхий Ассамблей,

Энэхүү хүний эрхийн түгээмэл тунхаглалыг дэлхийн бүх улс түмэн, бүх улс гүрэн хэрэгжүүлэхийг эрмэлзвэл зохих нийтлэг зорилт болгон дэвшүүлж, энэ зорилтын үүднээс хүн бүр, нийгмийн нэгж байгууллага бүхэн эл Тунхаглалыг байнга бодолцон гэгээрч боловсрох замаар хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн сахихад дөхөм үзүүлэхийг эрмэлзэх ёстойг, түүнчлэн үндэсний болон олон улсын хэмжээний дэвшилтэт арга хэмжээ авах замаар эдгээр эрх, эрх чөлөөг Нэгдсэн Үндэстний гишүүн улсын ард түмэн, тэдгээр улсын эрх мэдлийн нутаг дэвсгэр дээр оршин суудаг ард түмний аль алинаар нь бүх нийтээр үр нөлөөтэй хүлээн зөвшөөрүүлж, дагаж мөрдөх явдлыг хангахад тус дөхөм үзүүлэхийг эрмэлзэх ёстойг зарлан тунхаглаж байна.

1 дүгээр зүйл

Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. Тэдэнд оюун ухаан, өрлөг сэтгэл заяасан бөгөөд өөр хоорондоо ахан дүүгийн ёсоор харилцах ёстой.

2 дугаар зүйл

Хүн бүр энэ Тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой. Мөн түүнчлэн тухайн хүнийг харьяалдаг улс буюу нутаг дэвсгэрийн улс төр, эрх зүй болон олон улсын статус ямар ч байлаа гэсэн, тухайлбал, тусгаар тогтносон буюу асрамжинд байгаа, өөрөө эс удирдах зэрэг бүрэн эрхт байдал нь ямар ч байдлаар хязгаарлагдмал байсан тэр нь ялгаварлах үндэс болох ёсгүй.

3 дугаар зүйл

Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй.

4 дүгээр зүйл

Хэнийг ч боолчлох буюу бусдын эрхшээлд байлгах ёсгүй. Аливаа төрлийн боолчлол болон боолын худалдааг хориглоно.

5 дугаар зүйл

Хэнд ч эрүү шүүлт тулган эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэх ёсгүй.

6 дугаар зүйл

Хүн бүр хаана ч байсан эрх зүйн чадвартай байх эрхээ хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй.

7 дугаар зүйл

Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчилалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. Хүн бүр энэхүү Тунхаглалд харшлах аливаа алагчилалаас болон тийнхүү алагчилахыг өдөөсөн турхиралтаас адилхан хамгаалуулах эрхтэй.

8 дугаар зүйл

Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй.

9 дүгээр зүйл

Хэнийг ч дур мэдэн баривчлах, саатуулах буюу хөөн зайлуулах ёсгүй.

10 дугаар зүйл

Хүн бүр тулгасан аливаа эрүүгийн ял болон эрх үүргээ тодорхойлуулахдаа хараат бус, тал хардаггүй шүүхээр бүрэн адил тэгш үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй.

11 дүгээр зүйл

1. Гэмт хэрэгт буруутгагдаж буй хэн боловч өмгөөлөх бүх боломжоор хангагдсан нээлттэй шүүх хурлаар гэм буруутайг нь хуулийн дагуу тогтоох хүртэл гэм буруугүй гэж тооцогдох эрхтэй.
2. Тухайн үед үндэсний буюу олон улсын хуулийн дагуу гэмт хэрэгт эс тооцож байсан аливаа үйлдэл буюу эс үйлдлийг үндэслэж, хэнийг ч гэмт хэрэгт яллан шийтгэх ёсгүй. Түүнчлэн гэмт хэрэг гарсан тэр үед ногдуулж болох байснаас илүү хүнд ял тохоож болохгүй.

12 дугаар зүйл

Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааных нь нууц болон нэр төр, алдар хүндэд нь халдах ёсгүй. Тийм оролцоо халдлагын эсрэг хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй.

13 дугаар зүйл

1. Хэн боловч улсынхаа дотор чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй.
2. Хэн боловч аливаа улс орныг, түүний дотроо эх орноо орхин явах, эх орондоо эргэж очих эрхтэй.

14 дүгээр зүйл

1. Хэн боловч мөрдөлт мөшгөлтөөс зугтаж, өөр улсад орогнох боломжийг эрэлхийлэх болон орогнох эрхтэй.
2. Улс төрийн бус гэмт хэргийн улмаас буюу Нэгдсэн Үндэстний Байгууллагын зорилго, зарчимд харш хэрэг үйлдсэний улмаас зайлшгүй мөрдөгдөж буй тохиолдолд дээрх эрхийг эдлэж үл болно.

15 дугаар зүйл

1. Хүн бүр иргэний харьяалалтай байх эрхтэй.

2. Аливаа хүний иргэний харьяалал болон харьяаллаа өөрчлөх эрхийг дур мэдэн цуцлах ёсгүй.

16 дугаар зүйл

1. Насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүс арьс үндэс, яс үндэс, шашин шүтлэгтэй холбогдсон аливаа хязгаарлалтгүйгээр гэрлэх, ерх тусгаарлах эрхтэй. Тэд гэрлэхдээ, гэрлэсний дараа болон гэрлэлтээ цуцлуулах үед тэгш эрх эдлэнэ.

2. Нөхөр, эхнэр болох хоёр хүн чөлөөтэй, харилцан бүрэн зөвшөөрсөн нөхцөлд гэрлэж болно.

3. Гэр бүл бол нийгмийн жам ёсны үндсэн нэгж мөн бөгөөд нийгэм, төрөөр хамгаалуулах эрхтэй.

17 дугаар зүйл

1. Хүн бүр эд хөрөнгийг ганцаараа буюу бусадтай хамтарч өмчлөх эрхтэй.

2. Хэний ч өмч хөрөнгийг дураар хураан авч болохгүй.

18 дугаар зүйл

Хүн бүр чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, эс шүтэх эрхтэй. Энэхүү эрхэнд шашин буюу шүтлэгээ өөрчлөх эрх чөлөө, бие даан буюу бусадтай хамтран нийтийн өмнө болон хувийн журмаар хичээл заах, хурал мөргөл хийх, шашны хийгээд зан үйлийн ёслол үйлдэх зэргээр шашин буюу шүтлэгээ номлох эрх чөлөө багтана.

19 дүгээр зүйл

Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана.

20 дугаар зүйл

1. Хүн бүр чөлөөтэй, тайван хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхтэй.
2. Хэнийг ч аливаа эвлэл холбоонд албадан оруулах ёсгүй.

21 дүгээр зүйл

1. Хүн бүр улсаа удирдахад шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох эрхтэй.
2. Хүн бүр улсдаа төрийн алба хаших тэгш эрхтэй.
3. Ард түмний хүсэл зориг бол засгийн эрх мэдлийн үндэс байх ёстой. Энэ хүсэл зориг нь сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хураах буюу саналаа чөлөөтэй гаргах явдлыг хангахуйц өөр адил чанартай хэлбэрийг ашиглах замаар явуулж байвал зохих тогтмол, хуурамч бус сонгуулиар илрэлээ олно.

22 дугаар зүйл

Хүн бүр нийгмийн гишүүний хувьд нийгмийн хангамж эдлэх, түүнчлэн нэр төрөө хадгалах, биеэ боловсруулж хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ улс бүрийн бүтэц, нөөц бололцоотой уялдуулан үндэсний хүч чармайлт хийгээд олон улсын хамтын ажиллагааны замаар хэрэгжүүлэх эрхтэй.

23 дугаар зүйл

1. Хүн бүр хөдөлмөрлөх, ажлаа чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн шударга, аятай нөхцлөөр хангуулах, ажилгүйдлээс хамгаалуулах эрхтэй.
2. Хүн бүр ямар ч алагчилалгүйгээр адил хэмжээний хөдөлмөрт адил хэмжээний шан хөлс авах эрхтэй.

3. Ажил хөдөлмөр эрхэлж байгаа хэн боловч хувийн болон ам бүлийнхээ ахуй амьжиргааг хүний зэрэгтэй авч явахад хүрэлцэхүйц бөгөөд зайлшгүй тохиолдолд нийгмийн хангамжийн эх үүсвэрээр нэмэн арвижуулсан, хийсэндээ таарсан, хүртээмжтэй шан хөлс авах эрхтэй.

4. Хүн бүр эрх ашгаа хамгаалах зорилгоор үйлдвэрчний эвлэл байгуулах буюу үйлдвэрчний эвлэлд нэгдэх эрхтэй.

24 дүгээр зүйл

Хүн бүр ажлын цагаа зохистойгоор хязгаарлуулах, цалинтай ээлжийн амралт эдлэх эрхийг оролцуулан амрах, зав чөлөөтэй байх эрхтэй.

25 дугаар зүйл

1. Хүн бүр хоол хүнс, хувцас хунар, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгэм ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаагаар байх эрхтэй. Ажилгүйдэх, өвчлөх, тахир дутуу болох, бэлэвсрэх, өтлөх, эсхүл өөрөөс үл хамаарах бусад шалтгаанаар амь зуулгагүй болох нөхцөлд тэтгэмж авах эрхтэй.

2. Эх нялхас онцгой асрамж, туслалцаа авах эрхтэй. Баталгаатай гэр бүлээс гарсан буюу бутач гэдгээс үл хамааран бүх хүүхэд нийгмээс адилхан хамгаалалт эдлэх ёстой.

26 дугаар зүйл

1. Хүн бүр сурч боловсрох эрхтэй. Наад зах нь анхан шатны болон ерөнхий боловсрол үнэ төлбөргүй байвал зохино. Анхан шатны боловсролыг заавал эзэмшүүлэх ёстой. Техникийн болон тусгай мэргэжлийн боловсрол нийтэд хүртээлтэй байх ёстой. Авъяас чадвартай нь уялдан хүн бүрт дээд боловсрол эзэмших боломж адилхан хүртээлтэй олгох ёстой.

2. Боловсрол нь бие хүнийг өв тэгш хөгжүүлэх, хүний эрх, үндсэн эрх чөлөөг улам бүр хүндэтгэдэг болоход чиглэх ёстой. Боловсрол нь аливаа улс түмэн, янз бүрийн арьстан хийгээд шашны бүлгүүд бие биеэ харилцан ойлгох, хүлцэн тэвчих, эвсэн найрамдах, мөн түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагаас энх тайвныг сахиулах талаар явуулж буй үйл ажиллагаанд дөхөм үзүүлэх ёстой.

3. Хүүхэддээ олгох боловсролын чиглэлийг сонгоход эцэг эх давуу эрх эдлэнэ.

27 дугаар зүйл

1. Хүн бүр нийгмийнхээ соёлын амьдралд чөлөөтэй оролцох, урлагийн цэнгэлийг эдлэх, шинжлэх ухааны дэвшилд оролцож үр шимийг нь хүртэх эрхтэй.

2. Хүн бүр өөрийн туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны бүтээлийн материаллаг болон ёс суртахууны эрх ашгаа хамгаалуулах эрхтэй.

28 дугаар зүйл

Хүн бүр энэхүү Тунхаглалд заасан эрх, эрх чөлөөг бүрэн эдлэж болохуйц нийгмийн болон олон улсын дэг журамд аж төрөх эрхтэй.

29 дүгээр зүйл

1. Хүн бүр нийгмийнхээ өмнө тодорхой үүрэг хүлээх бөгөөд гагцхүү нийгэм л бие хүний чөлөөтэй, өв тэгш хөгжлийг хангана.

2. Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ гагцхүү бусдын эрх, эрх чөлөөг зохих ёсоор хүлээн зөвшөөрч хүндлэх, мөн ардчилсан нийгмийн ёс суртахууны шударга шаардлага, нийгмийн хэв журам, ерөнхий сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосноос өөр хязгаарлалтад өртөгдөх ёсгүй.

3. Эдгээр эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхдээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын зорилго, зарчимтай хэрхэвч зөрчилдүүлж болохгүй.

30 дугаар зүйл

Энэхүү Тунхаглалын ямар ч зүйлийг аль нэг улс, бүлэг буюу бие хүний зүгээс энд тунхагласан эрх, эрх чөлөөг устгахад чиглэсэн аливаа үйл ажиллагаа явуулах буюу тийм үйлдэл хийх эрх олгож байгаа мэтээр мушгин тайлбарлаж болохгүй.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт

Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200А(XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон.*

УДИРТГАЛ

Энэхүү Пактад оролцогч улс,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрэмд тунхагласан зарчмын дагуу хүн төрөлхтөний ам бүлийн гишүүн бүхэнд угаас заяасан нэр төр болон тэдний адил тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шудрага ёс, бүх нийтийн энх тайвны үндэс мөн болохыг анхааралдаа авч,

эдгээр эрх нь хүнд угаас заяасан нэр төрөөс үүдэн гарч байгааг хүлээн зөвшөөрч,

Хүний эрхийн түгээмэл Тунхаглалд зааснаар хүн бүр эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ улс төр, иргэнийхээ эрхийн адил эдлэх нөхцлөөр гагцхүү хангагдаж байж л улс төр, иргэний эрх чөлөөгөө эдэлж, айх аюулгүй, гачигдах зовлонгүй байх чөлөөт бие хүний эрхэм зорилго биелэгдэхийг хүлээн зөвшөөрч,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрэм ёсоор улс гүрэн хүний эрх, эрх чөлөөг бүх нийтээр хүндэтгэн сахих явдлыг хөхиүлэн дэмжих үүрэгтэйг анхааралдаа авч,

хувь хүн бүр бусад хүн болон хамт олныхоо өмнө үүрэг хүлээхийн сацуу энэхүү Пактад хүлээн зөвшөөрсөн эрхийг хөхиүлэн дэмжих, сахиулах талаар чармайх ёстойг анхааралдаа авч, дор дурдсан зүйлийг тохиролцов:

* Монгол Улс 1968.01.05-нд гарын үсэг зурж, 1974.11.18-нд соёрхон баталсан

I ХЭСЭГ

1 дүгээр зүйл

1. Бүх ард түмэн өөрөө засан тохинох эрхтэй. Энэхүү эрхийнхээ дагуу тэд улс төрийн статусаа чөлөөтэй тогтоож, эдийн засаг, нийгэм, соёлоо чөлөөтэй хөгжүүлнэ.

2. Бүх ард түмэн харилцан ашигтай байх зарчим дээр тулгуурласан олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаагаар болон олон улсын эрх зүйгээр хүлээсэн аливаа үүргээ хохироохгүйгээр байгалийн баялаг, нөөцөө өөрийн зорилгод чөлөөтэй захиран зарцуулна. Аль ч ард түмнийг ямар ч тохиолдолд оршин тогтнох хэрэглүүрээс нь хагацааж үл болно.

3. Энэхүү Пактад оролцогч бүх улс, түүний дотор, өөрөө эс удирдах болон асрамжийн нутаг дэвсгэрийг захирах хариуцлага бүхий улс, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрмийн заалтын дагуу өөрөө засан тохинох эрхийг хэрэгжүүлэх явдлыг хөхиүлэн дэмжиж, энэ эрхийг хүндэтгэх ёстой.

II ХЭСЭГ

2 дугаар зүйл

1. Энэхүү Пактад оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ болон харьяалалдаа байгаа бүх хүний энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй.

2. Хууль тогтоомжийн буюу бусад арга хэмжээ аваагүй байгаа бол энэхүү Пактад оролцогч улс бүр үндсэн хуулийнхаа журам болон энэ Пактын заалтад нийцүүлэн түүнд хүлээн зөвшөөрсөн эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай байж болох хууль тогтоомжийн буюу бусад арга хэмжээг авах үүрэгтэй.

3. Энэхүү Пактад оролцогч улс бүр дараахь үүрэг хүлээнэ:

(a) энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн аливаа хүнийг, ийм зөрчлийг албаны үүргээ гүйцэтгэж байсан этгээд үйлдсэн байсан ч үр нөлөөтэй эрх зүйн хамгаалалтаар хангах;

(b) эрх зүйн хамгаалалт хүссэн аливаа этгээдийн тийм эрхийг эрх бүхий шүүх, захиргаа, хууль тогтоох байгууллага, эсхүл тухайн улсын эрх зүйн тогтолцоонд заасан эрх бүхий бусад байгууллагаас тогтоож байх явдлыг хангах, түүнчлэн шүүхээр хамгаалуулах боломжийг нь хөгжүүлэх;

(c) эрх зүйн хамгаалалт олгож байгаа бол түүнийг эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлэх явдлыг хангах.

3 дугаар зүйл

Энэхүү Пактад оролцогч улс түүнд заасан иргэний болон улс төрийн бүх эрхийг эрэгтэй, эмэгтэйчүүдэд тэгш эдлүүлэх үүрэгтэй.

4 дүгээр зүйл

1. Улс үндэстний амьдралд аюул занал тулгарч, энэ тухай албан ёсоор зарлаж нийтийг хамарсан онц байдал тогтоосон үед энэхүү Пактад оролцогч улс уг Пактаар хүлээсэн үүргээсээ тухайн нөхцөл байдлын хурцадмал шинжид дүйх хэмжээгээр ухарсан арга хэмжээ авч болох бөгөөд тэр нь олон улсын эрх зүйгээр хүлээсэн бусад үүрэгт нь харшлах ёсгүйгээс гадна зөвхөн арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг буюу нийгмийн гарлаар алагчилах явдалд хүргэхгүй байх ёстой.

2. Энэ заалт нь 6, 7, 8, /1, 2 дахь хэсэг/, 11, 15, 16, 18 дугаар зүйлээс ямар нэгэн байдлаар ухрах үндэслэл болохгүй.

3. Ухрах эрхээ хэрэгжүүлж буй, энэхүү Пактад оролцогч аливаа улс ухарч байгаа заалт болон ухрах болсон шалтгааны талаар уг

Пактад оролцогч бусад улсад Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргаар уламжлан даруй мэдэгдэх ёстой. Түүнчлэн ухарсан үүргээ сэргээсэн хугацааг мөнхүү зуучлагчаар уламжлан мэдэгдсэн байх ёстой.

5 дугаар зүйл

1. Аливаа улс, бүлэг буюу хувь этгээд энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн аливаа эрх, эрх чөлөөг үгүй хийх буюу тэдгээрийг түүнд зааснаас илүү хэмжээгээр хязгаарлахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах буюу үйлдэл хийх эрхтэй мэтээр энэхүү Пактын заалтуудыг мушгин тайлбарлаж болохгүй.

2. Энэхүү Пактад оролцогч аливаа улсад хууль, конвенц, журам, заншлаар хүлээн зөвшөөрсөн буюу хэрэгжүүлж байгаа хүний аливаа үндсэн эрхийг тус Пактад хүлээн зөвшөөрөөгүй буюу доогуур хэмжээгээр хүлээн зөвшөөрсөн гэх шалтгаар хязгаарлах буюу бууруулж болохгүй.

III ХЭСЭГ

6 дугаар зүйл

1. Хүн бүр амьд явах салшгүй эрхтэй. Энэ эрхийг хуулиар хамгаална. Хэний ч амь насыг дур мэдэн бусниулж болохгүй.

2. Цаазаар авах ялыг цуцлаагүй улсад уг ялыг зөвхөн онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир энэхүү Пакт болон Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенцийн заалтад нийцсэн бөгөөд тухайн гэмт хэрэг үйлдэх үед хүчинтэй байсан хуулийн дагуу этгээдэд оногдуулж болно. Энэхүү ялыг гагцхүү эрх бүхий шүүхийн эцсийн шийдвэрийн дагуу гүйцэтгэж болно.

3. Амь нас бусниулсан үйлдэл нь төрлөөр устгах гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй байвал энэ заалт нь энэхүү Пактад оролцогч аль ч улсад Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенцийн заалтаар

хүлээсэн аливаа үүргээсээ ямар ч байдлаар ухрах эрх олгохгүй гэж ойлгоно.

4. Цаазаар авах ял шийтгүүлсэн хүн бүр уучлал эрэх буюу ял хөнгөрүүлэх хүсэлт гаргах эрхтэй. Бүх тохиолдолд өршөөл, уучлал үзүүлэх буюу цаазаар авах ялыг хөнгөрүүлж болно.

5. Арван найман нас хүрээгүй хүний үйлдсэн гэмт хэрэгт цаазаар авах ял оногдуулахгүй бөгөөд жирэмсэн эмэгтэйчүүдэд оногдуулсан уг ялыг гүйцэтгэж болохгүй.

6. Энэ зүйлийн аль ч заалт нь энэхүү Пактад оролцогч аль нэгэн улс цаазаар авах ялаа цуцлахыг хойшлуулах буюу ерөөсөө цуцлах үндэслэл болохгүй.

7 дугаар зүйл

Хэнд ч эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхийг хориглоно. Тухайлбал, өөрийнх нь чөлөөтэй өгсөн зөвшөөрөлгүйгээр хэнийг ч эмнэлгийн буюу шинжлэх ухааны туршилтад оруулж болохгүй.

8 дугаар зүйл

1. Хэнийг ч боол болгож болохгүй; аливаа төрийн боолчлол болон боолын худалдааг хориглоно.

2. Хэнийг ч бусдын эрхшээлд байлгаж болохгүй.

а) хэнийг ч албадан хөдөлмөрлүүлэх буюу заавал ажилд тулгаж болохгүй.

б) гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүнд хүчир хөдөлмөр хийлгэж хорих ял оногдуулж болдог улсын хувьд эрх бүхий шүүхээс оногдуулсан ялын дагуу хүнд хүчир хөдөлмөр хийлгэхэд 3 дахь хэсгийн (а) дэд хэсгийн заалт саад болохгүй.

с) энэ хэсгийн зорилгын үүднээс “албадан хөдөлмөрлүүлэх буюу заавал ажилд тулгах “ гэсэн нэр томъёонд дор дурдсан зүйлүүд хамаарахгүй:

I/ шүүхийн хууль ёсны шийдвэрээр хоригдож байгаа буюу тийм хорионоос тэнсэнгээр суллагдсан этгээдээс хийхийг шаарддаг, (b) дэд хэсэгт дурдаагүй аливаа ажил буюу алба,

II/ цэргийн шинжтэй аливаа алба, түүнчлэн итгэл үнэмшлийн сэдлээр цэргийн албанаас татгалзахыг зөвшөөрсөн улсад тийм хүмүүсээс хуульд заасны дагуу гүйцэтгэх ёстой аливаа үндэсний алба,

III/ онц байдлын үед буюу хүн амын амьдрал, аж байдалд заналхийлсэн гай гамшиг тохиолдсон үед заавал гүйцэтгэх аливаа алба,

IV/ иргэний ердийн үүрэгт хамаарах аливаа ажил буюу алба.

9 дүгээр зүйл

1. Хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй. Хэнийг ч дур мэдэн баривчлах буюу цагдан хорьж болохгүй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасч болохгүй.

2. Баривчлагдсан шалтгааныг хүн бүрт баривчлах үед нь мэдэгдэхийн зэрэгцээ буруутгаж байгаа аливаа үндэслэлийг даруй мэдэгдэнэ.

3. Баривчлагдсан буюу эрүүгийн хэрэгт буруутгагдсан аль ч хүнийг шүүгч буюу хуулийн дагуу шүүн таслах эрх хэмжээ олгогдсон бусад албан тушаалтанд даруй шилжүүлэх бөгөөд хүн хэргээ боломжийн богино хугацаанд шүүхээр шийдвэрлүүлэх буюу суллагдах эрхтэй. Шүүхийн өмнөх шатанд байгаа хүнийг заавал цагдан хорьж байх нийтлэг журам байх албагүй бөгөөд шүүх хуралд оролцох, шүүн таслах ажиллагааны аль ч шатанд байлцах, шаардлагатай тохиолдолд, шүүхийн шийдвэр гүйцэтгэхэд байх баталгаа гаргаж өгсөн бол этгээдийг суллаж болно.

4. Баривчлагдаж эсхүл цагдан хоригдож эрх чөлөөгөө хасуулсан хүн бүр ийнхүү хорьж саатуулсан нь хууль ёсны эсэхийг шүүхээр даруй тогтоолгох, хууль бусаар хорьсон бол суллуулах шийдвэр гаргуулах эрхтэй.

5. Хууль бусаар баривчлагдаж эсхүл цагдан хоригдож хохирсон этгээд хохирлоо албадан нөхөн төлүүлэх эрхтэй.

10 дугаар зүйл

1. Эрх чөлөөгөө хасуулсан бүх хүнтэй хүнлэг харьцаж, угаас заяасан нэр йтөрийг нь хүндэтгэнэ.

2. (а) онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд буруутнаар татагдсан этгээдийг ял шийтгүүлсэн этгээдээс тусгаарлаж, шийтгэгдээгүй этгээдийн эрх зүйн байдалд тохирсон жич дэглэмд байлгана.

(b) буруутнаар татагдсан насанд хүрээгүй этгээдийг насанд хүрсэн этгээдээс тусгаарлаж хэргийг нь аль болох богино хугацаанд шүүхэд шилжүүлэн шийдвэрлүүлнэ .

3. Хорих байгууллагын дэглэмийн нэн чухал зорилго нь хоригдлыг засан хүмүүжүүлж, нийгмийн хэвийн гишүүн болгох явдал байна. Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүйчүүдийг насанд хүрэгсдээс тусгаарлаж, тэдний нас, эрх зүйн байдалд нийцсэн дэглэмд байлгана.

11 дүгээр зүйл

Гэрээгээр хүлээсэн аль нэг үүргээ биелүүлж чадаагүй ч гагцхүү үндэслэл болгон хэний ч эрх чөлөөг хасч болохгүй.

12 дугаар зүйл

1. Аль нэг улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор байгаа аливаа хүн тухайн нутаг дэвсгэрийн дотор чөлөөтэй шилжин явах, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй.

2. Хүн бүр аливаа улсыг, түүний дотор эх орноо орхин явах эрхтэй.

3. Хуульд заасан бөгөөд үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун буюу бусдын эрх, эрх чөлөө болон энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн бусад эрхийг хамгаалахад шаардлагатай хязгаарлалтаас бусдаар дээр дурдсан эрхийг хязгаарлаж болохгүй.

4. Хэний ч эх орондоо ирэх эрхийг дур мэдэн хасч болохгүй.

13 дугаар зүйл

Энэхүү Пактад оролцогч аль нэг улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин суугаа гадаадын иргэнийг гагцхүү хуулийн дагуу гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үүднээс албадан гаргаж болох бөгөөд үндэсний аюулгүй байдлыг хамгаалах зайлшгүй шалтгаанаас бусад тохиолдолд албадан гаргахыг эсэргүүцсэн үндэслэл шалтгаанаа танилцуулах, эрх бүхий байгууллага буюу түүнээс тусгайлан томилсон этгээд буюу этгээдүүдээр хэргээ дахин хянуулах түүнчлэн энэ зорилгоор ийнхүү эрх бүхий байгууллага, этгээд буюу этгээдүүдэд өөрийгөө төлөөлүүлж хандах эрхтэй.

14 дүгээр зүйл

1. Шүүх ба тусгай шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй. Хүн бүр өөрт тулгасан эрүүгийн хэргийг хянан хэлэлцүүлэх буюу иргэний нэхэмжлэлийн хүрээнд эрх, үүргээ тодорхойлуулахдаа хуулийн дагуу байгуулагдсан эрх бүхий, хараат бус, тал үл харах шүүхээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй.

Ардчилсан нийгэм дэх ёс суртахуун, нийгмийн хэв журам буюу үндэсний аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс эсхүл талуудын хувийн амьдралын эрх ашгийн үүднээс, эсхүл нээлтэй явуулах нь шүүн таслах ажлын эрх ашгийг зөрчинө гэж шүүхээс үзсэн онцгой нөхцөл байдалд, тэрхүү шүүхийн өөрийн саналаар зайлшгүй гэж тогтоосон хэмжээгээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийг шүүх ажиллагаанд бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт

оролцуулахгүй байж болно; гэхдээ насанд хүрээгүй хүүхдийн эрх ашгийг хамгаалах, гэр бүлийн (matrimonial) эхнэр нөхрийн маргаан буюу хүүхдэд асран хамгаалагч тогтоохтой холбоотойгоос бусад эрүүгийн болон иргэний хэргийн талаархи шүүхийн шийдвэр олон нийтэд нээлттэй байна.

2. Эрүүгийн хэрэгт буруутгуулж буй хэн боловч гэм буруу нь хуулийн дагуу нотлогдох хүртэл гэм буруугүйд тооцогдох эрхтэй.

3. Хүн бүр өөрийг нь яллагдагчаар татсан аливаа эрүүгийн хэргийг хянан хэлэлцэхэд бүрэн тэгш эрхийн үндсэн дээр дараахь наад захын баталгаагаар хангагдах эрхтэй:

(a) оногдуулж байгаа ялын шинж чанар, үндэслэлийг ойлгох хэлээр нь даруй, нарийвчлан мэдэгдэх;

(b) өмгөөлүүлэх ажлаа бэлтгэх хүрэлцээтэй хугацаа, бололцоотой байх, сонгож авсан өмгөөлөгчтэйгээ харилцах;

(c) зүй бусын хойшлуулалтгүйгээр шүүгдсэн байх;

(d) хэргийг нь шүүхээр хянан хэлэлцэхэд байлцах, өөрийгөө биечлэн өмгөөлөх буюу өөрийн сонгон авсан өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх; өмгөөлөгчгүй байгаа бол өмгөөлүүлэх эрхийнх нь тухай өөрт нь мэдэгдсэн байх; шүүн таслах ажлын эрх ашиг шаардаж байвал ямар ч тохиолдолд, өөрт нь томилсон өмгөөлөгчтэй байх, ийм аливаа тохиолдолд өмгөөлөгчийн хөлсийг төлөх хүрэлцээтэй мөнгө хөрөнгө байхгүй бол үнэ төлбөргүй үйлчлүүлэх;

(e) өөрийнх нь эсрэг мэдүүлэг өгч байгаа гэрчийг байцаалгах буюу байцаалгуулах, эсрэг гэрчтэй адил нөхцлөөр өөрийн өмнөөс гэрч оролцуулах болон шалгуулах;

(f) шүүн таслах ажиллагаа явуулж байгаа хэлийг ойлгохгүй буюу үг хэлээр ярьдаггүй тохиолдолд орчуулагчийн тусалцааг үнэ төлбөргүй авах;

(г) өөрийн эсрэг мэдүүлэг өгөх, бурууг хүлээх тулган шаардалтад ертөхгүй;

4. Насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тэдний насыг болон засч хүмүүжихэд нь дэмжлэг үзүүлүүштэйг харгалзсан байх ёстой.

5. Ямар нэг гэмт хэрэгт шийтгүүлж ял заагдсан хүн бүр шийтгэгдсэнээ болон оноосон ялыг эргэж хянуулахаар хуулийн дагуу дээд шатны шүүхэд давж заалдах эрхтэй.

6. Эрүүгийн хэрэг үйлдэж, шүүхийн эцсийн шийдвэрээр ял заагдсан бөгөөд шинэ буюу шинээр илэрсэн үйл баримт шүүн таслах ажиллагааны алдааг хөдөлбөргүй нотолсны учир оногдуулсан ялыг хожим хүчингүй болгосон буюу хэргийг цагаатгасан бол тэрхүү мэдэгдээгүй байсан үйл баримт тухайн үедээ илрээгүй нь бүхэлдээ буюу зарим талаар уг хүний буруугаас болсон гэдэг нь батлагдаагүй бол тийнхүү шийтгүүлсэн этгээд хуулийн дагуу хохирлоо нөхөн төлүүлнэ.

7. Үйлдсэн гэмт хэрэгтээ тухайн улсын хууль болон эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу эцэслэн шийтгүүлсэн буюу цагаатгагдсан хэнийг ч тэрхүү гэмт хэргээр нь дахин шүүх буюу шийтгэх ёсгүй.

15 дугаар зүйл

1. Хэрэг үйлдэх үед нь дотоодын хууль буюу олон улсын эрх зүйгээр эрүүгийн гэмт хэрэгт эс тооцож байсан ямар нэг үйлдэл буюу эс үйлдлээр хэнийг ч гэмт хэрэгтэн гэж буруутгаж болохгүй түүнчлэн эрүүгийн гэмт хэрэг үйлдэх үед хэрэглэж байснаас илүү хүнд ял шийтгэл оногдуулж болохгүй. Гэмт хэрэг үйлдэгдсэнээс хойш тийм хэргийн ялыг хуулиар хөнгөлсөн бол уг хэрэгтэнд тэрхүү хөнгөлсөн ялыг хэрэглэнэ.

2. Хэрэг үйлдэх үед олон улсын хамтын нийгэмлэгийн хүлээн зөвшөөрсөн эрх зүйн ерөнхий зарчмын дагуу эрүүгийн гэмт хэрэгт

тооцож байсан үйлдэл буюу эс үйлдэл хийсэн этгээдийг шүүхэд шилжүүлэх болон шийтгэхэд энэ зүйлийн заалт саад болохгүй.

16 дугаар зүйл

Хүн бүр хаана ч эрх зүйн чадвартай байх эрхээ хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй.

17 дугаар зүйл

1. Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байранд нь буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно.

2. Хүн бүр тийм оролцоо, халдлагаас хуулиар хамгаалуулах эрхтэй.

18 дугаар зүйл

1. Хүн бүр чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, эс шүтэх эрхтэй. Энэхүү эрхэнд өөрийн сонгосон шашин буюу шүтлэгтэй байх эсхүл тийм шашин буюу шүтлэгтэй болох эрх чөлөөний зэрэгцээ ганцаар буюу бусадтай хамтран олон нийтэд буюу хувийн журмаар хичээл заах, хурал мөргөл хийх, шашны болон зан үйлийн ёслол үйлдэх зэргээр шашин буюу шүтлэг номлох эрх чөлөө багтана.

2. Хэний ч өөрийн сонгосон шашин буюу шүтлэгтэй байх эсхүл тийм шашин буюу шүтлэгтэй болох эрх чөлөөг хязгаарлахаар албадан шахах ёсгүй.

3. Шашин буюу шүтлэгээ номлох эрх чөлөөг зөвхөн хуулиар тогтоосон болон нийгмийн аюулгүй байдал, хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун, бусдын үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах шаардлагын үүднээс хязгаарлаж болно.

4. Энэхүү Пактад оролцогч улс эцэг эхийн болон зохих тохиолдолд хууль ёсны асран хамгаалагчдын үр хүүхэддээ хувийн үзэл

итгэлийнхээ дагуу шашны болон ёс суртахууны хүмүүжил олгох эрх чөлөөг хүндэтгэх үүрэг хүлээнэ.

19 дүгээр зүйл

1. Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй.
2. Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.
3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлага оногдуулна. Тийм учраас түүнийг зарим талаар хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараахь шаардлагаас үүдэн гарсан байх ёстой :
а/ бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх;
б/ үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах.

20 дугаар зүйл

1. Дайныг аливаа хэлбэрээр сурталчлахыг хуулиар хориглоно.
2. Алагчилан дайсагналцах болон хүчирхийллийг өдөөн турхирдаг үндсэрхэх үзлээр, арьс үндсээр болон шашин шүтлэгээр үзэн ядах байдлыг дэмжсэн аливаа ухуулга сурталчилгааг хуулиар хориглоно.

21 дүгээр зүйл

Тайван хуран цуглах эрхийг хүлээн зөвшөөрнө. Энэхүү эрхийг эдлэхэд ардчилсан нийгэмд үндэсний буюу нийгмийн аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах, эсхүл бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах эрх ашгийн үүднээс хуулийн дагуу тогтоосноос өөр хязгаарлалт хийж болохгүй.

22 дугаар зүйл

1. Хүн бүр бусадтай эвлэлдэн нэгдэх, түүний дотор өөрийн эрх ашгийг хамгаалах үүднээс үйлдвэрчний эвлэл байгуулах буюу түүнд элсэх эрхтэй.
2. Энэ эрхийг эдлэхэд ардчилсан нийгэмд үндэсний буюу нийгмийн аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахуун, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах эрх ашгийн үүднээс хуульд зааснаас өөр хязгаарлалт хийж болохгүй. Зэвсэгт хүчний болон цагдаагийн бүрэлдэхүүнд багтах этгээдэд энэхүү эрхийг хэрэгжүүлэхэд хууль ёсны хязгаарлалт тогтооход энэ зүйл саад болохгүй.
3. Энэ зүйлийн аль ч заалт Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрх чөлөөний тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 1948 оны конвенцид нэгдэн орсон улсын хувьд түүнд заасан баталгаанд харшлах хууль тогтоомж гаргах буюу хуулийг эдгээр баталгаанд хохирол учруулахаар хэрэглэх эрх үл олгоно.

23 дугаар зүйл

1. Гэр бүл бол нийгмийн жам ёсны үндсэн нэгж бөгөөд нийгэм, төрөөр хамгаалуулах эрхтэй.
2. Гэрлэх насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэйчүүд гэрлэх, өрх тусгаарлах эрхтэй.
3. Гэрлэгчид өөрсдөө чөлөөтэй бөгөөд харилцан бүрэн зөвшөөрөлцөөгүй аливаа гэрлэлт байж үл болно.
4. Энэхүү Пактад оролцогч улс нь гэрлэх үед, гэрлэсэн хугацааны туршид болон гэрлэлтийг цуцлах үед гэрлэгчдийн эдлэх эрх, хүлээх хариуцлагыг тэгш хангах зохистой арга хэмжээ авна. Гэрлэлтийг цуцлах тохиолдолд аливаа хүүхдийг хамгаалах талаар шаардлагатай заалт гаргана.

24 дүгээр зүйл

1. Аливаа хүүхэд арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ болон төрсөн байдлаар алагчлагдахгүйгээр өөрийн гэр бүл, нийгэм, төрийн зүгээс насанд хүрээгүйнхээ хувьд шаардлага бүхий хамгаалалт эдлэх эрхтэй.

2. Хүүхэд төрсөн даруй бүртгэгдэж, нэртэй болох ёстой.

3. Хүүхэд бүр иргэний харьяалалтай болох эрхтэй.

25 дугаар зүйл

Иргэн бүр 2 дугаар зүйлд дурдсан аливаа алагчилалгүйгээр болон үндэслэлгүй хязгаарлалтгүйгээр дараахь эрх, боломжийг эдэлнэ:

(a) төрийн хэргийг явуулахад шууд болон чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох;

(b) сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хурааж, сонгогчид жинхэнэ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг баталгаажуулсан, жинхэнэ ёсоор тогтмол явагддаг сонгуульд сонгох буюу сонгогдох;

(c) тэгш эрхийн ерөнхий нөхцөлтэйгээр улсдаа төрийн алба хаших.

26 дугаар зүйл

Бүх хүн хуулийн өмнө тэгш байх бөгөөд аливаа алагчлалгүйгээр хуулиар тэгш хамгаалуулах эрхтэй. Энэ үүднээс аливаа байдлаар алагчилах явдлыг хуулиар хориглох бөгөөд хууль нь арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн байдал буюу бусад байдлаар алагчилахаас бүх хүнийг адил тэгш үр нөлөөтэй хамгаалах баталгааг бүрдүүлэх ёстой.

27 дугаар зүйл

Угсаатан, шашны болон хэлний цөөнх оршин суудаг улсад эдгээр цөөнхөд багтдаг хүмүүст тийм бүлгийн бусад гишүүнийхээ хамтаар соёлоо баримтлах, шашнаа шүтэх, шашныхаа зан үйлийг үйлдэх, түүнчлэн эх хэлээрээ ярих эрхийг хорьж болохгүй.

IV ХЭСЭГ

28 дугаар зүйл

1. Хүний эрхийн хороог (энэхүү Пактад цаашид “Хороо” гэж нэрлэнэ) байгуулна. Хороо арван найман гишүүнээс бүрдэх бөгөөд хойно заасан чиг үүргийг гүйцэтгэнэ.
2. Хорооны бүрэлдэхүүнд энэхүү Пактад оролцогч улсын иргэн бөгөөд ёс суртахууны эрхэм дээд чанарыг эзэмшсэн, хүний эрхийн салбарт хүлээн зөвшөөрөгдсөн мэдлэг чадвар бүхий этгээд орох бөгөөд хууль эрхийн туршлагатай хэд хэдэн хүнийг оролцуулах нь ашигтай болохыг анхаарвал зохино.
3. Хорооны гишүүд өөрийн нэрээр сонгогдож, өөрийн нэрийн өмнөөс ажиллана.

29 дүгээр зүйл

1. Хорооны гишүүдийг 28 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан бөгөөд энэхүү Пактад оролцогч улсаас нэрийг нь дэвшүүлсэн хүмүүсийн жагсаалтаас нууцаар санал хурааж сонгоно.
2. Энэхүү Пактад оролцогч улс бүр хоёроос дээшгүй хүний нэрийг дэвшүүлж болох бөгөөд тэд нь тухайн улсын иргэн байх ёстой.
3. Хэн ч улиран нэр дэвших эрхтэй.

30 дугаар зүйл

1. Анхны сонгуулийг энэхүү Пакт хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш зургаан сарын дотор явуулна.

2. 34 дүгээр зүйлийн дагуу суларсан орон тоог нөхөх сонгуулиас бусад сонгууль бүрийг явуулахаас наад зах нь дөрвөн сарын өмнө Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү Пактад оролцогч улсад бичгээр хандаж гурван сарын дотор Хорооны гишүүнд нэр дэвшүүлэхийг санал болгоно.

3. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга ийнхүү нэр дэвшигчдийн нэрсийг цагаан толгойн дэс дараагаар тэдний нэрийг дэвшүүлсэн улсыг заан жагсааж, тухайн сонгууль бүрийг явуулахаас нэг сарын өмнө энэхүү Пактад оролцогч улсад толилуулахаар илгээнэ.

4. Хорооны гишүүдийн сонгуулийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын төв байранд зарлан хуралдуулсан энэхүү Пактад оролцогч улсын хуралдаан дээр явуулна. Энэхүү Пактад оролцогч улсын гуравны хоёр нь оролцсоноор уг хуралдааныг хүчин төгөлдөр гэж үзэх бөгөөд Пактад нэгдэн орсон улсын санал хураахад байлцаж, оролцсон төлөөлөгчдийн хамгийн олонх бөгөөд дийлэнх олонхийн санал авсан хүнийг Хорооны гишүүнээр сонгогдсонд тооцно.

31 дүгээр зүйл

1. Хороонд нэг улсаас нэгээс илүү иргэн орж болохгүй.

2. Хорооны сонгуулийг явуулахдаа гишүүдийн хувьд газар зүйн шударга хуваарилалт болон соёл иргэншлийн янз бүрийн хэлбэр, эрх зүйн үндсэн тогтолцоог төлөөлүүлэхийг бодолцоно.

32 дугаар зүйл

1. Хорооны гишүүдийг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно. Тэдгээрийн нэрийг дахин дэвшүүлбэл улиран сонгогдох эрхтэй.

Харин анхны сонгуулиар сонгогдсон гишүүдээс есийнх нь бүрэн эрхийн хугацаа хоёр жилийн дараа дуусах бөгөөд анхны сонгуулийг явуулж дуусмагц 30 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт дурдсан хуралдааны дарга тэдгээр есөн гишүүний нэрсийг шодож тогтооно.

2. Бүрэн эрхийн хугацаа дуусмагц сонгуулийг энэхүү Пактын тус хэсгийн дээр дурдсан заалтуудын дагуу явуулна.

33 дугаар зүйл

1. Түр зуур эзгүй байхаас бусад шалтгаанаар Хорооны аль нэг гишүүн чиг үүргээ биелүүлэхээ больсон гэж Хорооны бусад гишүүн санал нэгтэй үзсэн бол Хорооны дарга энэ тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэх бөгөөд тэрбээр уг гишүүний орон тоог сул гэж зарлана.

2. Хорооны аль нэг гишүүн нас барах буюу огцроход Хорооны дарга энэ тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад нэн даруй мэдэгдэх бөгөөд тэрбээр нас барсан буюу огцорсон өдрөөс эхлэн тэр гишүүний орон тоог сул гэж зарлана.

34 дүгээр зүйл

1. 33 дугаар зүйлийн дагуу орон тоо суларсан тухай зарласан бол түүнчлэн солигдох ёстой гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусч орон тоо суларсан тухай зарласнаас хойш зургаан сарын дотор дуусахгүй бол Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү Пактад оролцогч улс бүрт мэдэгдэх бөгөөд тэдгээр улс уг орон тоонд нөхөж дэвшүүлэх хүний нэрийг хоёр сарын дотор 29 дүгээр зүйлийн дагуу дэвшүүлж болно.

2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга ийнхүү нэр дэвшүүлсэн хүмүүсийн нэрсийн жагсаалтыг цагаан толгойн дэс дараагаар гаргаж түүнийг энэхүү Пактад оролцогч улс бүрт толилуулна. Улмаар орон тоог нөхөх сонгуулийг энэхүү Пактын энэ хэсгийн холбогдох заалтын дагуу явуулна.

3. 33 дугаар зүйлийн дагуу суларсан орон тоонд нөхөн сонгогдсон Хорооны гишүүн нь Хорооноос гарсан тэрхүү гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаанд энэхүү зүйлийн заалтын дагуу уг албан тушаалд ажиллана.

35 дугаар зүйл

Хорооны гишүүн нь Хорооны үүрэг, хариуцлагын ач холбогдлыг харгалзан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн тогтоосон журам, нөхцлийн дагуу Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөрөнгөөс Ерөнхий Ассамблейн батласан шан хөлс авна.

36 дугаар зүйл

Хороогоор энэхүү Пактын дагуу оногдсон чиг үүргийг нь үр нөлөөтэй биелүүлэх явдлыг хангахын тулд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга шаардлагатай боловсон хүчин, материаллаг хэрэгсэл олгоно.

37 дугаар зүйл

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Хорооны анхдугаар хуралдааныг Нэгдсэн Үндэстний Байгууллагын төв байранд зарлан хуралдуулна.

2. Анхдугаар хуралдаанаас хойш Хороо ажлын дэгэндээ заасан хугацаанд хуралдана.

3. Хороо ер нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын төв байр буюу Нэгдсэн Үндэстний Байгууллагын Женев дэх салбарын байранд хуралдана.

38 дугаар зүйл

Хорооны гишүүн бүр үүрэгт ажилдаа орохын өмнө Хорооны нээлттэй хуралдаан дээр үүргээ тал харахгүй, ухамсартай биелүүлэх тухай ёс төртэй мэдэгдэл хийнэ.

39 дүгээр зүйл

1. Хороо албан тушаалтнаа хоёр жилийн хугацаагаар сонгоно. Тэднийг улируулан сонгож болно.
2. Хороо дэгийнхээ журмыг өөрөө тогтоох боловч түүнд, тухайлбал, дор дурдсаныг заасан байвал зохино:
 - (а) Хорооны арван хоёр гишүүн оролцсоноор хуралдаан хүчинтэй болно.
 - (б) Хорооны шийдвэрийг хуралдаанд оролцогч гишүүдийн олонхийн саналаар батлана.

40 дүгээр зүйл

1. Энэхүү Пактад оролцогч улс түүгээр хүлээн зөвшөөрсөн эрхийг хэрэгжүүлэх үүднээс арга хэмжээ, энэ талаар гарсан ахиц дэвшлийн тухай тайлан ирүүлж байх үүрэгтэй:
 - (а) холбогдох оролцогч улсын хувьд энэхүү Пакт хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилийн дотор;
 - (б) үүнээс хойш Хорооноос шаардсан тухай бүрт.
2. Бүх тайланг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад явуулах бөгөөд тэрбээр тайланг хэлэлцүүлэхээр Хороонд илгээнэ. Энэхүү Пактыг хэрэгжүүлэхэд нөлөөлж байгаа хүчин зүйл, бэрхшээл байвал тэр тухай тайланд заана.
3. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Хороотой зөвлөлдсөний дараа холбогдох төрөлжсөн байгууллагад тэдгээрийн эрх мэдлийн хүрээнд хамаарах тайлангийн холбогдох хэсгийн хувийг илгээж болно.
4. Хороо энэхүү Пактад оролцогч улсаас гаргасан тайланг судлана. Хороо нь өөрийн тайлан болон зохистой гэж үзсэн ерөнхий шинж чанартай анхааруулгыг оролцогч улсуудад илгээнэ. Түүнчлэн Хороо энэхүү Пактад оролцогч улсаас ирүүлсэн тайлангийн хувийг дурдсан анхааруулгын хамт Эдийн засаг, нийгмийн зөвлөлд явуулж болно.

5. Энэхүү Пактад оролцогч улс энэ зүйлийн 4 дүгээр заалтын дагуу хийсэн аливаа анхааруулгын талаар санал бодлоо Хороонд оруулж болно.

41 дүгээр зүйл

1. Энэхүү Пактаар хүлээсэн үүргээ түүнд оролцогч аль нэг улс биелүүлэхгүй байгаа тухай Пактад оролцогч өөр улсын мэдээллийг хүлээн авч хэлэлцэх Хорооны эрх мэдлийг хүлээн зөвшөөрч байгаагаа энэхүү Пактад оролцогч аль ч улс энэ зүйлийн заалтын дагуу хэдийд ч мэдэгдэж болно. Хорооны энэ эрх мэдлийг өөрийнхөө хувьд хүлээн зөвшөөрч мэдэгдэл хийсэн оролцогч улсаас л энэ зүйлд заасан мэдээлэл ирсэн бол түүнийг хүлээн авч хэлэлцэж болно. Ийм мэдэгдэл хийгээгүй оролцогч улстай холбогдолтой ямар ч мэдээллийг Хороо хүлээн авахгүй. Энэ зүйлийн заалтын дагуу хүлээн авсан мэдээллийг дор дурдсан дэгээр авч хэлэлцэнэ:

(a) энэхүү Пактад оролцогч аль нэг улс Пактын заалтыг түүнд оролцогч өөр нэг улс хэрэгжүүлэхгүй байна гэж үзвэл, энэ тухайгаа тэр улсад бичгээр мэдэгдэж болно. Ийм мэдээлэл хүлээж авсан улс тайлбар буюу энэ асуудлыг тайлбарласан өөр аливаа мэдэгдлийг мэдээлэл ирүүлсэн улсад гурван сарын дотор бичгээр өгөх бөгөөд түүндээ уг асуудлаар авсан, авах гэж байгаа буюу авч болох арга хэмжээний тухай болон дотоодынхоо дэгийн тухай боломжийг, зүй зохисын хэрээр тусгана;

(b) анхны мэдээллийг тухайн улс хүлээн авснаас хойш зургаан сарын дотор холбогдох хоёр улс сэтгэл ханамжтай байхаар уг асуудлыг шийдэж чадахгүй бол, энэ хоёр улсын аль нь ч Хороо болон нөгөө улсдаа мэдэгдээд уг асуудлыг Хороонд шилжүүлэн өгөх эрхтэй;

(c) Хороо нь олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмын дагуу дотоодын бүх боломжтой арга хэрэгслийг тухайн тохиолдолд ашиглаж дууссан гэдгийг магадласны эцэст л асуудлыг авч хэлэлцэнэ. Харин эдгээр арга хэрэгслийг ашиглахыг

хүндэтгэх шалтгаангүйгээр сунжруулж байгаа тохиолдолд энэ журмыг хэрэглэхгүй;

(d) Хороо энэхүү зүйлд заасан мэдээллийг хаалттай хуралдаанаар авч хэлэлцэнэ;

(e) Хороо нь энэ зүйлийн (c) дэд хэсэгт заасныг баримтлахын зэрэгцээ холбогдох улсуудаар уг асуудлыг энэхүү Пактад хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх үндсэн дээр эв зүйгээр шийдвэрлүүлэх зорилгоор тэдэнд найрсаг туслалцаа үзүүлнэ;

(f) Хороо нь хэлэлцүүлэхээр ирүүлсэн ямар ч асуудлаар энэ зүйлийн (b) дэд хэсэгт дурдсан холбогдох улсад хандаж, уг хэрэгт холбогдол бүхий ямар ч мэдээ сэлт өгөхийг хүсч болно;

(g) энэ зүйлийн (b) дэд хэсэгт дурдсан холбогдох улс Хороогоор асуудлыг авч хэлэлцэхэд төлөөлөгчөө оролцуулах, амаар болон бичгээр нэмэлт мэдэгдэл хийх эрхтэй;

(h) Хороо нь энэ зүйлийн (b) дэд хэсэгт заасны дагуу мэдэгдэл хүлээн авсан өдрөөс хойш арван хоёр сарын дотор тайлан оруулна:

i/ хэрэв асуудлыг энэ зүйлийн (e) дэд хэсгийн заалтын хүрээнд шийдвэрлэж чадвал Хороо тайландаа баримт нотолгоо болон гаргасан шийдвэрийн талаар товч бичнэ;

ii/ хэрэв асуудлыг энэ зүйлийн (e) дэд хэсгийн заалтын хүрээнд шийдвэрлэж эс чадвал, Хороо илтгэлдээ баримт нотолгооны талаар товч бичнэ; Пактад оролцогч холбогдох улсаас бичгээр хийсэн танилцуулга болон ам танилцуулгын бичлэгийг тайланд хавсаргана. Асуудал тус бүрээр гаргасан тайлангийн холбогдох улсад танилцуулахаар илгээнэ.

2. Энэхүү Пактад оролцогч арван улс энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалтын дагуу мэдэгдэл хиймэгц энэ зүйлийн заалтууд

хүчин төгөлдөр болно. Эдгээр мэдэгдлийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулахаар шилжүүлэх бөгөөд тэрбээр мэдэгдлийн хуулбарыг бусад оролцогч улсад явуулна. Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдээд мэдэгдлээ хэзээ ч эгүүлэн татаж болно. Тийм үйлдэл нь энэ зүйлийн заалт ёсоор нэгэнт шилжүүлэн өгсөн мэдээллийн холбогдолтой аливаа асуудлыг хэлэлцэхэд саад болохгүй; хэрэв холбогдох оролцогч улс дахин мэдэгдэл хийгээгүй бол, мэдэгдлээ эгүүлэн татсан тухай Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдсэнээс хойш тэрхүү оролцогч аливаа улсын мэдээллийг хүлээн авахгүй.

42 дугаар зүйл

1. (а) Хэрэв 41 дүгээр зүйлийн заалтын дагуу Хороонд шилжүүлэн өгсөн ямар нэг асуудал холбогдох улсуудын санаанд нийцэхээр шийдвэрлэгдээгүй бол, Хороо тэдний зөвшөөрлийг урьдчилан авсны үндсэн дээр тусгай Эвлэрүүлэх комиссыг (цаашид “Комисс” гэж нэрлэнэ) томилж болно. Энэхүү Пактын заалтыг сахих үндсэн дээр асуудлыг эв зүйгээр зохицуулан шийдвэрлэх зорилгоор Комисс холбогдох улсуудад найрсаг туслалцаа үзүүлнэ.

(b) Комисс нь холбогдох улсууд хүлээн авахуйц таван гишүүнээс бүрдэнэ. Комиссын нийт бүрэлдэхүүн буюу зарим гишүүний талаар холбогдох улсууд гурван сарын дотор харилцан тохирч эс чадвал, тэдгээр тохиролцон томилж чадаагүй гишүүдийг Хорооны гишүүдийн дотроос нууц санал хураалтаар, нийт гишүүдийн гуравны хоёрын саналаар сонгоно.

2. Комиссын гишүүд үүргээ өөрийн нэрээр гүйцэтгэнэ. Тэд энэхүү Пактад оролцоогүй улс эсхүл оролцогч холбогдох улс, эсхүл 41 дүгээр зүйлийн дагуу мэдэгдэл хийгээгүй оролцогч улсын иргэн байх ёсгүй.

3. Комисс даргаа сонгож, ажлынхаа дэгийг тогтооно.

4. Комиссын хуралдааныг ер нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын төв байр буюу Нэгдсэн Үндэстний Байгууллагын Женев дэх

салбарын байранд хийнэ. Гэхдээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга болон холбогдох улсуудтай зөвлөлдсөний үндсэн дээр Комиссоос товлосон өөр тохиромжтой газар хуралдааныг хийж болно.

5. 36 дугаар зүйлийн дагуу байгуулсан Нарийн бичгийн дарга нарын газар энэ зүйлийн ёсоор томилогдсон Комисст мөн үйлчилнэ.

6. Хорооны хүлээн авч, судалсан мэдээллийг Комиссын мэдэлд шилжүүлэх бөгөөд Комисс нь холбогдох улсуудад хандаж, хэрэгт хамаарах аливаа мэдээлэл гаргаж өгөх хүсэлт тавьж болно.

7. Комисс асуудлыг бүрэн авч хэлэлцсэний дараа, гэхдээ, ямар ч тохиолдолд, уг асуудлыг хүлээн авснаасаа хойш 12 сарын дотор холбогдох улсуудад уламжлах тайланг Хорооны даргад өгнө:

(a) хэрэв Комисс арван хоёр сарын дотор уг асуудлыг хэлэлцэж эс дуусвал, тухайн асуудлыг хэлэлцэж байгаа явцын тухай товч тайлан бичнэ;

(b) хэрэв тухайн асуудлыг энэхүү Пактад хүлээн зөвшөөрсөн хүний эрхийг сахих үндсэн дээр эв зүйгээр зохицуулан шийдвэрлэж чадвал, Комисс тайландаа баримт нотолгоо болон гаргасан шийдвэрийн талаар товч бичнэ;

(c) хэрэв энэ зүйлийн 7 дахь хэсгийн (b) дэд хэсэгт заасан шийдвэрт хүрч эс чадвал, холбогдох улсуудын хооронд гарсан маргаанд хамаарах баримтын шинжтэй бүх асуудлаар хийсэн дүгнэлт болон асуудлыг эв зүйгээр зохицуулан шийдвэрлэх боломжийн тухай үзэл бодлоо Комиссын тайланд оруулна. Тайланд мөн холбогдох улсуудаас бичгээр өгсөн танилцуулга болон ам танилцуулгын бичлэгийг оруулна;

(d) хэрэв Комиссын тайланг энэ зүйлийн (c) дэд хэсэгт заасны дагуу оруулсан бол, холбогдох улсууд тайланг хүлээж авснаас хойш гурван сарын дотор Комиссын тайлангийн агуулгыг зөвшөөрч байгаа эсэхээ Комиссын даргад мэдэгдэнэ.

8. Энэ зүйлийн заалт нь 41 дүгээр зүйлд тодорхойлсон Хорооны хариуцлагыг хязгаарлахгүй.

9. Холбогдох улсууд нь Комиссын гишүүдийн бүх зардлыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргын тогтоосон төсвийн дагуу адил тэгш хэмжээгээр гаргана.

10. Шаардлагатай бол, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга холбогдох улсууд энэ зүйлийн 9 дэх хэсэгт заасан ёсоор Комиссын гишүүдийн зардлыг нөхөн төлтөл уг зардлыг гаргаж байх эрхтэй.

43 дугаар зүйл

Хорооны гишүүд болон 42 дугаар зүйлийн дагуу томилогдож болох тусгай эвлэрүүлэх комиссын гишүүд нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенцийн холбогдох зүйлүүдэд заасанчлан Нэгдсэн Үндэстний Байгууллагаас томилолтоор явуулдаг шинжээчдэд үзүүлдэг хөнгөлөлт, эрх ямба, дархан эрхийг эдлэнэ.

44 дүгээр зүйл

Энэхүү Пактыг хэрэгжүүлэх тухай заалтыг Нэгдсэн Үндэстний Байгууллага болон төрөлжсөн байгууллагын үүсгэн байгуулсан гэрээ бичгүүдэд заасан буюу тэдгээрийн дагуу хүний эрхийн салбарт тогтсон журамд хохирол учруулахгүйгээр хэрэглэх бөгөөд эдгээр заалт нь энэхүү Пактад оролцогч улсуудын хооронд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа олон улсын ерөнхий болон тусгай хэлэлцээрийн үндсэн дээр маргааныг шийдвэрлэх бусад журам хэрэглэхэд саад болохгүй.

45 дугаар зүйл

Хороо нь ажлынхаа тухай жил бүрийн тайланг Эдийн засаг, нийгмийн зөвлөлөөр дамжуулан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейд оруулж байна.

V ХЭСЭГ

46 дугаар зүйл

Нэгдсэн Үндэстний Байгууллага болон төрөлжсөн байгууллагын янз бүрийн нэгжүүдийн энэхүү Пактад хамаарах асуудлын хувьд гүйцэтгэвэл зохих үүргийг тодорхойлсон Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм, төрөлжсөн байгууллагуудын дүрмийн заалтыг хязгаарласан мэтээр энэхүү Пактын аль ч заалтыг мушгин тайлбарлаж болохгүй.

47 дугаар зүйл

Энэхүү Пактын аль ч заалтыг, байгалийн баялаг, нөөцөө бүрэн чөлөөтэй эзэмших, ашиглах аливаа ард түмний салшгүй эрхийг хязгаарласан мэтээр мушгин тайлбарлаж болохгүй.

VI ХЭСЭГ

48 дугаар зүйл

1. Энэхүү Пактад, Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагын гишүүн аль ч улс, Олон улсын шүүхийн дүрэмд оролцогч аль ч улс, энэхүү Пактад оролцохыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас урьсан бусад аль ч улс гарын үсэг зурж болно.

2. Энэхүү Пактыг соёрхон батлах ёстой. Батламж жуух бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

3. Энэхүү Пактад энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аль ч улс нэгдэн орж болно.

4. Нэгдэн орсон нь, энэ тухай батламж жуух бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулснаар хүчин төгөлдөр болно.

5. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга соёрхон батласан буюу нэгдэж орсон тухай батламж жуух бичгийг хадгалуулсан тухай бүрийг энэхүү Пактад гарын үсэг зурсан буюу нэгдэн орсон бүх улсад мэдээлж байна.

49 дүгээр зүйл

1. Энэхүү Пакт нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад соёрхон батласан буюу нэгдэн орсон тухай гучин тав дахь батламж жуух бичгийг хадгалуулсан өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

2. Соёрхон батласан буюу нэгдэн орсон тухай гучин тав дахь батламж жуух бичгийг хадгалуулсны дараа энэхүү Пактыг соёрхон батласан буюу түүнд нэгдэн орсон улсын хувьд энэхүү Пакт нь холбогдох батламж жуух бичгээ хадгалуулсан өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

50 дугаар зүйл

Энэхүү Пактын заалтууд холбооны улсуудын бүх хэсэгт ямар нэгэн хязгаарлалт буюу чөлөөлөлтгүйгээр үйлчилнэ.

51 дүгээр зүйл

1. Энэхүү Пактад оролцогч аль ч улс түүнд нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргаж болох бөгөөд түүнийгээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад өргөн мэдүүлж болно. Ерөнхий нарийн бичгийн дарга санал болгосон аливаа нэмэлт өөрчлөлтийг энэхүү Пактад оролцогч улсуудад хүргүүлж, түүнийг хэлэлцэж, санал хураах зорилгоор энэхүү Пактад оролцогч улсуудын бага хурал хуралдуулах саналтай эсэхээ өөрт нь мэдэгдэхийг хүснэ. Хэрэв оролцогч улсуудын наад зах нь гуравны нэгээс доошгүй нь тийм бага хурал хуралдуулах саналтай байвал Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Нэгдсэн Үндэстний Байгууллагын ивээлдор бага хурлыг хуралдуулна. Энэхүү бага хуралд оролцож саналаа өгсөн оролцогч

улсын олонхийн дэмжсэн аливаа нэмэлт өөрчлөлтийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейд батлуулахаар оруулна.

2. Нэмэлт өөрчлөлт нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей батлахын зэрэгцээ, энэхүү Пактад оролцогч улсуудын гуравны хоёр нь үндсэний хууль тогтоомжийнхоо дагуу түүнийг батласнаар хүчин төгөлдөр болно.

3. Хүчин төгөлдөр болсон нэмэлт өөрчлөлтийг түүнийг батласан оролцогч улсууд заавал дагаж мөрдөнө. Харин бусад оролцогч улсуудын хувьд энэхүү Пактын заалтууд болон тэдгээр улсаас урьд өмнө батласан аливаа нэмэлт өөрчлөлт заавал дагаж мөрдөх хүчинтэй хэвээр байна.

52 дугаар зүйл

48 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу хийсэн мэдээллийг үл харгалзан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга мөнхүү зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан бүх улсад дараахь зүйлийг мэдээлж байна:

(a) 48 дугаар зүйлийн дагуу гарын үсэг зурсан, соёрхон батласан, нэгдэн орсон тухай;

(b) 49 дүгээр зүйлийн дагуу энэхүү Пактын хүчин төгөлдөр болсон огноо, 51 дүгээр зүйлд зааснаар аливаа нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болсон огнооны тухай.

53 дугаар зүйл

1. Энэхүү Пактын англи, испани, орос, хятад, франц хэлээр үйлдсэн эх бичвэрүүд нь адил хүчинтэй бөгөөд түүнийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын архивт хадгална.

2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү Пактын баталгаатай хуулбарыг 48 дугаар зүйлд заасан бүх улсад хүргүүлнэ.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт

*Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200А (XXI) дугаар тогтоолоор баталж, 1976 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр хүчин төгөлдөр болсон**

Энэхүү Пактад оролцогч улсууд,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэмд тунхагласан зарчмын дагуу хүн төрөлхтөний бүлийн бүх гишүүнд угаас заяасан нэр төр болон тэдний тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шударга ёс, бүх нийтийн энх тайвны үндэс болохыг анхааралдаа авч,

эдгээр эрх нь хүнд угаас заяасан нэр төрөөс үүдэн гарч байгааг хүлээн зөвшөөрч,

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд зааснаар хүн бүр эдийн засаг, нийгэм соёлын эрхээ улс төр, иргэний эрхийн адил эдлэх нөхцлөөр хангагдсан үед л айх аюулгүй, гачигдах зүйлгүй байх чөлөөт бие хүний туйлын хүслэн биелэгдэхийг хүлээн зөвшөөрч,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм ёсоор улсууд хүний эрх, эрх чөлөөг бүх нийтээр хүндэтгэх хийгээд сахих явдлыг хөхиүлэн дэмжих үүрэгтэйг анхааралдаа авч,

хувь хүн бүр бусад хүн болон хамт олныхоо өмнө үүрэг хүлээхийн сацуу энэхүү Пактад хүлээн зөвшөөрсөн эрхийг хөхиүлэн дэмжүүлэх, сахиулах ёстойг анхааралдаа авч,

дор дурдсан зүйлийг тохиролцов:

I ХЭСЭГ

1 дүгээр зүйл

1. Бүх ард түмэн өөрөө засан тохинох эрхтэй. Энэ эрхийнхээ дагуу тэд улс төрийн байдлаа чөлөөтэй тогтоож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлөө чөлөөтэй хангана.

2. Бүх ард түмэн зорилгодоо хүрэхийн тулд харилцан ашигтай байх зарчим дээр тулгуурласан олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа болон олон улсын эрх зүйгээр хүлээсэн аливаа үүрэгт хохиролгүйгээр байгалийн баялаг, эх нөөцөө чөлөөтэй эзэмшинэ. Аливаа ард түмнийг ямар ч тохиолдолд оршин тогтнох хэрэглүүрээс нь салгаж үл болно.

3. Энэхүү Пактад оролцогч бүх улс, түүний дотор өөрөө захиргаагүй болон асрамжийн нутаг дэвсгэрийг захирах хариуцлага хүлээсэн улс, Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн заалтын дагуу өөрөө засан тохинох эрхийг хэрэгжүүлэхийг хөхиүлэн дэмжиж, энэ эрхийг хүндэтгэх ёстой.

II ХЭСЭГ

2 дугаар зүйл

1. Энэхүү Пактад оролцогч улс бүр дангаараа болон олон улсын тусламж, хамтын ажиллагаагаар, тухайлбал эдийн засаг, техникийн салбарт, энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг бүрэн хэрэгжүүлэхийг дэвшилттэйгээр хангахын тулд хууль тогтоомжийн арга хэмжээг оролцуулан, зохистой арга хэмжээг байгаа бүх боломжийнхоо хэрээр авах үүрэгтэй.

2. Энэхүү Пактад оролцогч улсууд арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, төрсөн болон бусад нөхцөл байдлаар алагчилахгүйгээр энэхүү Пактад тунхагласан эрхийг хэрэгжүүлэх баталгааг бий болгох үүрэгтэй.

3. Хөгжиж байгаа улсууд хүний эрх болон үндэсний эдийн засгаа зохих ёсоор харгалзан үзсэний үндсэн дээр энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эдийн засгийн эрхийг өөрийн улсын иргэн бус хүмүүст хэрэгжүүлэх баталгааг ямар хэмжээгээр бий болгохоо тодорхойлж болно.

3 дугаар зүйл

Энэхүү Пактад оролцогч улсууд түүнд заасан эдийн засаг, нийгэм, соёлын бүх эрхийг эрэгтэй, эмэгтэйчүүдэд тэгш эдлүүлэх нөхцлийг хангах үүрэгтэй.

4 дүгээр зүйл

Аливаа улсаас энэхүү Пактын дагуу хангах ёстой эрхийг эдлүүлэхдээ эдгээр эрхэд зөвхөн хуульд тодорхойлсон ёсоор хязгаарлалт тогтоож болох бөгөөд энэ нь тэдгээр эрхийн уг чанарт нийцсэн, ардчилсан нийгэмд гагцхүү нийтийн сайн сайхан байдалд туслах зорилготой байх ёстой гэдгийг энэхүү Пактад оролцогч улсууд хүлээн зөвшөөрнө.

5 дугаар зүйл

1. Аливаа улс, бүлэг болон этгээд энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн аливаа эрх, эрх чөлөөг устгахад чиглэсэн, эсхүл түүнд зааснаас илүү хэмжээгээр хязгаарлахад чиглэсэн аливаа үйл ажиллагаа явуулах, аливаа үйлдэл хийх эрхтэй байх мэтээр Пактын аливаа заалтыг мушгин тайлбарлаж болохгүй.

2. Аливаа улсад хууль, конвенц, журам, заншлаар хүлээн зөвшөөрсөн буюу тогтоосон хүний үндсэн эрхийг энэхүү Пактад бүхэлд нь хүлээн зөвшөөрөөгүй буюу бүрэн бус хүлээн зөвшөөрсөн гэдэг шалтгаанаар хязгаарлаж, багасгаж хэрхэвч болохгүй.

III ХЭСЭГ

6 дугаар зүйл

1. Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүр аж төрөхдөө чөлөөтэй сонгох, чөлөөтэй тохиролцох боломжийг олгосон хөдөлмөрлөх эрхийг хүлээн зөвшөөрч, энэ эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зохистой алхам хийнэ.

2. Энэ эрхийг бүрэн хэрэгжүүлэх зорилгоор энэхүү Пактад оролцогч улсуудын авах арга хэмжээ нь техник мэргэжлийн дадлага, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, эдийн засаг, нийгэм, соёлын хэлбэрэлтгүй хөгжлийг хангах арга замыг хэрэгжүүлэх хувь хүний улс төр, эдийн засгийн үндсэн эрх чөлөөг баталгаажуулах нөхцөлд үр ашигтай ажлаар бүрэн хангах алхмыг хамаарна.

7 дугаар зүйл

Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүр хөдөлмөрийн шударга, таатай нөхцлөөр хангагдах эрхийг хүлээн зөвшөөрөх бөгөөд тухайлбал:

(a) бүх хөдөлмөр эрхлэгчдэд наад зах нь дараахь байдлыг хангахуйц цалин хөлс олгох:

i/ цалин хөлсийг шударгаар тогтоох, аливаа ялгаваргүйгээр адил үнэлгээтэй хөдөлмөрт тэгш цалин хөлс олгох, чингэхдээ, тухайлбал, эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдээс доргүй хөдөлмөрлөх нөхцлийг бий болгох, тэдний адил хөдөлмөрт нь тэгш цалин хөлс олгох;

ii/ энэхүү Пактын заалтын дагуу хөдөлмөр эрхлэгч, түүний гэр бүлийн гишүүдэд хангалуун амьдрах боломж олгох.

(b) аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон ажлын нөхцлийг бүрдүүлэх;

(с) гагцхүү ажилласан хугацаа, мэргэшилд үндэслэн зохих дээд шатны ажилд дэвших адил боломжийг хүн бүрт олгох;

(d) амрах, зав чөлөөтэй байх, ажлын цагийг зохистойгоор хязгаарлах, ээлжийн амралтыг цалин хөлстэйгээр эдлүүлэх, баярын өдөрт цалин хөлс олгохыг хамаарна.

8 дугаар зүйл

1. Энэхүү Пактад оролцогч улсууд дор дурдсан эрхийг хангах үүрэгтэй:

(a) хүн бүр эдийн засаг, нийгмийн ашиг сонирхлоо хамгаалах, хэрэгжүүлэхийн тулд үйлдвэрчний эвлэл байгуулах, журмыг нь сахих үндсэн дээр сонгосон байгууллагадаа элсэн орох эрхтэй. Дээр дурдсан эрхийг эдлэхэд хуульд заасан буюу ардчилсан нийгэмд шаардагдах үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах ашиг сонирхлоос бусад ямарваа хязгаарлалт тогтоохыг хориглоно;

(b) үйлдвэрчний эвлэлээс үндэсний холбоо, нэгдэл байгуулах эрх, түүнчлэн үндэсний холбоо, нэгдлээс олон улсын үйлдвэрчний байгууллагыг үүсгэх буюу түүнд нэгдэн орох эрх;

(с) үйлдвэрчний эвлэл хуулиар тогтоосон бөгөөд ардчилсан нийгэмд шаардагдах үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах ашиг сонирхлоос бусад ямарваа хязгаарлалтгүйгээр үйл ажиллагаагаа саадгүй явуулах эрх;

(d) ажил хаях эрхтэй бөгөөд түүнийгээ тухайн улсын хуульд нийцүүлэн эдлэнэ.

2. Энэ зүйлийн заалт нь зэвсэгт хүчин, цагдаагийн газар, төрийн захиргааны бүрэлдэхүүнд орсон этгээдээс энэ эрхийг эдлэхэд нь хууль ёсны хязгаарлалт тогтооход саад болохгүй.

3. Энэ зүйлийн аливаа заалт Чөлөөтэй эвлэлдэн нэгдэх болон байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 1948 оны конвенцид заасан баталгаанд хохирол учруулахуйц хууль тогтоомжийг батлах буюу эдгээр баталгаанд хохирол учруулахаар хуулийг хэрэглэх эрхийг дурдсан Конвенцид оролцогч улсуудад олгохгүй.

9 дүгээр зүйл

Энэхүү Пактад оролцогч улсууд нийгмийн даатгалыг оролцуулан, хүн бүрийн нийгмийн хангамжинд хамрагдах эрхийг хүлээн зөвшөөрнө.

10 дугаар зүйл

Энэхүү Пактад оролцогч улсууд дор дурдсан зүйлийг хүлээн зөвшөөрнө:

1. Нийгмийн жам ёсны үндсэн нэгж болсон гэр бүлд, ялангуяа түүний үүсэх үед, бие дааж амжаагүй хүүхдийг халамжлах, хүмүүжүүлэх хариуцлага хүлээж байгаа үед, боломжийн хэрээр халамжлан хамгаалж тусална. Гэрлэгсэд чөлөөтэй, харилцан зөвшөөрөлцсөний үндсэн дээр гэрлэнэ.

2. Эхчүүдийг хүүхэд төрүүлэхийн өмнөх болон дараахь тодорхой хугацаанд онцгойлон хамгаална. Ажиллаж байгаа эхчүүдэд энэ хугацаанд цалинтай чөлөө буюу нийгмийн хангамжийн зохих тэтгэмж олгоно.

3. Бүх хүүхэд, өсвөр насныхны тухайд гэр бүлийн гарал буюу бусад үндэслэлээр алагчилахгүйгээр хамгаалах, тусламж үзүүлэх онцгой арга хэмжээ авч байх ёстой. Хүүхэд, өсвөр насныхныг эдийн засаг, нийгмийн дарлал мөлжлөгөөс хамгаалж байх ёстой. Тэднийг ёс суртахуун, эрүүл мэндэд нь харш, амь насанд нь аюултай буюу хэвийн өсөлт хөгжилтөд нь хор болохуйц салбарт ажиллуулсан бол хуулийн дагуу шийтгэнэ. Үүнээс гадна төр хүүхдийг ажиллуулах насны хязгаарыг тогтоож, үүнээс доош насны хүүхдийг хөлслөн

ажиллуулахыг хориглож, зөрчсөн тохиолдолд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэж байна.

11 дүгээр зүйл

1. Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүрийн болон түүний өрх гэрийн хүрэлцээтэй хоол хүнс, хувцас, орон сууцыг оролцуулан, амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх, амьдралынхаа нөхцлөө байнга сайжруулах эрхийг нь хүлээн зөвшөөрнө. Оролцогч улсууд энэ талаар чөлөөтэй зөвшилцөлд үндэслэсэн олон улсын хамтын ажиллагаа чухал ач холбогдолтойг хүлээн зөвшөөрч, энэ эрхийн хэрэгжилтийг хангах зохистой арга хэмжээ авна.

2. Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүрийн өлсгөлөнгөөс ангид аж төрөх үндсэн эрхийг хүлээн зөвшөөрч, тодорхой хөтөлбөр хэрэгжүүлэхийг оролцуулан, дангаараа буюу олон улсын хамтын ажиллагааны хэлбэрээр шаардлагатай арга хэмжээг дараахь зорилгоор авна:

(a) байгалийн эх нөөцийг хамгийн үр ашигтай эзэмших, ашиглах зорилгоор техник, шинжлэх ухааны мэдлэгийг өргөн ашиглах, хүнс тэжээлийн тухай мэдлэгийг дэлгэрүүлэх, газар тариалангийн тогтолцоог боловсронгуй болгох, шинэтгэл хийх замаар хоол хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах, хуваарилах арга ажиллагааг сайжруулах;

(b) хүнсний бүтээгдэхүүн экспортлогч буюу импортлогч улсын асуудлыг анхааралдаа авч харгалзан дэлхийн хоол хүнсний нөөцийн шударга хуваарилалтыг хангах.

12 дугаар зүйл

1. Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүрийн бие бялдрын болон сэтгэцийн эрүүл мэнд дээд түвшинд хүрсэн байх эрхийг хүлээн зөвшөөрнө.

2. Энэхүү Пактад оролцогч улсууд энэ эрхийг бүрэн хэрэгжүүлэхэд шаардагдах дараахь арга хэмжээг авна:

(а) нялхсын эндэгдлийг багасгах, хүүхдийн эрүүл чийрэг өсөлтийг хангах;

(b) гадаад орчны болон үйлдвэрлэлийн эрүүл ахуйг бүх талаар сайжруулах;

(с) халдварт өвчин, тухайн нутгийн өвчин, мэргэжлийн болон бусад өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, тийм өвчинтэй тэмцэх;

(d) өвчилсөн тохиолдолд эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, сувилах нөхцлийг бүгдэд бий болгох.

13 дугаар зүйл

1. Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүр сурч боловсрох эрхийг хүлээн зөвшөөрнө. Боловсрол хүний хувийн зан чанарыг бүхэлд нь бүрэн хөгжүүлэх, нэр төрөө ухамсарлахад чиглэгдэж, хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэн бэхжүүлэх ёстойг зөвшөөрч байна. Боловсрол хүн бүрт чөлөөт нийгмийн тустай гишүүн байх, бүх үндэстэн, арьс үндэстэн, угсаа, шашин шүтлэгээрээ ялгавар бүхий бүлгийн хувьд харилцан ойлголцох, хүлцэн тэвчих, эвсэн найрамдах, мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагаас энх тайвныг сахих талаар явуулж байгаа үйл ажиллагаанд дөхөм үзүүлэхэд бүгдэд боломж олгох ёстойг зөвшөөрч байна.

2. Энэхүү Пактад оролцогч улсууд энэ эрхийг бүрэн хэрэгжүүлэхийн тулд:

(а) хүн бүрт бага боловсролыг заавал, үнэ төлбөргүй олгох;

(b) үнэ төлбөргүй боловсрол олгохыг дэвшилттэйгээр нэвтрүүлэх бүхийлшаардлагатай арга хэмжээ авах замаар, техник-мэргэжлийн дунд сургуулийн боловсролыг оролцуулан, дунд боловсролын төрөл бүрийн хэлбэрийг бүгдэд боломжтой, хүртээмжтэй болгох;

(с) үнэ төлбөргүй боловсрол олгохыг дэвшилттэйгээр нэвтрүүлэх бүхий л шаардлагатай арга хэмжээ авах замаар, авъяас чадварыг нь харгалзан, дээд боловсролыг бүгдэд ижил хүртээмжтэй болгох;

(d) бага боловсролтой бүрэн болоогүй буюу бага сургуулийг бүрэн төгсөөгүй хүн суурь боловсролтой болохыг хөхиүлэн дэмжих буюу эрчимжүүлэх;

(e) бүх шатны сургуулийн тогтолцоог эрчимтэй хөгжүүлэх, хангалттай тэтгэлэгийн тогтолцоотой болох, багш нарын материаллаг нөхцлийг байнга сайжруулах арга хэмжээг авах ёстой.

3. Энэхүү Пактад оролцогч улсууд эцэг эх болон зохих нөхцөлд хууль ёсны асран хамгаалагчаас хүүхэддээ төрийн байгууллагаас байгуулсан сургууль төдийгүй, боловсрол олгох талаар улсаас тогтоосон буюу батласан наад захын шаардлагыг хангаж байгаа бусад сургуулийг сонгох, өөрийн хувийн итгэл, үнэмшлийн дагуу шашин шүтлэг болон ёс суртахууны боловсрол олгох боломжийг хангана.

4. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зарчмыг хатуу баримталсан бөгөөд тэр сургуулиар олгож байгаа боловсрол нь төрөөс тогтоосон наад захын шаардлагын доод хэмжээг хангасан нөхцөлд, хувь этгээд буюу байгууллагаас сургууль байгуулах, удирдах эрх чөлөөг хязгаарласан утгаар энэ зүйлийн аливаа хэсгийг тайлбарлаж болохгүй.

14 дүгээр зүйл

Энэхүү Пактад оролцогч улс бүр түүнд оролцогч болох үедээ өөрийн эзэмшлийн нутаг дэвсгэр дээр буюу шүүхийн харьяалалд нь хамаарах бусад нутаг дэвсгэр дээр бага боловсролыг заавал, үнэ төлбөргүй болгох журам тогтоож чадаагүй байсан бол, бүх нийтийн боловсролыг заавал, үнэ төлбөргүй болгох зарчмыг зохих хугацаанд, дэвшилттэйгээр хэрэгжүүлэх арга хэмжээний тодорхой төлөвлөгөөг хоёр жилийн дотор боловсруулан, батлах үүрэг хүлээнэ.

15 дугаар зүйл

1. Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүр дараахь эрх эдлэхийг хүлээн зөвшөөрнө:

(a) соёлын амьдралд оролцох;

(b) шинжлэх ухааны дэвшлийн үр дүнг ашиглах, түүнийг хэрэглэх;

(c) өөрийнхөө туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны аливаа бүтээлтэй холбогдон үүссэн ёс суртахууны болон эд материалын ашиг сонирхлыг хамгаалуулах.

2. Энэхүү Пактад оролцогч улсуудаас энэ эрхийг бүрэн хэрэгжүүлэх үүднээс авч явуулбал зохих арга хэмжээнд шинжлэх ухаан, соёлын ололтыг хамгаалах, хөгжүүлэх, дэлгэрүүлэхэд шаардагдах арга хэмжээ багтана.

3. Энэхүү Пактад оролцогч улсууд шинжлэх ухааны судалгааны болон уран бүтээлийн үйл ажиллагаа явуулахад зайлшгүй шаардагдах эрх чөлөөг хүндэтгэх үүрэгтэй.

4. Энэхүү Пактад оролцогч улсууд шинжлэх ухаан, соёлын салбарт олон улсын харилцаа, хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжиж, хөгжүүлэх нь үр ашигтай гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

IV ХЭСЭГ

16 дугаар зүйл

1. Энэхүү Пактад оролцогч улсууд энэ хэсэгт заасны дагуу Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээ, хүрсэн дэвшлийнхээ тухай тайлан гаргаж байх үүрэг хүлээнэ.

2. (a) Бүх тайланг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хүргүүлэх бөгөөд тэрээр тайлангийн хувийг энэхүү Пактын заалтын дагуу Эдийн засаг, нийгмийн зөвлөлд хэлэлцүүлэхээр илгээнэ.

(b) төрөлжсөн байгууллагын гишүүн бөгөөд энэхүү Пактад оролцогч улсаас ирүүлсэн тайлан буюу түүний хэсэг нь тухайн байгууллагын үндэслэн байгуулсан баримт бичгийн дагуу

түүний үйл ажиллагаатай холбоотой байвал Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга тайлан буюу түүний хэсгийг холбогдох байгууллагад хүргүүлнэ.

17 дугаар зүйл

1. Энэхүү Пактыг хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилийн хугацаанд Эдийн засаг, нийгмийн зөвлөл энэхүү Пактад оролцогч улсууд болон холбогдох төрөлжсөн байгууллагуудтай зөвлөлдөн хөтөлбөр боловсруулж гаргах бөгөөд энэхүү хөтөлбөрийн дагуу оролцогч улсууд зохих үе шатаар тайлан гарган өгч байна.

2. Энэхүү Пактаар хүлээсэн үүргийг биелүүлэхэд нөлөөлж байгаа хүчин зүйл, бэрхшээлийг тайланд тусгаж болно.

3. Хэрэв энэхүү Пактад оролцогч улсууд Нэгдсэн Үндэстний Байгууллага болон аливаа төрөлжсөн байгууллагад зохих мэдээлэл урьд нь өгсөн бол, тэрхүү мэдээлэл дахин өгөх шаардлагагүй бөгөөд харин тийнхүү өгсөн мэдээллийг иш татан дурдахад л хангалттай.

18 дугаар зүйл

Эдийн засаг, нийгмийн зөвлөл нь хүний эрх, үндсэн эрх чөлөөний талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд төрөлжсөн байгууллагуудаас үйл ажиллагааны хүрээнд хамаарах, энэхүү Пактын заалтыг биелүүлэх явцад хүрсэн дэвшлийн талаар тайлан гаргуулан авах тухай тэдгээр байгууллагатай тохиролцож болно. Тайланд дээрх байгууллагуудаас Пактын заалтыг хэрэгжүүлэх талаар гаргасан шийдвэр, зөвлөмжийн тухай тодорхой оруулж болно.

19 дүгээр зүйл

Эдийн засаг, нийгмийн зөвлөл 16, 17 дугаар зүйлд заасны дагуу оролцогч улсуудаас ирүүлсэн хүний эрхтэй холбогдол бүхий тайлан болон 18 дугаар зүйлд заасны дагуу төрөлжсөн байууллагуудаас

ирүүлсэн хүний эрхийн холбогдолтой тайланг Хүний эрхийн комисст судалгаа хийлгэх болон ерөнхий зөвлөмж гаргуулахаар, эсхүл зарим тохиолдолд мэдээлэхээр шилжүүлж болно.

20 дугаар зүйл

Энэхүү Пактад оролцогч улсууд болон холбогдох төрөлжсөн байгууллагууд 19 дүгээр зүйлийн дагуу гаргасан ерөнхий зөвлөмжийн талаар буюу Хүний эрхийн комиссын аль нэг тайлан, түүний иш татаж байгаа аль нэг баримт бичгийн талаар Эдийн засаг, нийгмийн зөвлөлд саналаа илэрхийлж болно.

21 дүгээр зүйл

Эдийн засаг, нийгмийн зөвлөл ерөнхий зөвлөмж болон энэхүү Пактад оролцогч улсууд, төрөлжсөн байгууллагуудаас энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг бүх нийтээр хангах талаар авсан арга хэмжээ, хүрсэн үр дүнгийн талаар ирүүлсэн мэдээллийн тухай хураангуй тайланг Ерөнхий Ассамблейд үе үе оруулж байна.

22 дугаар зүйл

Эдийн засаг, нийгмийн зөвлөл нь техникийн тусламж үзүүлэх асуудал эрхэлсэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын бусад байгууллага, тэдгээрийн туслах байгууллага болон төрөлжсөн байгууллагуудын анхаарлыг энэхүү Пактыг амьдралд аажмаар, үр ашигтай хэрэгжүүлэхэд өөрийн эрх хэмжээний дагуу олон улсын арга хэмжээ авах шаардлагатай эсэхийг шийдэхэд нь тэдгээр байгууллагад дөхөм үзүүлэхүйц хийгээд Пактын энэхүү хэсэгт дурдсан тайлантай холбоотой аливаа асуудалд хандуулж болно.

23 дугаар зүйл

Энэхүү Пактад оролцогч улсууд түүгээр хүлээн зөвшөөрсөн эрхийг хэрэгжүүлэхэд дөхөм үзүүлэх олон улсын арга хэмжээнд конвенц байгуулах, зөвлөмж гаргах, техникийн тусламж үзүүлэх, зөвлөлдөх зорилгоор бүсийн болон мэргэжлийн зөвлөгөөн хийх,

түүнчлэн засгийн газруудтай хамтран судалгаа хийх зэрэг арга хэмжээ багтана гэж үзэж байна.

24 дүгээр зүйл

Энэхүү Пактад тусгагдсан асуудлын талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөл бүрийн газар болон төрөлжсөн байгууллагуудын гүйцэтгэвэл зохих үүргийг тодорхойлсон Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм, төрөлжсөн байгууллагуудын дүрмийн заалтуудын ач холбогдлыг бууруулсан мэтээр энэхүү Пактын аливаа заалтыг тайлбарлаж болохгүй.

25 дугаар зүйл

Байгалийн баялаг, нөөцийг бүрэн чөлөөтэй эзэмших, ашиглах бүх ард түмний салшгүй эрхийг хязгаарласан мэтээр энэхүү Пактын аливаа заалтыг мушгин тайлбарлаж болохгүй.

V ХЭСЭГ

26 дугаар зүйл

1. Энэхүү Пакт нь Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагын гишүүн аливаа улс, Олон улсын шүүхийн дүрэмд оролцогч аливаа улс, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас энэхүү Пактад оролцохыг урьсан бусад аливаа улс гарын үсэг зурахад нээлттэй байна.
2. Энэхүү Пактыг соёрхон баталбал зохино. Батламж жуух бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.
3. Энэхүү Пакт энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аливаа улс нэгдэн ороход нээлттэй байна.
4. Нэгдэж орсон тухай батламж жуух бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулснаар нэгдэн орсон гэж үзнэ.

5. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга соёрхон батласан буюу нэгдэн орсон батламж жуух бичгийг хадгалуулсан бүрийг энэхүү Пактад гарын үсэг зурсан буюу нэгдэж орсон бүх улсад мэдээлж байна.

27 дугаар зүйл

1. Энэхүү Пакт нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад соёрхон батласан болон нэгдэн орсон тухай гучин тав дахь батламж жуух бичгийг хадгалуулснаас хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

2. Соёрхон батласан болон нэгдэж орсон тухай гучин тав дахь батламж жуух бичгийг хадгалуулсны дараа энэхүү Пактыг соёрхон батласан буюу түүнд нэгдэн орсон улсын хувьд батламж жуух бичгээ хадгалуулснаас хойш гурван сарын дараа энэхүү Пакт хүчин төгөлдөр болно.

28 дугаар зүйл

Энэхүү Пактын заалтууд холбооны улсуудын бүх хэсэгт ямар нэгэн хязгаарлалтгүйгээр адил үйлчилнэ.

29 дүгээр зүйл

1. Энэхүү Пактад оролцогч аливаа улс нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргаж, энэ тухайгаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэж болно.

Ерөнхий нарийн бичгийн дарга дэвшүүлсэн аливаа нэмэлт өөрчлөлтийн утхай саналыг энэхүү Пактад оролцогч улсуудад хүргүүлж, түүнийг хэлэлцэж, санал хураах зорилгоор энэхүү Пактад оролцогч улсуудын бага хурал хуралдуулах саналтай эсэхээ мэдэгдэхийг хүснэ. Хэрэв оролцогч улсуудын гуравны нэгээс доошгүй нь бага хурал хуралдуулах саналтай байвал Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Нэгдсэн Үндэстний Байгууллагын ивээл дор бага хурлыг хуралдуулна. Энэхүү бага хуралд оролцсон хийгээд саналаа өгсөн оролцогч

улсын олонхийн дэмжсэн аливаа нэмэлт өөрчлөлтийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейд батлуулахаар оруулна.

2. Эдгээр нэмэлт өөрчлөлт нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей баталж, энэхүү Пактад оролцогч улсуудын гуравны хоёр нь үндэсний хууль тогтоомжийнхоо дагуу тэдгээрийг баталмагц хүчин төгөлдөр болно.

3. Хүчин төгөлдөр болсон нэмэлт өөрчлөлт нь түүнийг хүлээн зөвшөөрсөн оролцогч улсуудын хувьд заавал дагаж мөрдөх зүйл болно. Харин бусад оролцогч улсуудын хувьд энэхүү Пактын заалт болон тэдгээр улсаас урьд өмнө хүлээн зөвшөөрсөн аливаа нэмэлт өөрчлөлт заавал дагаж мөрдөх хүчинтэй хэвээр байна.

30 дугаар зүйл

26 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу хийсэн мэдээллийг үл харгалзан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга мөн зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан бүх улсад дараахь зүйлийн талаар мэдээлж байна:

(a) 26 дугаар зүйлийн дагуу гарын үсэг зурсан, соёрхон батласан, нэгдэн орсон тухай;

(b) 27 дугаар зүйлийн дагуу энэхүү Пактын хүчин төгөлдөр болсон огноо, 29 дүгээр зүйлд зааснаар аливаа нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болсон огнооны тухай.

31 дүгээр зүйл

1. Энэхүү Пактын хятад, англи, франц, орос, испани хэлээр үйлдсэн эх бичвэрүүд нь адил хүчинтэй бөгөөд түүнийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын архивт хадгална.

2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү Пактын баталгаат хуулбарыг 26 дугаар зүйлд заасан бүх улсад хүргүүлнэ.

Цөөнхийн эрхийн асуудал*

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нэг талаас иргэдийн дуу хоолой болдог ч, нөгөө талаас олон нийтийн үзэл бодлыг төлөвшүүлдэг хүчтэй зэмсэг билээ. Олон нийтийн үзэл бодлыг төлөвшүүлэгч, чиглүүлэгч утгаараа хэвлэл мэдээллийн хэрэгсэл нийгмийн өмнө ямарваа мэдээллийг баримт дээр тулгуурлан, үнэн зөв, өөрсдийн үзэл бодлыг тусгалгүй хүргэх томоохон ёс зүйн үүрэг хүлээдэг. Энэхүү ёс зүйн үүрэг нь ялангуяа Монголын цөөнх болсон хүмүүсийн тухай мэдээлэхэд нэн хамаатай. Хэвлэн нийтлэх, үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь нэн чухал хүний эрхийн асуудал болохын зэрэгцээ хүний эрхийн тулгуур асуудал болсон энэ үед нийгмийн өөр өөр цөөнхийн тухай хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэрхэн яаж мэдээлснээс цөөнх бүлгүүдийн хүний ба иргэний эрх, эрх чөлөөгөө эдлэх явдал шууд пропорционал хамааралтай юм.

Хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр цацагдаж буй мэдээлэл нь хэт нэг талыг барьсан, явцуу, цаашлаад стереотип буюу нийгмийн хэвшмэл буруу хандлагыг батжуулсаар байгаа үед нийгмийн цөөнх болсон үндэстний цөөнх, бэлгийн цөөнх буюу лесбиан, гей, бисексуал, трансжендэр хүмүүс, ХДХВ/ДОХ-той амьдарч буй хүмүүс, биеэ үнэлэгч, бусад цөөнх бүлгийн эрх, эрх чөлөө зөрчигдөх хөрс байсаар байх болно.

Монгол Улсын Үндсэн хууль болоод Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенциор хүний төрөлхийн болон бусад шинж чанарыг үл харгалзан хүн бүр эрх тэгш, аливаа үндэслэлээр ялгаварлан гадуурхахыг хориглоно хэмээн заасан байдаг ч эдгээр бүлэг хүмүүсийн үндсэн эрх, эрх чөлөө нь бусад хүмүүстэй харьцуулвал илүү ноцтой, байнга зөрчигдсөөр байгааг цөөнхийн хүний эрхийн илтгэлийг бичих ажлын хэсэг баримтжуулсан юм. Эрх зүйт нийгэмд хүрэхээр тэмүүлж буй Монгол Улсын хувьд хэн байх эсэхээс нь үл хамааран тухайн хүний эрхийг дээдлэх, эрхээ эдлэх нөхцөл бололцоог хангах асуудал нь төрийн чухал үүрэг билээ.

Тиймээс улс орныхоо хилийн дээс дотор амьдарч буй хүн бүрийн

*ЛГБТ төв нь Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэгт ТББ-ын Форумас илгээх "Цөөнхийн эрх"-ийн илтгэл бичих туршлага дээрээ тулгуурлан энэхүү хэсгийг бэлтгэсэн болно.

эрхийг ханган эдлүүлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн ёс зүйт, хариуцлагатай хандлага, тэнцвэрт, бодит баримтад тулгуурласан мэдээлэл нь жинхэнэ эерэг, бүтээлч хүчин зүйл болох нь гарцаагүй юм. Энэ хүрээнд дараах хэдэн цөөнхийн асуудлыг авч үзлээ.

Үндэстний цөөнх

Үндэстний цөөнхийн өмнө тулгарч буй асуудал бол тэдний төрөлх хэл дээрээ мэдээлэл хүртэх эрх нь зөрчигддөг байдал юм. Үндэстний цөөнх казах болон духачууд монгол хэлээр бүрэн дүүрэн нэвтэрдэггүйгээс, мөн тэдний хэл дээр нийтэлж, нэвтрүүлдэг хэвлэл мэдээллийн хэрэгсэл байдаггүйгээс тэд мэдээллээс маш их хоцорч, улмаар тэдний сурч боловсрох, мэдээлэл хүртэх эрх нь зөрчигдөхөд хүргэж байна.

Цаашлаад духачуудын тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлдэг байдал нь бодит байдалтай нийцдэггүй. Нэр томъёоны хувьд ч мөн өөрсдийгөө цаатан бус, духа хэмээн нэрийддэг нэрээр нь тэднийг нэрлэх нь зүйтэй юм. Духачуудыг ядууралд нэрвэгдсэн, хагас зэрлэг байдлаар амьдардаг хэмээн дүрслэх нь цөөнгүй. Тэд уламжлалт аж ахуй болсон цаа бугын аж ахуйгаа эрхлэн амьдардаг үндэстний цөөнх билээ. Дэд бүтэц муу хөгжсөн нутгаар нутаглах эдгээр хүмүүс уламжлалт аж ахуйгаа эрхлэх эрхээ эдлэж, өөрсдийн соёл уламжлалыг хойч үедээ өвлүүлж байна гэдэг талаас хэвлэл мэдээллийн хэрэгслүүд төдийлөн анхаарч хардаггүй.

Бэлгийн цөөнх

Монголын лесбиян, гей, бисексуал, трансжендэр хүмүүс буюу бэлгийн цөөнхийн хувьд хэвлэл мэдээллээр мэдээлэгдэх байдал нь нэн асуудалтай байдаг. ЛГБТ төвийн 2009 оны 6-р сард радио, телевиз, сонин хэвлэлийн дөчин ажилтнуудын дунд явуулсан судалгаа нь сэтгүүлчдийн ойлголт, үг хэллэг, зарчмын талаар тод дүр зургийг дүрсэлсэн. “Бэлгийн чиг баримжаа гэж юу вэ?” гэсэн асуултад сэтгүүлчдийн ихэнх буруу хариулж, эсвэл хариулаагүй орхижээ. Хүн бэлгийн чиг баримжаатай төрдөг үү хэмээх асуултад оролцогчдын 69% нь “тийм” гэсэн хэрнээ дараагийн асуулт болох

“Хүн бэлгийн чиг баримжаагаа өөрчилж болох уу?” гэсэн асуултад 54% нь “болно” гэж хариулжээ. Сэтгүүлчдийн 25% нь “Сенсаац дэгдээхийн тулд ЛГБТ хүмүүсийн тухай хэвлэл мэдээллийн хэрэгсэл мэдээлдэг” гэсэн бол зөвхөн 12% нь “ЛГБТ хүмүүс болон тэдний өмнө тулгардаг асуудлыг нийгэмд илүү сайн ойлгуулж, мэдлэг олгохын тулд мэдээлдэг” гэжээ. Харин “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ЛГБТ хүмүүст хамааралтай асуудлыг бодит, үнэн зөв, хувь хүний үзэл бодлыг тусгалгүй мэдээлэх үүрэг хариуцлагыг хүлээдэг үү?” гэсэн асуултад таван сэтгүүлч тийм үүрэг ер хүлээдэггүй, хоёр нь мэдэхгүй, нэг нь асуултыг ойлгоогүй гэжээ.

Харин ЛГБТ хүмүүсийн тухай мэдээлэх нь сүүлийн жилүүдэд ихэссэн гэж үзсэн сэтгүүлч арван гурав байсан ба ихэнхдээ гей хүмүүсийн тухай мэдээлэл гардаг гэжээ. “ЛГБТ хүмүүсийн талаар нийгэм ямар үзэл бодолтой байдаг вэ?” гэсэн асуултад 22 нь буюу үнэмлэхүй ихэнх нь “Маш сөрөг үзэл бодолтой байдаг” гэсэн хариултыг өгчээ. Харин “Хэвлэл мэдээлэл нь ЛГБТ хүмүүсийн тухай нийгмийн ойлголтод нөлөөлсөн гэж та боддог уу? Тийм бол хэрхэн нөлөөлсөн бэ?” гэсэн асуултад 35 сэтгүүлч хариулсны 11 нь “Сэтгүүлчид ЛГБТ хүмүүсийн тухай нийгмийн ойлголтод сөргөөр нөлөөлсөн”, 4 нь эерэг сөргийг нь тодорхойлолгүй “Нөлөөлсөн” хэмээн хариулжээ⁵.

Энэхүү судалгааг харахад ЛГБТ хүмүүсийн тухай үнэн зөв, бодитоор мэдээлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг чухал болохыг сэтгүүлчид өөрсдөө хүлээн зөвшөөрсөн байна. Харин нийгэмд мэдээлэл хүргэж, нийгмийн үзэл бодлыг хэлбэршүүлэгч, чиглүүлэгч чиг үүрэгтэй хэвлэл мэдээллийн ажилтнууд, сэтгүүлчид өөрсдөө үнэн зөв мэдээлэл ойлголтгүй байгаагийн улмаас буруу мэдээлэл, ойлголтыг түгээж, ЛГБТ хүмүүсийн нөхцөл байдалд сөргөөр нөлөөлж байна хэмээн дүгнэж болохоор байна.

Тиймээс хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь бэлгийн цөөнхийн асуудлаар нийтэлж, нэвтрүүлэхдээ нэр томъёоноосоо эхлэн анхаарах шаардлага урган гарч байна. Тухайлбал, нэр томъёоны хувьд лесбиян, гей, бисексуал, трансжэндэр хүмүүсийн тухай мэдээлэхдээ хэвлэл мэдээллийн хэрэгсэл монгол хэлнээ нэн

⁵ Энэхүү судалгаа англи хэл дээр байдаг ба бүрэн эхтэй нь танилцахыг хүсвэл info@lgbtcentre.mn хүсэлтээ илгээнэ үү.

сөрөг утгатай болсон “гомо” хэмээх үгийг хэрэглэж буйгаа зогсоох нь эхний нэн чухал алхам болох юм. Дараах хүснэгтэд одоо хэвлэл мэдээллээр хэрэглэдэг буруу үгс, тэдгээрийг зүгшрүүлсэн үгсийн жагсаалт, мөн ойлголтуудыг олж үзээд, зөв зүйтэй үг хэллэг, ойлголтыг ашиглахыг Монголын ЛГБТ олон нийт хэвлэл мэдээллийн ажилтнуудад уриалж байна.

ЛГБТ хүмүүсийн тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлдэг буруу ташаа зүйлс ба буруу үг хэллэг	ЛГБТ хүмүүсийн тухай хэвлэл мэдээллээр мэдээлэхдээ хэрэглэвэл зохих үг хэллэг, ойлголт
<i>Гомо, лесби</i>	Эмэгтэй ижил хүйстнүүд өөрсдийгөө лесбиян, эрэгтэй ижил хүйстнүүд өөрсдийгөө гей, аль аль хүйст хандсан бэлгийн чиг баримжаатай хүмүүс өөрсдийгөө бисексуал гэдэг.
<i>Эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд бол гомо байдаг</i>	Эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд бүгд гей байдаггүй. Бэлгийн зан үйлээр аваад үзвэл гей хүмүүс эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн тоонд багтах хэдий ч, эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог бүх эрэгтэйчүүд өөрсдийгөө гей эсвэл бисексуал бэлгийн чиг баримжаатай гэж тооцдоггүй. Гей эсвэл бисексуал эрэгтэй хүмүүс өөрсдийнхөө бэлгийн чиг баримжааг уахмсарласан, өөртөө хүлээн зөвшөөрсөн, нийгэмшихдээ ч өөрсдийгөө гей эсвэл бисексуал хэмээн тодорхойлдог. Тийм ч учраас анагаах ухаанд эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүдийг гей хүмүүсээс ялгах үүднээс MSM буюу ЭБЭ хэмээн тодорхойлсон байдаг. ЭБЭ бол зан үйл. Гей эсвэл бисексуал байх нь зан үйлээс гадна бусад шинж төрхийг агуулсан цогц ойлголт.
<i>Бэлгийн чиг хандлагаа сонгодог. Хормойн донтонгууд. Гаж донтонгууд. Сэтгэл мэдрэлийн өвчтэй юмнууд. Нийгмийн хог шаар.</i>	Бэлгийн чиг баримжаа гэдэг нь ижил эсвэл эсрэг хүйсийн хүмүүст, эсвэл аль аль хүйсийн хүмүүст сэтгэл зүрх, оюун ухаан болон бэлгийн хувьд татагдах хүний мөн чанарын төрөлхийн үзэгдэл юм. Хүн өөрийн бэлгийн чиг баримжааг сонгодоггүй. Эхийн хэвлийд үр хөврөл бүрэлдэж эхлээд өнчин тархи бүрэлдэж эхлэхэд хүний бэлгийн чиг баримжаа тогтдог ба төрөлхийн учир түүнийгээ өөрчилж чаддаггүйг олон орны эрдэмтэд нотолжээ. Харин хүмүүс өөрийн бэлгийн чиг баримжааг илэрхийлж ч болдог, үгүй ч байж болдог. Бэлгийн чиг баримжаа хүн бүрийн сэтгэлзүйн нэг хэсэг учир үүнийг сэтгэлзүйн өвчин, эмгэг хэмээн тооцдоггүй. ЛГБТ хүмүүс бусадтай адил хүмүүс.
<i>Манин</i>	Хүйсийн чиг баримжаа гэдэг нь хүн өөрийгөө эмэгтэй, эсвэл эрэгтэй гэж мэдрэх мэдрэхүй ба тэр мэдрэхүйгээ илэрхийлж

	<p>буй байдал юм. Ийм мэдрэхүй, илэрхийлэмжтэй хүмүүс өөрсдийгөө трансжэндэр гэдэг. Трансжэндэр хүмүүс ямар ч бэлгийн чиг баримжаатай байж болдог.</p> <p>Харин манин гэдэг нь аль аль хүйсийн анхдагч ба хоёрдагч шинж тэмдгийг зэрэг агуулсан хүмүүсийг хэлдэг. Шинжлэх ухааны олон улсын хэлээр тэдгээр хүмүүсийг интерсекс хүмүүс гэдэг. Энэхүү байдал нь маш ховор үзэгдэл. Монголд “манин” хэмээн хэлж заншсан хүмүүсийн ихэнх нь трансжэндэр хүмүүс байдаг.</p>
<p><i>Гомочууд ДОХ тарааж байна.</i></p>	<p>ХДХВ-ын халдвар авсан хүн болгон ДОХ-той байна, эсвэл ДОХ-той болно гэсэн үг биш. ХДХВ-ын халдвар гарцаагүй ДОХ-д хүргэнэ гэсэн аксиом үгүй. Зарим тохиолдолд ХДХВ-ын идэвхжлээс хамааран тухайн хүн ДОХ-той болох буюу өвчний үедээ шилжиж болдог.</p> <p>ХДХВ/ДОХ нь алагчилдаггүй өвчин. Хамгаалалтгүй бэлгийн хавьталд орж буй бүх хүн эрсдэлтэй зан үйл хийж байдаг. Ихэнхдээ ХДХВ/ДОХ-ын илрэл эхлээд гей хүмүүсийн дунд илэрдэг ч, ХДХВ/ДОХ-той амьдарч буй гей хүмүүсийг ХДХВ/ДОХ-той амьдарч буй эсрэг хүйстэн хүмүүстэй харьцуулахад эсрэг хүйстэн хүмүүсийн тоо нь хамаагүй илүү байдаг нь олон арван жилийн турш гадаадын орнуудад харагдсан.</p> <p>Гей хүмүүс бэлгийн зан үйлээр эрсдэлтэй зан үйл болох шулуун гэдсээр хавьтдаг гэсэн ойлголт олны дунд зонхилдог ч, жишээ нь АНУ-д шулуун гэдсээр хавьтдаг гей хүмүүс маш цөөн байдаг гэсэн судалгаа гарсан байна.</p>

ХДХВ/ДОХ-той амьдарч буй хүмүүс

“Зөвхөн эрэгтэй, эмэгтэй хүмүүс болон хүүхдүүд л халдвар авах эрсдэлтэй” гэсэн мэдээллийн лозунг 90-ээд онд АНУ-д хэрэгжүүлсэн байдаг. Энэ нь ХДХВ-ын халдвар хэнийг ч ялгагдаггүйг хүмүүсийн ухамсарт суулгасан мессеж байсан юм. Хэн ч ХДХВ-ын халдвар авч болно. Зөвхөн өөрөөс хамаарах үйлдэл буюу хамгаалалтгүй бэлгийн хавьтлаас гадна бусдын буруутай, хариуцлагагүй үйлдлээс буюу эмнэлгийн бүрэн ариутгагдаагүй багаж хэрэгсэл, цус цусан бүтээгдэхүүн, аз туршсан үйлдлээс буюу эхээс урагт ХДХВ-ын халдвар дамжиж болдог.

“Өвчин хэлж ирдэггүй, хийсч ирдэг” гэдэг зүйр үгээ мартаад, ХДХВ-ын халдвартай амьдарч буй хүмүүсийг өвчний золиос гэдгийг нь үл ажраад гэмт хэрэгтэн мэт хэвлэл мэдээллээр тэднийг шүүн таслаж, сөргөөр дүрсэлсээр байна. “Ганцхан удаа бэлгэвчгүй хавьтаад

амьдрал нь орвонгоороо эргэжээ, та ч болгоомжилж өөрийгөө болон хайртыгаа хамгаал” гэсэн бүтээлч мессеж түгээхийн оронд хэвлэл мэдээллийн хэрэгслээр ХДХВ/ДОХ-той амьдарч буй хүмүүсийн замбараагүй бэлгийн амьдралыг гайхан шагширдаг. Цаашлаад шинээр ХДХВ-ын халдвар илэрсэн тохиолдолд тухайн хүний нэрийг л хэлэхгүй боловч бусдыг нь хэлж, хувийн нууцыг задруулан хэвлэл мэдээллээр мэдээлдэг. Энэ нь халдвар авсан хүмүүс ажлаа алдах, гэр орноосоо хөөгдөх, бусдад үг хэлээр доромжлуулах, бие махбодоор хохирох үүд хаалгыг нээдгийг байнга санах ёстой. Анхны ХДХВ-ын халдвар авсан эмэгтэй дээрх бүх явдлыг биеэр туулж, хүний эрх нь дэндүү зөрчигддөг байсныг хэвлэл мэдээллийн хариуцлагагүй үйлдлээс үүдэлтэй хэмээн тэрээр ярьсан байдаг.

<p>ХДХВ/ДОХ-той амьдарч буй хүмүүсийн тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлдэг буруу ташаа зүйлс</p>	<p>ХДХВ/ДОХ-той амьдарч буй хүмүүсийн тухай хэвлэл мэдээллээр мэдээлвэл зохих зүйлс</p>
<p><i>Замбараагүйдээ өвчин авсан</i></p>	<p>Хамгаалалтгүй бэлгийн хавьталд орвол нэг удаагийн хавьтлаар ч ХДХВ-ын халдвар авч болдог.</p>
<p><i>Гомочууд ДОХ тарааж байна.</i></p>	<p>ХДХВ-ын халдвар авсан хүн болгон ДОХ-той байна, эсвэл ДОХ-той болно гэсэн үг биш. ХДХВ-ын халдвар гарцаагүй ДОХ-д хүргэнэ гэсэн аксиом үгүй. Зарим тохиолдолд ХДХВ-ын идэвхжлээс хамааран тухайн хүн ДОХ-той болох буюу өвчний үедээ шилжиж болдог.</p> <p>ХДХВ/ДОХ нь алагчилдаггүй өвчин. Хамгаалалтгүй бэлгийн хавьталд орж буй бүх хүн эрсдэлтэй зан үйл хийж байдаг. Ихэнхдээ ХДХВ/ДОХ-ын илрэл эхлээд гей хүмүүсийн дунд илэрдэг ч, ХДХВ/ДОХ-той амьдарч буй гей хүмүүсийг ХДХВ/ДОХ-той амьдарч буй эсрэг хүйстэн хүмүүстэй харьцуулахад эсрэг хүйстэн хүмүүсийн тоо нь хамаагүй илүү байдаг нь олон арван жилийн турш гадаадын орнуудад харагдсан.</p> <p>Гей хүмүүс бэлгийн зан үйлээр эрсдэлтэй зан үйл болох шулуун гэдсээр хавьтдаг гэсэн ойлголт олны дунд зонхилдог ч, жишээ нь АНУ-д шулуун гэдсээр хавьтдаг гей хүмүүс маш цөөн байдаг гэсэн судалгаа гарсан байна.</p>
<p><i>Хамгаалалтгүй байсан ч тавиагүй л бол аюулгүй</i></p>	<p>Шулуун гэдэс, үтрээний орчинд орсон л бол эрэгтэй хүн дур тавих үгүйгээс үл хамааран халдвар авах боломжтой. Харин эмэгтэй хүмүүс эрэгтэй хүнийг тавиагүй болохоор халдвар авахгүй гэж боддог нь бас л буруу. Учир нь үрийн шингэн үл ялиг ялгарсан байсан ч хэрэв хавьтагч ХДХВ-ын халдвартай байвал халдвар авах боломжтой.</p>
<p><i>Амаар хамгаалалтгүй бэлгийн хавьталд орох нь аюулгүй.</i></p>	<p>Хамгаалалтгүйгээр үтрээнээс ялгарах шингэн, үрийн шингэнтэй харьцаж л байвал халдварын эрсдэл бий.</p>
<p><i>ДОХ-той хүмүүс хохь нь, шангаа хүртэж байгаа юм.</i></p>	<p>Хэн ба юу байхаас үл хамааран хэн ч өвчинд нэрвэгдэж болно. Хэн нэгэн хавдартай хүнд “хохь чинь, шангаа хүрт” гэж хэлвэл хуншгүйгээрээ гайхагдах мөртлөө яагаад ХДХВ-ын халдвар авсан хүмүүсийг ийн үг хэлээр дайрч болно гэж үздэг вэ гэсэн асуудлыг дэвшүүлж, хүмүүст ойлгуулах ёстой. Учир нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулаад байгаа энэхүү үл тэвчсэн байдал нь ХДХВ-ын халдвартай хүмүүсийн хүний эрх ноцтой зөрчигдөх үндэс суурийг тавьж, тэдний эсрэг гарч буй алагчлалыг энгийн хэм хэмжээ мэт болгож байдаг.</p>

Цаашлаад одоогийн байдлаар Монгол Улсад ХДХВ-ын халдвартай эрэгтэйчүүдийн үнэмлэхүй хувь нь гей залуучууд, эсвэл эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд байдгаас ХДХВ/ДОХ-ыг тэдний л өвчин мэт ярьж, мэдээлж байгаа нь дэндүү өрөөсгөл ба нийгэмд хамгаалалттай бэлгийн хавьтал чухал бус гэсэн мессежийг түгээж байна гэж дүгнэж болохуйц байна.

Биеэ үнэлэгч эмэгтэйчүүд

Нийгэм эдийн засгийн хүн хүчир байдал, боловсрол нимгэн, амьдрал ахуйгаа хангах бололцоо дутмагаас үүдэн хүмүүс, ялангуяа эмэгтэйчүүд биеэ үнэлэхэд хүрдэг. Тиймээс биеэ үнэлэх үзэгдэл нь ёс суртахууны хэм хэмжээний хүрээнд бус, нийгэм эдийн засгийн эрх тэгш бус байдлын хүрээнд авч үзэх ёстой асуудал байдаг. Гэтэл үүнийг эрхзүйн патерналист үзэл буюу нийгмийн ёс суртахууныг хамгаалах ёстой хэмээх хэн юуг тодорхойлоод байгаа нь мэдэгдэхгүй тодорхойлолт, эмэгтэй хүн бүр зөвхөн нэг эр хүнд хамаарах ёстой гэсэн эцгийн эрхт үзлийн үүднээс тайлбарлаж мэдээлэх нь үнэхээр учир дутагдалтай. Эцгийн эрхт ёсны үзэл баримтлалаар эмэгтэй хүн бүр хэн нэгэн эр буюу эцэг, эсвэл нөхөр, эсвэл ах, эсвэл том хүүгийнхээ хараа хяналтад байж, тэднийхээ үгэнд багтсан үйлдэлтэй байх ёстой гэсэн бичигдээгүй зарчим эмэгтэйчүүдийн өөрөө өөрийнхөө амьдралыг чиглүүлэх, тодорхойлох, шийдвэр гаргах эрх мэдэлд саад тотгор учруулдаг. Энэхүү эцгийн эрхт ёсны зарчмууд тодорхой нийгэм, иргэншил, аж ахуйн онцлог цаг үетэй холбоотой үүссэн байсан ба тухайн үедээ хүмүүсийн харилцааг ийн зохицуулах боломжтой байсан биз. Гэтэл орчин үеийн техник технолог хөгжсөн өнөө үед эдгээр зарчим нь үеэ өнгөрөөсөн, орчин цагийн ахуй, нийгмийн харилцаанд, хамгийн чухал нь хүний эрхэд үл нийцэх зарчим болон хувирчээ. Хэрэв нийгэм эдийн засгийн байдлаар өөр хэлбэрээр амьдрал ахуйгаа залгуулах боломжгүй байгаа бол биеэ үнэлэгч хүмүүсийн ажил хөдөлмөрөө чөлөөтэй сонгох, аргагүй байдлаас сонгож буй эрхийг нь хүндэтгэх, хөдөлмөрийн нөхцлийн аюулгүй байдлыг нь хангах үүргийг төр хүлээж, хэвлэл мэдээллийн хэрэгсэл түүнийг нь хүний эрхийн асуудлын хүрээнд авч үзэх цаг ирсэн. Эрхзүйн патерналист үзлээс үүдэн биеэ үнэлэхийг эрүүгийн зүйл анги

болгосон байдлаас үүдэн биеэ үнэлэгч эмэгтэйчүүд үг хэлээр доромжлуулах, бие махбод, бэлгийн хувьд, цаашлаад амь насаараа хохирох, хил дамнасан хүний наймааны гэмт хэргийн золиос болох гээд олон төрлийн эрх нь зөрчигдөх үндэс суурь болдог. Энэ болгоныг шинэ, хүнлэг ба хүний эрхийг дээдэлсэн хүрээнд авч үзэх цаг болсон.

Нэр томъёоны тайлбар

Гомдол гаргах процесс (Communication procedure)

Дэлхийн улс орнуудын аль ч цэгт гарсан хүний эрхийн ноцтой болон ужиг зөрчлийн талаарх гомдлыг хүлээн авч шалгах процесс. Гомдол хүлээн авч хянан шалгах эрхийг ХЭЗ-ийн ихэнх Тусгай хэрэгслүүд, зарим Гэрээний хороод эдэлдэг.

Гэрээний хороод (Treaty bodies)

Хүний эрхийн гол гол олон улсын гэрээнүүдийн хэрэгжилтэд хяналт тавих үндсэн үүрэг бүхий, бие даасан шинжээчдээс бүрдсэн байгууллага

Дүгнэх ажиглалт (Concluding observations)

Гишүүн улсуудаас шилжүүлсэн эхний болон ээлжит илтгэлүүдийг хэлэлцээд Гэрээний хорооноос гаргадаг, дүгнэлт, зөвлөмж бүхий баримт бичиг

Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг (UPR) НҮБ-ын гишүүн бүх улсуудынхаа хүний эрхийн үүрэг, амлалтынх нь биелэлт, хүний эрхийн төлөв байдлыг үнэн бодит мэдээлэлд үндэслэн дүгнэлт хэлэлцүүлгийг 4 жил тутамд хийдэг ХЭЗ-ийн тусгай механизм юм.

UPR-ийн Ажлын хэсэг

Ажлын хэсэг нь UPR-ийг гардан явуулдаг. Өөрөөр хэлбэл UPR-т орж байгаа улсын хүний эрхийн төлөв байдлыг 3 цагийн турш авч хэлэлцэн, зөвлөмж, дүгнэлт гаргадаг үйл явц. Ажлын хэсэгт Хүний эрхийн зөвлөлийн 47 улс оролцоно. Ажлын хэсгийн хурадаанаас гардсан шийдвэрийг Хүний эрхийн зөвлөлийн бүгд хуралдаанаар хэлэлцэн батлана.

UPR-ийн Үндэсний илтгэл

UPR-т орж буй улсын Засгийн газрын бэлтгэн ирүүлсэн хүний эрхийн төлөв байдлыг илтгэл. Үндэсний гэж нэрлэсэн учир нь илтгэлийг бэлтгэхэд үндэснийхээ хэмжээнд холбогдох бүх талуудтай өргөөнөөр зөвлөлдөхийг НҮБ-ийн Хүний эрхийн зөвлөлийн тогтоолд зөвлөмжилсэн байдаг.

Тодорхой эрхийн чиглэлээр олгогдсон мандат (Thematic mandate)

Зөвхөн тодорхой эрхийн чиглэлээр, тухайлбал, орон байрны эрхийн чиглэлээр дэлхийн улс орнуудын хаана ч ажиллуулахаар ХЭЗ-ийн Тусгай хэрэгслүүдэд олгосон мандат. Энэ төрлийн мандатын тоо одоогоор 31 байна.

UPR-ийн Гурвал илтгэгч (troika)

Ажлын хэсгийн хуралдааныг удирдан явуулах, ажлын хэсгийн илтгэлийг бэлтгэх үүрэг бүхий илтгэгч нар. 3 илтгэгчийг (Гурвал) Хүний эрхийн зөвлөлийн гишүүдийн дундаас шодох аргаар сонгоно. Гурвал нь Ажлын хэсгийн хуралдааны үеэр хэлэлцүүлэгт орж буй улсад тавигдах асуулт болон хэлэлцэх асуудлуудыг урьдчилан бэлтгэж болно. Хүний эрхийн дээд комиссарын газар нь Гурвалыг шаардлагатай тусламж, мэдээллээр хангах үүрэг хүлээнэ.

Тодорхой улсын чиглэлээр ажиллахаар олгогдсон мандат (Country mandate)

Зөвхөн тодорхой улс оронд, бүх эрхийн салбарт ажиллуулахаар ХЭЗ-ийн Тусгай хэрэгслүүдэд олгосон мандат. Энэ төрлийн мандатын тоо 8 байна.

Тусгай хэрэгсэл (Special procedures)

“Тусгай хэрэгсэл” нь хуучин Хүний эрхийн Комиссоос байгуулагдан өдгөө Хүний эрхийн зөвлөлд уламжлуулан шилжүүлсэн, улс оронд үүссэн тодорхой асуудлаар, эсвэл сэдэвчилсэн асуудалд анхаарч ажилладаг механизмын ерөнхий нэр. Нэг болон бүлэг этгээдүүд ХЭЗ-ийн Тусгай хэрэгслээр ажиллаж болох ба Тусгай илтгэгч, Хараат бус шинжээч, Ажлын хэсэг гэх мэт өөр өөр нэртэй байж болно.

Хүний эрхийн дээд комиссар - ХЭДК

1993 онд бий болсон бөгөөд ХЭДКГ-ыг тэргүүлдэг, НҮБ-ын хүний эрхийн асуудал хариуцсан гол албан тушаалтан

Хүний эрхийн дээд комиссарын газар – ХЭДКГ (ОНСНР)

Хүн бүрт, бүх эрхийг нь эдлүүлэх, хамгаалах, хөхиүлэн дэмжихийн тулд НҮБ-ын дүрмээр олгогдсон өвөрмөц мандат бүхий газар. НҮБ-ын хүний эрхийн механизмууд болох ХЭЗ, Тусгай хэрэгслүүд, Гэрээний хороодын өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

Хүний эрхийн зөвлөл- ХЭЗ (HRC)

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 2006 оны 3 сарын 15-ны өдрийн 60/251 тоот шийдвэрийн үндсэн дээр, 60 гаруй жилийн хугацаанд НҮБ-ын хүний эрхийн асуудлыг хариуцан ажилласан НҮБ-ын Хүний эрхийн комиссын оронд хүний эрхийн асуудлыг хариуцан ажиллахаар байгуулагдсан НҮБ-ын Засгийн газар хоорондын үндсэн байгууллага

ХЭЗ-ийн Зөвлөх хороо

(Human Rights Council Advisory Committee)

ХЭЗ-ийн үйл ажиллагааны бодлого, чиглэлийг тодорхойлох үүрэг бүхий Зөвлөх Хороо нь өөрийн итгэл үнэмшлийн үндсэн дээр ажиллах 18 шинжээчдээс бүрдэж ажилладаг.

Шалгах (Inquiry)

Гэрээний гишүүн улс нь хүний эрхийг ноцтой зөрчиж буй талаарх бодитой мэдээлэл хүлээн авсан тохиолдолд тухайн улсыг дуудаж асуух, нэмэлт мэдээлэл ирүүлэхийг хүсэх, шаардлагатай тохиолдолд тухайн улсад айлчлах зэргээр хүний эрхийн зөрчлийнх нь асуудалд дүгнэлт, зөвлөмж гаргах үйл явц.

Эхний илтгэл (Initial report)

Гишүүн улсуудаас нэгдэн орсон хүний эрхийн гэрээгээрээ хүлээсэн үүргийнхээ дагуу (ихэвчлэн 1-2 жилийн дараа) тухайн чиглэлийн хүний эрхийн төлөв байдлынхаа талаар бэлтгэн Гэрээний хорооны руу шилжүүлдэг анхны илтгэл

Ээлжит илтгэл (Periodic report)

Гишүүн улсуудаас нэгдэн орсон хүний эрхийн гэрээгээрээ хүлээсэн үүргийнхээ дагуу эхний илтгэлээ шилжүүлсний дараа Гэрээний хорооны хүссэн үед (ихэвчлэн 4-5 жилийн дараа) тухайн чиглэлийн хүний эрхийн төлөв байдлынхаа талаар бэлтгэн Гэрээний хорооны руу шилжүүлдэг тогтмол илтгэл

Яаралтай захидал (Urgent appeals or letters of allegation)

Хувь этгээдээс хүний эрхийн зөрчлийн талаар ирүүлсэн гомдлыг хүлээн аваад ХЭЗ-ийн Тусгай хэрэгслүүд тодруулга авахаар холбогдох гишүүн улс руу илгээсэн захидал

Хаяг: ГЛОБ ИНТЕРНЭШНЛ ТББ
Чингэлтэй дүүрэг VI хороо, Эрх чөлөөний талбай,
Дипломат 95 цогцолбор, 1-р орц 6 тоот
Улаанбаатар хот 211238, ш/х 102
Утас: 976-11-324627, 976-11-324764
Факс: 976-11-315326
И-майл: hnanan@globeinter.org.mn,
globenews@globeinter.org.mn
Вэб сайт: www.globeinter.org.mn
www.upr-mongolia.mn